



МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН
МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ

2020

ЖИЛИЙН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН
МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ

2020

ЖИЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	7
2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ	8
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ	11
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА	13
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	14
 БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛС ФАТФ-ЫН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ УЛС ОРНУУДЫН ЖАГСААЛТААС ГАРСАН ТУХАЙ	 20
1.1. ФАТФ-ын хяналтаас гарах ажлын төлөвлөгөөний биелэлт	20
1.2. Санхүүгийн мэдээллийн албанаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	25
1.3. ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтыг зохион байгуулсан тухай	27
1.4. Монгол Улс ФАТФ-ын саарал жагсаалтаас гарсан тухай	33
1.5. Монгол Улс Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас гарсан тухай	43
 БҮЛЭГ 2. МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ	 50
2.1. Мэдээлэл цуглуулах	50
2.2. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх	51
2.3. Мэдээлэл солилцох	53
2.3.1. Дотоодын байгууллагатай мэдээлэл солилцох	53
2.3.2. Гадаадын байгууллагатай мэдээлэл солилцох	54
 БҮЛЭГ 3. ДОТООД БА ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА	 58
3.1. Дотоод хамтын ажиллагаа.....	58
3.1.1. Үндэсний зөвлөл	58

3.1.2. Хамтын ажиллагааны зөвлөл	65
3.2. Гадаад хамтын ажиллагаа	72
3.2.1. ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг болон Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг	72
3.2.2 Эгмонт бүлэг	76
3.2.3. Харилцан ойлголцлын санамж бичиг	77
3.2.4 Олон улсын хамтын ажиллагаа	78
БҮЛЭГ 4. ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	82
4.1. Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудад хийсэн сургалт, семинар.....	83
4.2. Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын хамрагдсан сургалт, семинар	85
4.3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа	87
БҮЛЭГ 5. МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН БҮТЭЦ	94
5.1. Санхүүгийн мэдээллийн албаны дотоод мэдээллийн систем	94
5.2. goAML программ хангамж	95
БҮЛЭГ 6. ҮНДЭСНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	100
БҮЛЭГ 7. ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИК ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	108
БҮЛЭГ 8. ХЯНАЛТ ШАЛГАЛТ	116
8.1. Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хийсэн хяналт шалгалтын тоо, цар хүрээ	116
8.2. Хяналт шалгалттай холбоотой боловсруулсан баримт бичиг	119
8.3. Техник тусалцаа ба хүрч ажиллах, соён гэгээрүүлэх, чадавхыг бэхжүүлэх	119
8.4. Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хийгдэх хяналт шалгалтыг сайжруулах нь.....	120
ХАВСРАЛТ	121

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БМГТ	Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан
ГТТГТ	Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МУТС	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх
СББМҮҮ	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
ҮЗ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
ХАЗ	Хамтын ажиллагааны зөвлөл

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Дотоод хамтын ажиллагааны байгууллагын гишүүд	22
Зураг 2.	Ази, Номхон далайн хамтарсан бүлэгтэй хийсэн цахим уулзалт /2021.05.11/	23
Зураг 3.	Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн цахим хурал	24
Зураг 4.	ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын нээлт /2020.10.01/	28
Зураг 5.	ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын үеэр /2020.10.02/	29
Зураг 6.	ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын хаалтын уулзалт /2020.10.02/	30
Зураг 7.	ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын хаалтын уулзалт /2020.10.02/	31
Зураг 8.	Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн цахим уулзалт /2020.10.13/	33
Зураг 9.	Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албанаас Европын холбооны төлөөлөлтэй хийсэн уулзалт /2020.05.14/	43
Зураг 10.	Гаалийн мэдүүлгийн тоо	50
Зураг 11.	Хүлээн авсан сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийсэн сэжигтэй гүйлгээний тоо	51
Зураг 12.	Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн Сэжигтэй гүйлгээний тайлан, сэжиглэх үндэслэлээр	52
Зураг 13.	Санхүүгийн мэдээллийн албаны дотоодын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцсон байдал	53
Зураг 14.	Хамтын ажиллагааны гишүүн байгууллагуудын албан тушаалтнуудад шагнал гардуулах ёслол	65
Зураг 15.	Хамтын ажиллагааны гишүүн байгууллагууд	66
Зураг 16.	Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдсан байдал /2020 он/	71
Зураг 17.	Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайлан	75
Зураг 18.	Монголбанкны удирдлагууд АНУ-ын элчин Сайд Майкл С.Клеческийг хүлээн авч уулзав. /2020.04.29/	79
Зураг 19.	Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2017-2020/	82
Зураг 20.	Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2017-2020/	83
Зураг 21.	Бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2017-2020/	83
Зураг 22.	Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хамрагдсан гадаад, дотоод сургалт, семинарын мэдээлэл	85
Зураг 23.	Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудас fiu.mongolbank.mn	87
Зураг 24.	Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай мэдээллийн нэгдсэн систем www.amlcft.mn	88
Зураг 25.	Санхүүгийн мэдээллийн албаны дотоод мэдээллийн системийн бүтэц	94
Зураг 26.	goAML вэб портал	95
Зураг 27.	goAML системийн бүдүүвч зураг	96
Зураг 28.	goAML тайлан хүлээн авах хуудас	97
Зураг 29.	Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх бүдүүвч зураглал	101
Зураг 30.	Үндэсний эрсдэлийн үнэлгээний ач холбогдол	102
Зураг 31.	Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх үе шатууд	102
Зураг 32.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний хэлэлцүүлэг /2020.10.26-30/	103
Зураг 33.	Үндэсний Хөтөлбөр, Стратегийг батлуулж хэрэгжүүлэх тухай	104
Зураг 34.	Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн цахим чуулга уулзалт /2020.07.22/	108
Зураг 35.	Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	117

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Монгол Улсын авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	20
Хүснэгт 2.	ФАТФ-ын Монгол Улсад хийсэн газар дээрх хяналт шалгалтад оролцсон алба тушаалтнууд	29
Хүснэгт 3.	ФАТФ-ын саарал жагсаалтаас Монгол Улсыг гаргах ажилд олон улсын байгууллагуудаас үзүүлсэн дэмжлэг, туслалцааны мэдээлэл	32
Хүснэгт 4.	Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн гүйлгээний тоо	50
Хүснэгт 5.	Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлан	52
Хүснэгт 6.	Санхүүгийн мэдээллийн албаны гадаадын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцсон байдал	54
Хүснэгт 7.	Эгмонт бүлгийн гишүүн гадаадын Санхүүгийн мэдээллийн албадуудтай мэдээлэл солилцсон байдал	76
Хүснэгт 8.	Бусад орны Санхүүгийн мэдээллийн албануудтай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн жагсаалт	77
Хүснэгт 9.	Дэлхийн банкны зөвлөхүүдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний цахим сургалт хийсэн хуваарь	78
Хүснэгт 10.	Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын сургалт, семинарт хамрагдсан байдал хуваарь	85
Хүснэгт 11.	ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээний өөрчлөлт	109
Хүснэгт 12.	Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээ	110
Хүснэгт 13.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа	117
Хүснэгт 14.	Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хийсэн хяналт шалгалтын статистик мэдээлэл /2020 он/	118

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн ажиллах журам	121
Хавсралт 2.	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө	126
Хавсралт 3.	Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн болон үр дүнтэй байдлын үнэлгээний цаг хугацааны матриц (2007-2020).....	131
Хавсралт 4.	Англи нэр томъёоны тайлбар	135

2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

01 дүгээр сарын 17

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хуулийн хамрах хүрээг өргөжүүлэв. Ийнхүү санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдээс Санхүүгийн мэдээллийн албанд хуульд заасан гүйлгээ, тайланг мэдээлэх хууль, эрх зүйн орчин бүрдэв.



01 дүгээр сарын 20

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг болон Ази, Номхон далайн хамтарсан бүлгийн хурал 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулагдав. Монгол Улс 2019 оны 10 дугаар сард ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу "Саарал жагсаалт"-д орсноос хойш ажлын төлөвлөгөөний биелэлтийн анхны тайланг БНХАУ-ын Бээжин хотод хамгаалав.



01 дүгээр сарын 31

Монгол Улсын 2 дахь удаагийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний

эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны техник туслалцаатайгаар хийж гүйцэтгэх ажлыг эхлүүлэв. Энэхүү ажлын хүрээнд Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг Сангийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар тушаалаар байгууллаа.



02 дугаар сарын 01

ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийн үнэлгээг ахиулах хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлуудыг багтаасан Монгол Улсын 2020 оны Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн.

02 дугаар сарын 03

Санхүүгийн мэдээллийн албаны бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэж, Үйл ажиллагааны болон Бодлого хэрэгжилт, хамтын ажиллагааны гэсэн 2 хэлтэстэй болж өргөжсөн. Үүний дүнд Санхүүгийн мэдээллийн албаны хүний нөөц болон хүчин чадал хоёр дахин нэмэгдсэн.



02 дугаар сарын 21

ФАТФ-ын ээлжит чуулга уулзалт БНФУ-ын Парис хотод зохион байгуулагдав. Уг хурлаар Монгол Улсын төлөөлөл ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарах чиглэлээр хийгдэж буй ажлуудыг эрчимжүүлж, ФАТФ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын 50 хувийг биелүүлсэн талаар мэдээлэв.

3 дугаар сарын 05

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2020 оны 02 дугаар сард хүргүүлсэн Монгол Улсын 2020 оны Явцын тайлантай холбоотой нэмэлт тайлбар, мэдээллийг хариуцсан байгууллагуудаас нэгтгэн авч, шинэчилсэн байдлаар хүргүүлэв.

3 дугаар сарын 19

Ковид-19 цар тахлын улмаас Монгол Улс ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн эрчимтэй хяналтаас гарах ажлыг хойшлуулахгүй байх үүднээс Сангийн сайд болон Монголбанкны Ерөнхийлөгч ФАТФ-ын Ерөнхийлөгчид хандан албан хүсэлт хүргүүлсэн. Үүний үр дүнд Монгол Улсын тайлагнах хугацааг хойшлуулахгүйгээр хэвээр үргэлжлүүлэх боломжтой болов.

ОНЦЛОХ 20



3 дугаар сарын 27

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу мэдээлэл хүлээж авах үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, улмаар мэдээлэх үүрэгтэй бүх этгээдэд зориулсан нэгдсэн порталтай болох ажлыг эхлүүлсэн. Энэ хүрээнд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газраас олон улсад өргөн ашиглагддаг goAML програмыг АНУ-ын Сангийн яамны техник туслалцаатайгаар 2020 оны 3 сараас эхлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж эхлэв.

4 дүгээр сарын 13

Монгол Улсыг ФАТФ-ын эрчимжүүлсэн хяналтаас гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгээс үлдсэн 3 үүрэг даалгавар буюу Шууд хэрэгжилт 3, 7, 11-ийн хүрээнд хийсэн ажлуудын биелэлтийг Ахицын тайланд тусган хүргүүлсэн. Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран уг тайланг нэгтгэн боловсруулж, 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Ази, Номхон далайн хамтарсан бүлэгт хүргүүлсэн.

20 ҮЙЛ ЯВДАЛ

4 дүгээр сарын 27

Үндэсний эрсдэлийн үнэлгээний дэд ажлын хэсгүүдийг Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дугаартай тушаалаар байгуулсан. Нийтдээ 10 дэд ажлын хэсэг банк, үнэт цаас, даатгал зэрэг салбар тус бүрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэж эхлэв. Дэд ажлын хэсгүүдэд төр болон хувийн хэвшлийн 52 байгууллагын 128 гаруй төлөөлөгчид орж ажиллав.



5 дугаар сарын 11

Монгол Улсыг ФАТФ-ын Саарал жагсаалтаас гаргах үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Ази, Номхон далайн хамтарсан бүлэгт тайлагнах цахим уулзалтыг 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Их тэнгэр цогцолборт зохион байгуулсан. Уг хуралд нийт 20 гаруй байгууллагуудын төлөөлөл оролцсон бөгөөд Монгол Улсын Ахицын тайланг танилцуулж, амжилттай хамгаалав.

5 дугаар сарын 28

Санхүүгийн мэдээллийн албаны албан ёсны цахим хуудас <https://fiu.mongolbank.mn/> ашиглалтад оров. Энэхүү цахим хуудсаар дамжуулан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээдэг боллоо.



5 дугаар сарын 29

Монгол Улсын “Саарал жагсаалт”-аас гарах ажлын төлөвлөгөөний биелэлтийг тусгасан

Ахицын тайланг ФАТФ-ын Ази, Номхон далайн хамтарсан бүлэгт амжилттай хамгаалсан талаарх хэвлэлийн бага хурлыг Монголбанк дээр зохион байгуулав. ФАТФ-аас ирүүлсэн тайланд Монгол Улс өгөгдсөн 6 үүрэг даалгаврыг хангалттай биелүүлсэн гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд газар дээрх хяналт шалгалт хийх эсэхийг ФАТФ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэхээр болсон.

6 дугаар сарын 12

Мэдээлэх үүрэгтэй этгээдүүд болох санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан Санхүүгийн мэдээллийн албанаас “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага”-ыг боловсруулан гаргаж, холбогдох яамд, мэргэжлийн холбоод болон мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд хүргүүлэв.



6 дугаар сарын 16

ФАТФ-ын Олон Улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн цахим хуралд оролцов. Уг хуралд нийтдээ 23 улсын төлөөлөгчид хамрагдсан бөгөөд Монгол Улсын “Саарал жагсаалт”-аас гарах чиглэлээр авсан арга хэмжээний талаар хэлэлцэж, ахиц дэвшил гаргаж байгаад баяр хүргэв.



6 дугаар сарын 22

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журмын дагуу тайлан бөглөх заавар,

зөвлөмж” гарган хүргүүлэв. Мөн заавар, зөвлөмжийг Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд байршуулан нийтэлсэн.



6 дугаар сарын 30

ФАТФ-аас 2019 оны 10 дугаар сард Монгол Улсыг “Саарал жагсаалт”-аас гаргахын тулд 6 үүрэг даалгаврыг өгсөн бөгөөд амжилттай биелүүлсэн гэдгийг ФАТФ-ын цахим хуудсанд албан ёсоор нийтлэв.

7 дугаар сарын 22

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Харилцан үнэлгээний хорооны цахим хурлыг зохион байгуулав. Уг хурлаар ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийн нийт 5 зөвлөмжийн үнэлгээг ахиулж, 1 зөвлөмжийн үнэлгээг хэвээр үлдээх хүсэлт бүхий Санхүүгийн мэдээллийн албанаас хүргүүлсэн Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайланг хэлэлцэв. Уг хурлаар 3 Зөвлөмжийн үнэлгээг ахиулснаар нийт 37 зөвлөмжийн дийлэнхийг болон бүрэн биелүүлсэн үнэлгээтэй болов.

8 дугаар сарын 14

Сангийн сайдын 2020 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 151 тоот тушаалын хавсралтаар ФАТФ-ын Монгол Улсад хийх газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх төлөвлөгөө, байгууллага, албан тушаалтнуудын бүрэлдэхүүн болон зохион байгуулалтын арга хэмжээ авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Уг төлөвлөгөө болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудаас санал авч боловсруулсан. Санхүүгийн мэдээллийн албаны дарга ажлын хэсгийн нарийн бичгээр томилогдон удирдлага зохион байгуулалтыг гүйцэтгэж, газар дээрх хяналт шалгалтын бэлтгэл ажлыг хангав.

8 дугаар сарын 25

Ковид-19 цар тахлын үед ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтыг биечлэн зохион байгуулах боломжгүйн улмаас хойшлогдох нөхцөл байдал үүссэн. Гэвч төрийн дээд түвшинд ач холбогдол өгч, дээд түвшний удирдлагуудтай хамтран удаа дараа албан хүсэлт хүргүүлж, цахим уулзалт хийсний дүнд уг уулзалтыг Монгол Улсад 2020 оны 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулахаар болсон. Үүнтэй холбоотойгоор Шадар сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийг Санхүүгийн мэдээллийн албаны дарга ахалж, Ковид-19 цар тахлын онцгой нөхцөл байдалд газар дээрх хяналт шалгалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэв.

2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

9 дүгээр сарын 04

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Харилцан үнэлгээний хорооноос 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцсэн Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайланг эцэслэн батлав. Ингэснээр ФАТФ-ын техник хэрэгжилтийн 14, 28, 35 гэсэн 3 зөвлөмжийн үнэлгээг ахиулж, 1, 8 дугаар зөвлөмжийн үнэлгээг хэвээр үлдээсэн.



10 дугаар сарын 01-02

Монгол Улс ФАТФ-ын "Саарал жагсаалт"-аас гарах ажлын сүүлийн шат болох газар дээрх хяналт шалгалтыг Ковид-19 цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмийг баримтлан амжилттай зохион байгуулав. Газар дээрх хяналт шалгалтын ажил 2020 оны 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд Монгол Улсад зохион байгуулагдаж, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын нийт 140 гаруй төлөөлөгчид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр өөрсдийн хийсэн ажлаа амжилттай тайлагнаж хамгаалав.



10 дугаар сарын 13

Монгол Улсыг ФАТФ-ын "Саарал жагсаалт"-аас гаргах эсэхийг шийдвэрлэх Олон Улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн цахим хурал болов. Энэхүү хурлаар 2020 оны 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд Монгол Улсад ирж газар дээрх хяналт шалгалтыг хийсэн үнэлгээний багийн гишүүд тайлангаа танилцуулахын зэрэгцээ Монгол Улсыг саарал жагсаалтаас гаргах саналыг дэвшүүлж, хуралд оролцсон 100 гаруй орны төлөөлөгчид бүгд дэмжлээ.



10 дугаар сарын 23

ФАТФ-ын ээлжит чуулга уулзалтаар Монгол Улсыг ФАТФ-ын "Саарал жагсаалт"-аас гарсан гэдгийг зарлаж, албан ёсны мэдэгдлийг ФАТФ-ын цахим хуудсанд нийтлэв. Ингэснээр Монгол Улс бусад улс орнуудтай харьцуулахад хамгийн богино хугацаанд буюу 1 жилийн дотор уг жагсаалтаас гарч чадсан улс боллоо. Мөн дэлхий нийтээр тархсан Ковид-19 цар тахлын хүнд хэцүү цаг үед Монгол Улс "Саарал" жагсаалтаас гарах ажлыг амжилттай зохион байгуулсан нь олон улсын шилдэг туршлага болсныг ФАТФ-ын чуулга уулзалт дээр улс орнууд баяр хүргэж онцлов.



11 дүгээр сарын 10

ФАТФ-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн чуулга уулзалтаар Монгол Улсыг "Саарал жагсаалт"-аас гаргахаар шийдвэрлэснийг ФАТФ-ын Ерөнхийлөгч Доктор Маркус Плейер албан захидлаар мэдэгдэж, баяр хүргэлээ.



Нэгдүгээрт Монгол Улс "Саарал жагсаалт"-аас гарсан ажил орлоо.

12 дугаар сарын 30

Монголбанкны 2020 оны онцлох 20 үйл явдлын



11 дүгээр сарын 20

ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллага болох Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 33 дахь удаагийн ээлжит чуулга уулзалт цахим хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд Монгол Улсыг төлөөлөн Санхүүгийн мэдээллийн албаны дарга оролцлоо.



12 дугаар сарын 07

Монгол Улсыг Европын Холбооны

мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас хасах тухай тогтоолыг Европын Комиссоос гаргасан. Үүний дүнд Монгол Улс 2021 оны 01 дүгээр сард албан ёсоор Европын Холбооны жагсаалтаас гарсан.



САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Санхүүгийн мэдээллийн
албаны дарга

Б.Батбаатар

Өнгөрсөн 2020 он Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр томоохон ахиц дэвшил гаргасан, сорилт сургамжаар дүүрэн жил байлаа. Санхүүгийн мэдээллийн албаны хувьд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэлийн тэргүүлэх зорилт болох Монгол Улсыг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу "Саарал" жагсаалтаас 2020 онд багтаан гаргахад онцгой анхаарч ажиллав.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоход юуны түрүүнд төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Иймд Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын уялдаа холбоо хамтын ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгч ажиллав. Энэ хүрээнд төрийн 20 гаруй байгууллагын оролцоотой эдгээр зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулахад ахиц дэвшил гаргасан он жил байлаа. Монгол Улсыг "Саарал" жагсаалтаас гаргах ажлын хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас төр, хувийн хэвшлийн байгууллагууд болон мэргэжлийн холбоодтой идэвх зүтгэлтэйгээр хамтран ажилласны үр дүнд ФАТФ-аас өгсөн үүрэг даалгаврыг амжилттай биелүүлсэн. Ингэснээр Монгол Улс бусад улс орнуудтай харьцуулахад хамгийн богино хугацаа болох 1 жилийн дотор буюу 2020 оны 10 дугаар сард "Саарал" жагсаалтаас гарч чадлаа. Мөн дэлхий нийтээр тархсан Ковид-19 цар тахлын хүнд хэцүү цаг үед Монгол Улс "Саарал" жагсаалтаас гарах ажлыг амжилттай зохион байгуулсан нь олон улсын шилдэг туршлага болсныг ФАТФ-ын чуулган дээр улс орнууд цохон тэмдэглэж баяр хүргэсэн. Богино хугацаанд өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлж, стратегийн дутагдлаа

арилгахад улс төрийн өндөр түвшний дэмжлэг, Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын удирдлагууд болон хамтран ажиллагсдын хүчин чармайлт, дэмжлэг туслалцаа гол нөлөө үзүүлсэн. Түүнчлэн ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Дэлхийн банк, Европын Холбоо, Азийн хөгжлийн банк, Олон Улсын валютын сан, НҮБ-ын Хар Тамхи Мансууруулах Бодистой тэмцэх алба, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Сангийн Яам, Америкийн нэгдсэн улсын Сангийн яам, Бүгд Найрамдах Хятад Ардын Улсын Ардын Банк, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк, Австрали Улсын Дотоод хэргийн яам болон бусад элчин сайдын яамдууд зэрэг олон улсын донор байгууллагууд техник туслалцаа үзүүлж, үр дүнтэйгээр хамтран ажилласан.

Түүнчлэн Европын Холбооноос 2020 оны 10 дугаар сараас эхлэн Монгол Улсыг Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад оруулах шийдвэрийг 2020 оны 5 сард гаргасантай холбоотойгоор уулзалт хэлэлцээрийг төрийн холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Монгол Улсыг ФАТФ-ын жагсаалтаас гарсантай холбоотойгоор Монгол Улсыг Европын Холбооны жагсаалтаас хасах тухай тогтоолыг Европын Комиссоос 2020 оны 12 дугаар сард гаргасан. Үүний дүнд Монгол Улс 2021 оны 01 дүгээр сард албан ёсоор Европын Холбооны жагсаалтаас гарлаа.

Монгол Улсыг олон улсын байгууллагуудын жагсаалтаас гаргах чиглэлээр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэх, хяналт шалгалтад хамруулж, гаргасан зөрчилд хариуцлага ногдуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэв. Иймд Санхүүгийн мэдээллийн албанаас хяналт

шалгалтын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд холбогдох заавар зөвлөмжийг боловсруулан соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. Мөн мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой мөрдөн шалгах, яллах ажиллагааг нэмэгдүүлэх, хилээр мэдүүлээгүй эсвэл худал мэдүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх, хариуцлага тооцох, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх дотоод хамтын ажиллагааг сайжруулах, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албанаас Үндэсний болон Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд, хувийн хэвшилтэй хамтран ажиллалаа.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дэлхийн улс орнууд ФАТФ-аас гаргасан техник хэрэгжилтийн 40 зөвлөмж болон Шууд хэрэгжилтийн 11 шалгуурыг дагаж мөрдөх үүрэгтэй байдаг. Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-ын 40 Зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлуудыг багтаасан Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайланг төрийн холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлээ. Үүний дүнд нийт 3 зөвлөмжийн үнэлгээг 2020 онд ахиулснаар Монгол Улс ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээний хувьд нийт 37 Зөвлөмж дийлэнхийг болон бүрэн биелүүлсэн гэсэн үнэлгээтэй боллоо. Эдгээр ажлын хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба маань мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг олон улсын байгууллагуудад тайлагнаж, хамтран ажилласан.

Санхүүгийн мэдээллийн албаны хувьд 2020 он нэлээд өөрчлөлт шинэчлэлийг авчирсан жил байлаа. Учир нь Санхүүгийн мэдээллийн алба бүтэц, зохион байгуулалтаа өөрчилж, Үйл ажиллагааны болон Бодлого хэрэгжилт, хамтын ажиллагааны гэсэн 2 хэлтэстэй болж өргөжсөн. Улмаар хүний нөөцөө 2 дахин нэмэгдүүлэн ажилтнуудынхаа чадавхыг бэхжүүлэхэд ихээхэн анхаарлаа. Санхүүгийн мэдээллийн албаны үндсэн чиг үүргийн хүрээнд 2020 онд хүлээн авсан сэжигтэй гүйлгээний тоо өмнөх оноос 21 хувиар, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо 8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх онд нийт 84 сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийсэн бөгөөд 2020 онд энэ үзүүлэлт 6 дахин өсч, нийт 505 сэжигтэй гүйлгээний мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлжээ.

Санхүүгийн мэдээллийн албанаас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд мэдээлэл хүлээж авах үйл ажиллагаанд олон улсын дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, мэдээллийн чанар, түүнд хийх дүн шинжилгээг сайжруулах зорилгоор НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газраас гаргасан goAML програмыг 2020 онд нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж, туршилтын ажлыг амжилттай хэрэгжүүлэв.

Санхүүгийн мэдээллийн албанаас 2020 онд санаачлан хэрэгжүүлсэн томоохон ажлын нэг нь Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу Сангийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хийж гүйцэтгэсэн явдал юм. ФАТФ-ын Зөвлөмжид заасны дагуу Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нөөц бололцоог зөв хуваарилах, болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх боломж нөхцөл бүрдэнэ. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний үрдүнд үндэслэн "Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулж хэрэгжүүлэх болно.

Иймд Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс ФАТФ-ын дараагийн шатны явцын үнэлгээнд бэлтгэх, ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмж болон үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилтийн шалгуурыг хангах, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах болно. Энэ хүрээнд хамтын ажиллагаанд тулгуурлан тууштайгаар хичээл зүтгэл гарган ажиллаж, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог улам бэхжүүлэхийг зорих болно.

Энэ дашрамд, ФАТФ болон Европын Холбооны жагсаалтаас гарах, ФАТФ-ын 40 зөвлөмжийн техник хэрэгжилтийг үнэлгээг ахиулах, Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэхэд хамтран ажилласан Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн төрийн байгууллагууд, түүний удирдлагууд, мэргэжлийн холбоод, мэдээлэх үүрэгтэй этгээдүүд, олон улсын донор байгууллагууд, ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг болон гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдад чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Санхүүгийн мэдээллийн
албаны дарга

Б.БАТБААТАР



МОНГОЛБАНК
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА



Монгол Улс 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталж, 2006 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Санхүүгийн мэдээллийн албыг байгуулснаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндэс, суурийг тавьсан.


Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдээс тайлан, мэдээлэл хүлээн авах, дүн шинжилгээ хийх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилладаг. Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гадаад болон дотоодын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг олон нийтэд таниулах, хяналт тавих зэрэг хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн мэдээллийн алба нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ зүй бус хөндлөнгийн оролцоо, нөлөөллөөс ангид байж, хараат бус ажилладаг, бие даасан байгууллага юм.


ФАТФ-аас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх олон улсын стандарт болох 40 Зөвлөмжийг боловсруулан гаргасан. Дэлхийн улс орнууд эдгээр зөвлөмжийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дагаж мөрддөг. Уг стандартын Зөвлөмж 29-д Санхүүгийн мэдээллийн албаны эрхлэх үйл ажиллагааны стандартыг тодорхойлон тусгасан байдаг бөгөөд манай улсын Санхүүгийн мэдээллийн алба энэ стандарт, шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Монголбанкны дэргэд байгуулагдсан Санхүүгийн мэдээллийн алба нь олон улсын зарчим, стандартыг хэрэгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа явуулж ирсний үр дүнд олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, Эгмонт бүлэгт 2009 онд элсэн орсон. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр бусад улс орны санхүүгийн мэдээллийн албадуудтай мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

Түүнээс гадна Монгол Улс нь ФАТФ-ын бүс нутаг хариуцсан байгууллага болох Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүнээр 2004 онд элсэн орж, одоог хүртэл ФАТФ-аас гаргасан олон улсын стандартын дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо тогтмол үнэлүүлж байна.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС



Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх;



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг хуульд заасан журмын дагуу эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэх, шилжүүлсэн сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар мэдээллийн сан бүрдүүлэх;



Мэдээлэх үүрэгтэй этгээдийн сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор сэжигтэй гүйлгээнд хийсэн дүн шинжилгээний талаарх ерөнхий мэдээлэл, сэжигтэй гүйлгээний нийтлэг хэв шинж, арга хэлбэрийн талаар тогтмол мэдээлэх;



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах, сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх аргачлал боловсруулж мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;



Програмын тасралтгүй ажиллагааг хангах, сервер, компьютер, техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангах ажлуудыг удирдан зохион байгуулах;



Судалгаа шинжилгээ хийх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны статистик мэдээллийг нэгтгэн гаргах.

БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах;



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гадаад болон дотоодын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах;



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, мөн эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх;



Санхүүгийн хориг арга хэмжээний жагсаалтыг мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан Үндэсний стратеги, хөтөлбөрийг боловсруулах, уг стратегийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл, сурталчилгаа явуулах;



Санхүүгийн мэдээллийн алба болон холбогдох дотоод байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, сургалт зохион байгуулах;



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албыг хариуцах;



Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих.



БҮЛЭГ 1

МОНГОЛ УЛС ФАТФ-ЫН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ
УЛС ОРНУУДЫН ЖАГСААЛТААС ГАРСАН ТУХАЙ

”



1.1 | ФАТФ-ЫН ХЯНАЛТААС ГАРАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ФАТФ-аас 2017 онд хийсэн харилцан үнэлгээгээр Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмж болон үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилтийн дагуу үнэлж, дутагдалтай гэж дүгнэсэн. Үүнтэй холбогдуулан, Монгол Улс үнэлгээг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилласан боловч ФАТФ-аас 2019 оны 10

дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “Саарал” жагсаалтад оруулсан. Иймд Саарал жагсаалтаас гарах ажлын хүрээнд Монгол Улс 2021 оны 5 дугаар сар хүртэл авч хэрэгжүүлэх 4 Шууд хэрэгжилттэй холбоотой ФАТФ-аас өгөгдсөн нийт 6 үүрэг даалгаврыг биелүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулсан (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Монгол Улсын авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх ажил	Төлөвлөгөөт хугацаа	Хариуцах байгууллага
Шууд хэрэгжилт 3			
1	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах байгууллагын тухайн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан аргачлалаар хийж гүйцэтгэх	2021 оны 5 сар	Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах чиг үүрэг бүхий байгууллагууд (Хууль зүй, дотоод хэргийн яам: Монголын Нотариатчдын танхим, Монголын Хуульчдын холбоо; Сангийн яам: Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт)
2	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн хариуцлага оногдуулах		
Шууд хэрэгжилт 7			
3	Тодорхойлсон эрсдэлтэй уялдуулан мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, прокурорын түвшинд яллах ажиллагааг нэмэгдүүлэх	2021 оны 5 сар	Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар
Шууд хэрэгжилт 8			
4	Хилээр мэдүүлээгүй/ худал мэдүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авах	2021 оны 01 сар	Сангийн яам: Гаалийн ерөнхий газар

Шууд хэрэгжилт 11		
5	Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах	2020 оны 9 сар
6	Санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ авах үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авах	2021 оны 5 сар

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2019 оны 172 дугаар захирамжаар энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр Сангийн Сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Үүнээс гадна, 2019 оны Засгийн газрын 463 дугаар тогтоолоор ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас Монгол Улсыг гаргах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд, хувийн хэвшил болон мэргэжлийн холбоодын хамтарсан дэд ажлын хэсгүүд уг төлөвлөгөөний дагуу эрчимтэй ажилласан. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас төлөвлөгөөт ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэх чиглэлээр байгууллага тус бүртэй хамтран дэмжлэг үзүүлж ажилласан бөгөөд Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд

анхаарч, шаардлагатай бүхий л хэлэлцээр, хурал, уулзалтыг зохион байгуулж, дотоод болон гадаад хамтын ажиллагааг хангаж ажилласнаас гадна холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэх, хянах, боловсронгуй болгох ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 1-д тусгагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийт 6 үүрэг даалгаврын хэрэгжилтийг агуулсан Ахицын тайланг Санхүүгийн мэдээллийн албанаас нэгтгэн 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Ази, Номхон далайн хамтарсан бүлэгт хүргүүлсэн. Уг тайланг ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг болон Ази, Номхон далайн хамтарсан бүлгийн 2020 оны 01 дүгээр сард БНХАУ-ын Бээжин хотод хамтран зохион байгуулсан хурлаар хэлэлцүүлж, Шууд хэрэгжилт 3, 8, 11-т багтсан нийт 3 үүрэг даалгаврыг “Дийлэнхийг биелүүлсэн” гэж үнэлүүлсэн.

Зураг 1. Дотоод хамтын ажиллагааны байгууллагын гишүүд



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Үүний дараагаар 2020 оны 02 дугаар сард БНФУ-ын Парис хотод зохион байгуулагдсан ФАТФ-ын нэгдсэн чуулганы үеэр Монгол Улсын ажлын хэсгийн төлөөлөл Монгол Улсыг ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргахтай холбоотой ажлыг эрчимжүүлсэн талаар мэдээлэв. Мөн хяналтын процессын дагуу Монгол Улсад газар дээрх хяналт шалгалтыг хийх ажлыг яаралтай зохион байгуулах агуулга бүхий Сангийн сайдын албан хүсэлтийг уламжлав.

ФАТФ-аас 2020 оны 3 дугаар сард Ковид-19 цар тахалтай холбогдуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргахтай холбоотой бүх улсуудад үнэлгээ хийх ажлыг 4 сараар хойшлуулж байгааг мэдээлсэн. Тус мэдэгдлийн хариуд Монголбанкны Ерөнхийлөгч болон Сангийн сайдын зүгээс ФАТФ-т Монгол Улс нь жагсаалтаас гарахтай холбоотой шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж байгааг

уламжилж, Монгол Улсад үнэлгээ хийх хугацааг хойшлуулахгүй байх албан хүсэлтийг илгээсэн. Уг албан хүсэлтийг Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулсан бөгөөд үүний үр дүнд ФАТФ-ын Ерөнхийлөгч Монгол Улсын Ахицын тайланг хамгаалах хугацааг хэвээр үлдээхийг зөвшөөрсөн.

Улмаар ажлын хэсгээс үлдсэн 3 үүрэг даалгавар буюу Шууд хэрэгжилт 3, 7, 11-ийн хүрээнд хийсэн ажлуудын биелэлтийг Ахицын тайланд тусгасан бөгөөд Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс уг тайланг нэгтгэн боловсруулж, 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Ази, номхон далайн хамтарсан бүлэгт хүргүүлсэн. Энэхүү Ахицын тайланг 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн цахим уулзалтаар амжилттай танилцуулж, хамгаалав. Уг хуралд Монгол Улсын Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгч, Тагнуулын ерөнхий газрын дарга болон ажлын хэсэгт багтсан бусад төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцсон.

Зураг 2. Ази, Номхон далайн хамтарсан бүлэгтэй хийсэн цахим уулзалт /2021.05.11/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн цахим хурлаар Монгол Улсын Ахицын тайлангийн талаар хэлэлцсэн. Уг хурлын үр дүнд ФАТФ-аас 6 дугаар сарын 30-ны өдөр албан ёсны мэдэгдэл гаргаж, Монгол Улс үлдсэн 3 үүрэг даалгаврыг хангалттай биелүүлж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй

тэмцэх үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэх, холбогдох техникийн хэрэгжилтийн дутагдлыг арилгах чиглэлээр ФАТФ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг хангалттай биелүүлсэн гэж үзэв. Иймд Монгол Улс нийт 4 Шууд хэрэгжилтийг хангах чиглэлээр ФАТФ-аас өгсөн 6 ажлын үүрэг даалгаварт “Дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээг авсан.



ФАТФ-ын 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн мэдэгдэл

ФАТФ-ын 2020 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн цахим хурлаар Монгол Улсыг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хангалттай биелүүлсэн гэж дүгнэлээ. Түүнчлэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнгийн хэрэгжилтийг үнэлэх, цаашид хэрэгжилтийг тогтвортой хангахын тулд улс төрөөс шаардагдах хүчин чармайлт байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор газар дээрх хяналт шалгалт хийх шийдвэрийг гаргав. Монгол Улс дараах гол шинэчлэлүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Зураг 3. Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн цахим хурал



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

- (1) Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах байгууллагын тухайн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан аргачлалаар хийж гүйцэтгэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн хариуцлага оногдуулах;
- (2) тодорхойлсон эрсдэлтэй нь уялдуулан мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, прокурорын түвшинд яллах ажиллагааг нэмэгдүүлэх;
- (3) хилээр мэдүүлээгүй/худал мэдүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авах;
- (4) хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах;
- (5) санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ авах үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авах зэрэг юм.

1.2 | САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсыг ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргах үйл ажиллагааны төлөвлөгөөний Шууд хэрэгжилт 3-т заасны дагуу санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийн биелэлтийг хангуулах чиглэлээр хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх үүрэг даалгаврыг өгсөн. Энэ ажлын хүрээнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг мэдээлэх үүрэгтэй этгээд болгосон.

Иймд Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэх ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын Хуульчдын холбоо, Монголын Нотариатчдын танхим болон Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй идэвхтэй хамтран ажиллаж, дэмжлэг туслалцаа үзүүлсэн. Улмаар санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх болон хяналт шалгалтын давтамж, хүрээг эрсдэлд суурилсан байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллав.

Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн албанаас өөрийгөө зохицуулах байгууллагууд болох Монголын Хуульчдын холбоо, Монголын Нотариатчдын танхим, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтид холбогдох

санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж, зайны хяналт тавих чиглэлээр дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Улмаар 2019 оны 9 дүгээр сараас хойшхи хугацаанд эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд газар дээрх хяналт шалгалтыг өөрийгөө зохицуулах байгууллагууд болон холбогдох яамдуудтай хамтран хийж гүйцэтгэснээс гадна сургалт соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгууллаа. Мөн хяналт шалгалтын үр дүнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ хангалтгүй биелүүлж, удаа дараагийн зөрчил гаргасан, эрсдэлийг тодорхойлох асуулгын хариуг үндэслэн эрсдэл өндөртөйд тооцогдсон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс Улсын байцаагчийн мэдэгдэл хүргүүлж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлсэн.

Шууд хэрэгжилт 7-той холбоотойгоор тодорхойлсон эрсдэлтэй уялдуулан мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, прокурорын түвшинд яллах ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэргийн статистикийн маягтыг бэлтгэн хууль сахиулах байгууллагуудад хүргүүлсэн. Түүнчлэн, бодлогын арга хэмжээнүүдийн хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн Хууль сахиулах ажлын хэсгийн хүрээнд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр бодлогын арга хэмжээнүүдийг системтэйгээр зохион байгуулан хэрэгжүүлэн ажилласны зэрэгцээ прокурорын хяналтыг хэрэгжүүлэх болон өндөр эрсдэлтэй

суурь гэмт хэргүүдийг мөнгө угаахаар давхар зүйлчлэн шалгах чиглэлээр хамтарч ажиллав.

Шууд хэрэгжилт 8-тай холбоотойгоор хилээр мэдүүлээгүй/ худал мэдүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх, гаргасан зөрчилднэйдүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авах ажлын хүрээнд Гаалийн ерөнхий газар (ГЕГ)-тай хамтарч ажилласан. Тухайлбал, ГЕГ-ын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газраас Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран Замын-Үүд, Ханги, Гашуунсухайт боомтод 2020 оны 9 дүгээр сарын 06-10-ны өдрүүдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хил хяналтын байгууллагын албан хаагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, бэлэн мөнгө, түүнтэй адилтгах бусад төлбөрийн хэрэгслийн хууль бус эргэлттэй тэмцэх, үнэт чулуу, алтыг хууль бусаар хил нэвтрүүлэх үйлдлийг илрүүлэх чадавхыг дээшлүүлэх ажлын байрны болон онолын сургалт зохион байгуулж, нийт хил хяналтын байгууллагын 53 албан тушаалтныг оролцуулсан.

Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах Шууд хэрэгжилт 11-ийн ажлын хүрээнд Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс Хамтын ажиллагааны зөвлөлийн харьяа байгуулагдсан

Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгийн үйл ажиллагааг дэмжиж ажилласан. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 464 дугаар тогтоолоор баталсан "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ын дагуу холбогдох байгууллагуудтай идэвхтэй хамтарч ажиллав.

Үүнээс гадна үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албанаас Терроризмтэй тэмцэх зөвлөл болон холбогдох хяналт шалгалтын байгууллагуудтай хамтран санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд энэ чиглэлийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв. Мөн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлийн мэдээлэх үүрэгтэй этгээдийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох олон улсын байгууллагуудын конвенц болон стандартын орчуулгын ажилд идэвхтэй оролцсон.

1.3 | **ФАТФ-ЫН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ**

ФАТФ-аас 2020 оны 6 дугаар сард Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 Шууд хэрэгжилттэй холбоотой 6 үүрэг даалгаврыг хангалттай биелүүлсэн гэж үнэлсэн. Үүнтэй холбогдуулан, ФАТФ-аас цаашид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг тогтвортой хангах чиглэлээр Монгол Улсын төрөөс хангалттай хүчин чармайлт гаргаж ажиллах эсэхийг тодорхойлох зорилгоор газар дээрх хяналт шалгалтыг хийхээр тогтсон. Энэ хүрээнд ФАТФ-аас Ковид-19 цар тахлыг харгалзан үзэж Монгол Улсад хийх газар дээрх хяналт шалгалтыг уян хатан байдлаар буюу Ази, Номхон далайн хамтарсан бүлгийн зарим гишүүдийг Монгол Улсад биечлэн ирүүлж, бусад аялах боломжгүй гишүүдийг цахимаар шалгалтад оролцуулахаар болсон. Гэвч Ковид-19 цар тахлын улмаас хамтарсан бүлгийн гишүүд Монгол Улсад биечлэн ирж оролцох эсэх нь тодорхойгүй байсны улмаас газар дээрх хяналт шалгалт хойшлогдож болзошгүй нөхцөл байдал үүссэн.

Иймд Монголбанк, Сангийн Яам болон холбогдох бусад гишүүн байгууллагуудаас Монгол Улсад суугаа холбогдох гадаад улс орнуудын элчин сайдын яамд болон хамтарч ажилладаг олон улсын байгууллагуудын ажилтнуудаар дамжуулан газар дээрх хяналт шалгалтыг бүрэн цахим байдлаар хийлгэх хүсэлтийг хүргүүлсэн боловч ФАТФ-ын Ерөнхийлөгчөөс татгалзсан хариу өгсөн. Үүний дараагаар ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг болон Ази, Номхон далайн хамтарсан бүлгийн дарга, дэд дарга нартай цахим хурал хийж, газар дээрх хяналт шалгалтыг хойшлуулахгүй байх зорилгоор удаа дараа албан хүсэлтүүдийг явуулсан. Түүнчлэн, Гадаад харилцааны яамаар

дамжуулан Монгол Улсаас ФАТФ-ын гишүүн улс орнуудад суугаа элчин сайдын яамдаар Монгол Улсад үнэлгээ хийх ажилтнуудаа илгээх эсвэл цахимаар газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх тухай хүсэлтүүдийг хэд хэдэн удаа хүргүүлэв. Эдгээр хүсэлт, хэлэлцээрүүдийн үр дүнд Монгол Улсад газар дээрх хяналт шалгалтыг 2020 оны 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулахаар болсон.

Сангийн Сайдын 2020 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 151 дүгээр тушаалаар Монгол Улсад хийх ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх төлөвлөгөө, хяналт шалгалтад бэлтгэх байгууллага, албан тушаалтнуудын бүрэлдэхүүн, зохион байгуулалтын арга хэмжээ авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тус тус баталсан. Энэхүү ажлын төлөвлөгөөний биелэлтийг 2020 оны 9 дүгээр сард Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл, Сангийн Сайдын ахалсан ажлын хэсгийн хурал дээр хэлэлцэж, дүгнэсэн.

Санхүүгийн мэдээллийн албанаас Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллага тус бүрт зориулан газар дээрх хяналт шалгалтын хүрээнд ФАТФ-аас тодруулах боломжтой асуулт, хариултууд бүхий зөвлөмжийг бэлтгэж хүргүүлсэн. Улмаар Монголын банкны холбоотой хамтран банкуудын удирдлагууд болон комплаенсын нэгжийн ажилтнуудад зориулан 2020 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх талаар сургалт зохион байгуулж, зөвлөмжүүд өгөв. Үүнээс гадна Монгол Улсын газар дээрх хяналт шалгалтын тайлан буюу шинэчилсэн Ахицын тайланг 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Санхүүгийн мэдээллийн албанаас гишүүн байгууллагуудтай хамтран ФАТФ-т бэлтгэн хүргүүлснээс гадна газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх зорилгоор 2020 оны 9 дүгээр

сарын 25-29-ний өдрүүдэд Азийн хөгжлийн банкны зөвлөхтэй нийт 4 удаагийн урьдчилсан бэлтгэл уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, вакумжиж ажиллав.

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 105 дугаар тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын тогтолцоонд газар дээрх хяналт шалгалтыг хийх ФАТФ-ын үнэлгээний багийн гишүүдийн манай улсад ирэх, буцах нислэг, байрлах байр болон бүх төрлийн үйлчилгээг чанарын стандартад нийцүүлэх, мэргэжлийн байгууллагуудаас тавих ариутгал, халдваргүйжүүлэлтийн шаардлагыг бүрэн хангах, хяналт шалгалтын

хүрээнд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийг байгуулав. Энэхүү ажлын хэсэгт Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам болон халдваргүйжүүлэлт хийх байгууллагууд багтсан. Уг ажлын хэсгийг Санхүүгийн мэдээллийн албаны дарга ахалж, газар дээрх хяналт шалгалтын зохион байгуулалтыг хариуцаж ажилласан.

Зураг 4. ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын нээлт /2020.10.01/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Монгол Улсад ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтыг 2020 оны 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд Улсын онцгой комиссын хяналтан дор Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх шаардлагын дагуу зохион байгуулсан бөгөөд төрийн 22 байгууллага, 19 аж ахуйн нэгж, 4 мэргэжлийн холбоод, хувиараа бизнес эрхлэгчдийн төлөөллөөс бүрдсэн нийт 140

гаруй хүн оролцсон. Харин Ази, Номхон далайн хамтарсан бүлгийг төлөөлж АНУ, Их Британи, ОХУ, БНХАУ-ын нийт 4 үнэлгээний багийн гишүүн Монгол Улсад биечлэн ирж, бусад гишүүд цахим байдлаар газар дээрх хяналт шалгалтад оролцов. үйл ажиллагааны төлөвлөгөө (Хүснэгт 1)-ний ажлуудын хэрэгжилтийг үнэлсэн.

Хүснэгт 2. ФАТФ-ын Монгол Улсад хийсэн газар дээрх хяналт шалгалтад оролцсон алба тушаалтнууд

Биечлэн оролцсон	Цахимаар оролцсон
- Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн ажлын албаны ажилтан Дарья Кудряшова; - БНХАУ-ын Ардын Банкны Мөнгө угаахтай тэмцэх албаны Олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн Дэд захирал Чи Пэн Чү; - Их Британи Улсын Сангийн яамны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх тасгийн дарга Мартин Вайард; - АНУ-ын Сангийн яамны Бодлогын ахлах зөвлөх Сабина Кук	- Ази, Номхон далайн хамтарсан бүлгийн дарга Йогпал Синг, Конни Чу; - ФАТФ-ын ажлын албаны төлөөлөгч Александр Родригез-Вигоро; - Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн ажлын албаны төлөөлөгчид Митали Тъяги, Лоурэн Хирш, Дэниэл Куалишэфски; - Европын холбооны төлөөлөгч Лоурэн Лим; - Энэтхэг Улсын төлөөлөгч Пурна Кам Сингх; - Япон Улсын төлөөлөгч Кодай Хашимото; - Макао Улсын Приссилла Фонг болон Хосэ Карапина төлөөлөгчид; - Шинэ Зеланд Улсын төлөөлөгч Ник Кокэй болон бусад төлөөлөгчид.

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Зураг 5. ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын үеэр /2020.10.02/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын нээлтэд Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон бусад яамд, төрийн эрх бүхий байгууллагуудын дээд удирдлагууд оролцсон. Нээлтийн үеэр Ерөнхий сайд Ковид-19 цар тахлын үед манай улсын

үнэлгээг хойшлуулахгүйгээр газар дээрх хяналт шалгалтыг хийжгүйцэтгэхийг зөвшөөрч, хамтарч ажилласан ФАТФ, Ази, Номхон далайн хамтарсан бүлэг болон Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт талархал илэрхийлсэн. Түүнчлэн Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны өнөөгийн

байдлыг товч танилцуулан, цаашид энэ чиглэлээр төрийн өндөр түвшний оролцоог хангаж ажиллахыг онцолж, хурлыг эхлүүлсэн. Монголбанкны Ерөнхийлөгч мөн олон улсын байгууллагуудын оролцогчдод гүнээ талархаж, газар дээрх хяналт шалгалтыг Ковид-19 цар тахлын хүнд хэцүү үед Монгол Улсын талаас өндөр ач холбогдолтойгоор зохион байгуулсныг дурдаж, Санхүүгийн мэдээллийн албаны чадавх, бололцоог нэмэгдүүлсэн талаар мэдээлэв.

Юуны өмнө үнэлгээний баг Шууд хэрэгжилт 3-ын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороотой уулзаж, зохицуулалттай мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлд суурилсан хяналт шалгалтын талаар хэлэлцсэн бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн хариуцлага оногдуулах тогтолцооны талаар тодруулав. Уг уулзалтын дараагаар санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ

үзүүлэгчдийг зохицуулах мэргэжлийн холбоод болон Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яамны албан тушаалтнуудтай уулзаж, тодруулга авсан. Улмаар үнэлгээний багийн гишүүд хувийн хэвшлийн төлөөлөгчид буюу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хуульчдын холбоо, Монголын Нотариатчдын танхим, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын зохицуулалтад хамаардаг санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдтэй тусдаа уулзалт хийж, тэдний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргийн хэрэгжилт, ойлголтын талаар ярилцав.

Шууд хэрэгжилт 7-ийн хүрээнд үнэлгээний багийн гишүүд хууль сахиулах байгууллагуудын төлөөлөлтэй 2 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Тухайлбал, Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газруудын албан тушаалтнуудаас Монгол Улсын мөнгө

Зураг 6. ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын хаалтын уулзалт /2020.10.02/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

угаах гэмт хэрэгтэй холбоотой мөрдөн шалгах, яллах, шүүх үйл ажиллагааны талаар биечлэн болон цахимаар дэлгэрэнгүй асуултуудыг асуув.

Шууд хэрэгжилт 8-ын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын талаар Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газартай хэлэлцүүлэг өрнүүлсэн. Уг уулзалтаар Сангийн яамнаас Монгол Улсын одоогийн хил хамгаалалтын тогтолцооны талаар илтгэл бэлдэж танилцуулсан бөгөөд Гаалийн ерөнхий газрын дотоод систем, програм, техник хангамж, чадавхын талаар хэлэлцсэн.

Шууд хэрэгжилт 11-тэй холбоотой 2 ажлын талаар хэлэлцэх уулзалтыг Тагнуулын ерөнхий газар, Терроризмтой тэмцэх зөвлөл, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Санхүүгийн зохицуулах хорооны албан тушаалтнуудтай хийсэн. Монгол Улсын талаас үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх дотоод үйл

ажиллагааг хэрхэн хамтарч хэрэгжүүлж байгааг танилцуулсан бөгөөд олон улсын конвенци болон НҮБ-ын санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоог бий болсон талаарх мэдээлсэн.

Хувийн хэвшлийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалтуудаас бусад дээр дурдсан бүх уулзалтуудад Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөгчид оролцож, холбогдох хариу тайлбар, тодруулгыг өгсөн. Улмаар ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын хаалтын уулзалтад УИХ-ын дарга, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, бусад төлөөллүүд оролцов. Энэхүү уулзалтаар хоёр талууд хамтын ажиллагаанд талархал илэрхийлж, ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарах үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсад хийсэн газар дээрх хяналт шалгалтыг албан ёсоор өндөрлөв.

Зураг 7. ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын хаалтын уулзалт /2020.10.02/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

ФАТФ-ЫН СААРАЛ ЖАГСААЛТААС МОНГОЛ УЛСЫГ ГАРГАХ АЖИЛД ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДААС ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 3. ФАТФ-ын саарал жагсаалтаас Монгол Улсыг гаргах ажилд олон улсын байгууллагуудаас үзүүлсэн дэмжлэг, тусалцааны мэдээлэл



Санхүүгийн Хориг Арга Хэмжээ
Авах Байгууллага (ФАТФ)



Ази, Номхон Далайн Мөнгө
Угаахтай Тэмцэх Бүлэг



Евро-Азийн Мөнгө
Угаахтай Тэмцэх
Бүлэг



Америкийн
Нэгдсэн Улсын
Сангийн Яам



Их Британи, Умард
Ирландын Нэгдсэн
Хаант Улсын Сангийн
Яам



Бүгд Найрамдах
Хятад Ардын Улсын
Ардын Банк

Монгол Улсыг Саарал жагсаалтаас гаргах ажлын хүрээнд ФАТФ, Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Ази, Номхон далайн хамтарсан бүлэгтэй идэвхтэй хамтарч ажилласан.

ФАТФ-ын Монгол Улсад хийсэн газар дээрх хяналт шалгалтад төлөөлөгчдөө илгээж, биечлэн оролцсон.



THE WORLD BANK

Дэлхийн Банк



Asian Development Bank

Азийн Хөгжлийн Банк

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр техник тусалцаа үзүүлж, Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэхэд хамтран ажилласан.

Монгол Улсад Саарал жагсаалтаас гарах чиглэлээр ФАТФ-аас өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэхэд техник тусалцаа үзүүлсний дүнд олон улсын зөвлөхтэй хамтран ажиллаж, санал зөвлөгөө авсан.



Олон Улсын Валютын Сан



Australian Government
Visions of Australia

Австрали Улсын Дотоод
Хэргийн Яам

1. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр техник тусалцаа дэмжлэг үзүүлсэн;

2. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр эрсдэлийн үнэлгээний аргачлал, хэрэгсэлтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хянан шалгагч нарын чадавхыг бэхжүүлэхэд тусалцаа үзүүлсэн.


1. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр техник тусалцаа дэмжлэг үзүүлсэн;

2. Үй олноор хөнөөх зөвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд тусалцаа үзүүлсэн.



UNODC
United Nations Office on Drugs and Crime

Нэгдсэн Үндэстний
Байгууллагын
Мансууруулах Бодис, Гэмт
Хэрэгтэй Тэмцэх Газар



Европын Сэргээн
Босголт, Хөгжлийн
Банк



Олон Улсын
Санхүүгийн
Корпораци



Европын Холбоо

Монгол Улсад суугаа
элчин сайдын яамдууд

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр хамтран ажилласан.

1.4 | МОНГОЛ УЛС ФАТФ-ЫН СААРАЛ ЖАГСААЛТААС ГАРСАН ТУХАЙ

Газар дээрх хяналт шалгалтын үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн хурал дээр гишүүн орнууд хэлэлцэн дүгнэж, ФАТФ-ын Ерөнхийлөгч 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсыг ФАТФ-ын

стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу Саарал жагсаалтаас гарсныг албан ёсоор зарласан. ФАТФ-аас гаргасан мэдэгдлийн талаар Монголбанк болон Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд мэдээлсэн.

Зураг 8. Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн цахим уулзалт /2020.10.13/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба



ФАТФ-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн мэдэгдлээс

ФАТФ-аас Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах чиглэлээр томоохон ахиц, дэвшил гаргаж ажилласныг сайшааж байна. Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр нөлөөг бэхжүүлж, 2019 оны 10 дугаар сард ФАТФ-аас илрүүлсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдлыг арилгахтай холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан амлалтаа биелүүлж, холбогдох техникийн дутагдлыг арилгасан байна. Монгол Улс Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгтэй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах чиглэлээр цаашид үргэлжлүүлэн хамтран ажиллах болно.

Монгол Улс Ковид-19 цар тахлын хүнд хэцүү цаг үед газар дээрх хяналт шалгалтыг амжилттай зохион байгуулсан нь олон улсын сайн туршлага болсныг ФАТФ-ын чуулга уулзалт дээр онцлон тэмдэглэсэн. Түүнчлэн 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр ФАТФ-ын Ерөнхийлөгч

Доктор Маркус Плейер Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу аарал жагсаалтаас гаргахаар шийдвэрлэснийг дараах албан захидлаар мэдэгдэж, баяр хүргэсэн.

ФАТФ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ДОКТОР МАРКУС ПЛЕЙЕРЫН ЗАХИДЛЫН ОРЧУУЛГА



ФАТФ
ЕРӨНХИЙЛӨГЧ

Албан бус орчуулга

Ноён Хүрэлбаатар Чимэд Сангийн Сайд
15160 С.Данзангийн гудамж 5/1
Засгийн газрын II байр, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар хот Монгол улс
Имэйл: info@mof.gov.mn

2020 оны 11 дүгээр сарын 06

Дугаар: 06112020

Хүндэт сайд танаа,

Энэхүү захидлыг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас 2020 оны 10 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд цахимаар хуралдаж, Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгээс тавигддаг шаардлагуудын дагуу үнэлсэн үр дүнгийн талаар мэдээлэх зорилгоор хүргүүлж байна.

Тус хуралдаанаар Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгээс 2020 оны 10 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн газар дээрх хяналт шалгалтын үр дүнг хэлэлцлээ. Дэлхий дахинд дэгдсэн цар тахлын хүнд хэцүү цаг үед Монгол Улс маш их хүчин чармайлт гаргаж, газар дээрх хяналт шалгалтыг амжилттай зохион байгуулсан явдалд талархал илэрхийлье.

Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, дутагдлыг арилгах чиглэлээр дараах гол арга хэмжээг авч хэрэгжүүлснийг ФАТФ-аас сайшаан үнэлж байна. Үүнд: (1) Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах байгууллагын тухайн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан аргачлалаар хийж гүйцэтгэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн хариуцлага оногдуулж ажилласан; (2) тодорхойлсон эрсдэлтэй нь уялдуулан мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах ажиллагааг нэмэгдүүлсэн; (3) хилээр мэдүүлээгүй/худал мэдүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээг авсан; (4) хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулснаас гадна санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ авах үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авсан.

Иймд Монгол Улс үйл ажиллагааны төлөвлөгөөгөө бүрэн биелүүлэн, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, цаашид тогтвортой хэрэгжүүлэхээр байгааг газар дээрх хяналт шалгалтаар баталгаажуулсны үр дүнд Монгол Улсыг ФАТФ-ын хяналтаас гаргахаар шийдвэрлэлээ. Монгол Улсын гаргасан ахиц дэвшлийн талаар болон ФАТФ-аас Монгол Улсыг саарал жагсаалтаас гаргах тухай шийдвэрийг ФАТФ-ын цахим хуудсанд 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр нийтэлсэн болно. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог улам бэхжүүлэн ажиллаж байгаа явдалд дахин баяр хүргэе.

Хүндэтгэсэн,
Доктор Маркус Плейер
ФАТФ-ын Ерөнхийлөгч

ФАТФ
2 rue Andre Paskal
75775 Paris Cedex 16
ФРАНЦ УЛС

Утас: +33 (0) 1 45 24 90 90
Факс: +33 (0) 1 44 30 61 37
contact@fatf-gafi.org
www.fatf-gafi.org

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба



МОНГОЛ УЛСЫГ МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ УЛС ОРНУУДЫН ЖАГСААЛТ БУЮУ “СААРАЛ” ЖАГСААЛТААС ГАРГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ОН ЦАГИЙН ДАРААЛАЛ

2017
07.21

Монгол Улсын Харилцан Үнэлгээний тайланг ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 20 дахь удаагийн жилийн хурал Шри-Ланка улсын нийслэл Коломбо хотноо болсон хурлаар хэлэлцэж батлав. Тус тайланд ФАТФ-ын үр дүнтэй байдлын 11 шалгуур үзүүлэлтээс 9 нь доогуур, 2 нь дунд зэрэг үнэлгээтэй, ФАТФ-ын 40 зөвлөмжийн техник хэрэгжилтийн хувьд 5 нь биелээгүй, 15 нь хэсэгчилсэн биелэлттэй, 5 нь ихэнхийг биелүүлсэн, 5 нь бүрэн биелүүлсэн гэж үнэлсэн.

2017
09.20

Монгол Улсын Харилцан Үнэлгээний тайлан хэвлэгдэв. Тус тайлангийн үр дүнд үндэслэн Монгол Улсыг “Өргөтгөсөн эрчимтэй хяналт”-д оруулж, ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтад орох эрсдэлтэй байгаа тул хугацаатай үүрэг даалгавар өгсөн.

2018
06.29

Монгол Улсыг ФАТФ-аас стратегийн дутагдлаа арилгаж, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх ажиглалтад хамруулсан бөгөөд уг ажиглалтын хугацаа 2019 оны 06 дугаар сард дуусгавар болсон.

2019
10.18

Монгол Улсыг ФАТФ-ын үр дүнтэй байдлын 11 шалгуур үзүүлэлтээс 7-г нь биелүүлэхэд ахиц гаргасан боловч 4 үзүүлэлтийг хангалтгүй биелүүлсэн гэж үзсэн. Улмаар Ази, Номхон далайн хамтарсан бүлгээс БНФУ-ын Парис хотод болсон Чуулга уулзалтаар Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “Саарал жагсаалт”-д оруулахаар шийдвэрлэсэн. Ингэхдээ ФАТФ-аас үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хангалтгүй биелэлттэй 3, 7, 8, 11 гэсэн нийт 4 шууд хэрэгжилтэд хамаарах 6 ажлыг 2021 оны 5 дугаар сар хүртэл хэрэгжүүлэхийг Монгол Улсад үүрэг болгосон.

2019
12.02

Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, ФАТФ-тай тохирсон үйл ажиллагааны хүрээнд өгөгдсөн нийт 6 үүрэг даалгаврын хэрэгжилтийг тусгасан Монгол Улсын Ахицын тайланг Ази, Номхон хамтарсан бүлэгт хүргүүлсэн.

2019
12.11

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2019 оны 172 дугаар захирамжаар ФАТФ-тай тохирсон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр Сангийн Сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан.

2019
12.25

2019 оны Засгийн газрын 463 дугаар тогтоолоор ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас Монгол Улсыг гаргах чиглэлээр 4 шууд хэрэгжилтийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.

2020
01.20

Нийт 6 үүрэг даалгаврын хэрэгжилтийг тусгасан Монгол Улсын Явцын тайланг БНХАУ-ын Бээжин хотод ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг болон Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хамтран зохион байгуулсан хурлаар хэлэлцүүлж, Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран тайланг хамгаалсан. Тус хурлаар Шууд хэрэгжилт 3, 8, 11-т багтсан 3 үүрэг даалгавар буюу нийт ажлын 50 хувийг "Дийлэнхийг биелүүлсэн" гэж үнэлүүлсэн.

2020
02.21

БНФУ-ын Парис хотод зохион байгуулагдсан ФАТФ-ын нэгдсэн чуулганы үеэр Монгол Улсыг ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргахтай холбоотой ажлыг эрчимжүүлсэн талаар мэдээлсэн. Мөн Монгол Улсад газар дээрх хяналт шалгалтыг хийх ажлыг яаралтай зохион байгуулах агуулга бүхий Сангийн сайдын албан хүсэлтийг уламжлав.

2020
03.24

ФАТФ-аас Ковид-19 цар тахалтай холбогдуулан бүх улсуудад үнэлгээ хийх хугацааг 4 сараар хойшлуулах мэдээлэл ирсэн. Иймд Монголбанкны Ерөнхийлөгчийн зүгээс ФАТФ-т Монгол Улс нь жагсаалтаас гарахтай холбоотой шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж байгаа бөгөөд Монгол Улсад үнэлгээ хийх хугацааг хойшлуулахгүй байх албан хүсэлтийг илгээсэн. Уг хүсэлтийг Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан бэлтгэсэн.

2020
03.26

Сангийн сайдын зүгээс Монголбанкны Ерөнхийлөгчийн тавьсан хүсэлттэй ижил агуулгатай Монгол Улсад үнэлгээ хийх хугацааг хойшлуулахгүй байх албан хүсэлтийг илгээсэн.

2020
04.03

ФАТФ-ын Ерөнхийлөгч Монголбанкны Ерөнхийлөгч болон Сангийн сайдын хүсэлтийн хариуд Монгол Улсын авч хэрэгжүүлж буй арга хэмжээг өндрөөр үнэлж, улмаар Монгол Улсын жагсаалтаас гарах үнэлгээг хойшлуулахгүйгээр тайланг цахим байдлаар хэлэлцэхийг зөвшөөрсөн.

2020
04.13

Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран вакумжин ажиллаж, Монгол Улсыг ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргахтай холбоотой ФАТФ-аас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тусгасан Монгол Улсын Ахицын тайланг нийт 16 хавсралт баримт бичгийн нэгтгэн боловсруулж, Ази, Номхон далайн хамтарсан бүлэгт хүргүүлсэн. Тус тайланг Азийн хөгжлийн банкны зөвлөхийн санал зөвлөмжид үндэслэн сайжруулалтуудыг хийсэн.

2020
04.27

Монгол Улсын Ахицын тайланд тусгасан Шууд хэрэгжилт 3, 7, 11-ийн хүрээнд хийсэн ажлуудтай холбоотой тодруулах асуудлуудыг Ази, Номхон далайн хамтарсан бүлгээс ирүүлсэн.

2020
04.28

ФАТФ-аас Ковид-19 цар тахалтай холбогдуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргахтай холбоотой бүх улсуудад үнэлгээ хийх ажлыг 4 сараар хойшлуулсан бөгөөд ингэхдээ Монгол Улсын хүсэлтэд үндэслэн хуваарьт хугацааг хэвээр үлдээх талаар нийтэд мэдээлсэн.

2020
05.04

Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч холбогдох байгууллагуудтай хамтран Монгол Улсын Ахицын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг Ази, Номхон далайн хамтарсан бүлэгт хүргүүлсэн.

2020
05.07

Санхүүгийн мэдээллийн албанаас Монгол Улсын Ахицын тайланг Ази, номхон далайн хамтарсан бүлэгтэй цахим уулзалт хийж хамгаалах ажлын хүрээнд туршилтын цахим хурлыг Их тэнгэр цогцолборт зохион байгуулсан.

2020
05.11

Монгол Улсыг ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргахтай холбоотой ФАТФ-аас өгсөн үлдсэн 3 үүрэг даалгаврын хэрэгжилтийг агуулсан Ахицын тайланг Ази, номхон далайн хамтарсан бүлэгтэй цахим уулзалтаар амжилттай танилцуулж, хамгаалав. Уг хуралд Санхүүгийн мэдээллийн албанаас тус хурлыг Их тэнгэр цогцолборт техник технологи, аюулгүй байдлыг ханган зохион байгуулах, тайланг амжилттай хамгаалах бусад байгууллагуудтай хамтран ажилласан.

2020
05.26

Ази, номхон далайн хамтарсан бүлэгт цахим уулзалтаар амжилттай хамгаалсан Монгол Улсын Ахицын тайланд өгсөн үнэлгээ дүгнэлтийг урьдчилсан байдлаар ирүүлсэн бөгөөд уг дүгнэлтээр Монгол Улсыг ФАТФ-аас өгсөн үүрэг даалгаврыг “Дийлэнхийг биелүүлсэн” гэж үнэлсэн.

2020
05.29

Монгол Улс ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарах хүрээнд ФАТФ-аас өгөгдсөн 6 ажлын үүрэг даалгавраа хангалттай биелүүлсэн гэдэг үнэлгээг өгсөн талаарх мэдээллийг түгээх үүднээс Санхүүгийн мэдээллийн албанаас Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга болон холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэвлэлийн бага хурлыг Монголбанк дээр зохион байгуулсан.

2020
06.02

Ази, номхон далайн хамтарсан бүлгээс Монгол Улсын Ахицын тайлангийн мэдээллийг сүүлийн байдлаар нягтлахыг хүссэний дагуу Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран хянаж эцэслэсэн. Тус тайланг Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн цахим порталд байршуулсан.

2020
06.16

ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн цахим хурлаар Монгол Улсын Ахицын тайлангийн талаар хэлэлцсэн. Уг хуралд нийтдээ 23 улсын төлөөлөгчид хамрагдсан бөгөөд Санхүүгийн мэдээллийн албанаас Монгол Улсын төлөөлөгчдийг тус хуралд оролцуулах ажлыг зохион байгуулсан.

2020
06.24

ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн цахим хурлын үр дүнг ФАТФ-ын чуулганаар хэлэлцэж, улмаар Монгол улсыг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр төлөвлөгөөний дагуу ажлуудаа хангалттай биелүүлж, ахиц дэвшил гаргасан баяр хүргэсэн. Иймд КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр Монгол улсад газар дээрх хяналт шалгалтыг хийхийг улс орнууд дэмжив.

2020
06.30

ФАТФ-ын чуулганаар Монгол Улсыг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хангалттай биелүүлсэн гэж дүгнэсэн талаар ФАТФ-аас хэвлэлийн мэдэгдэл гаргав. Үүнд, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнгийн хэрэгжилтийг үнэлэх, цаашид хэрэгжилтийг тогтвортой хангахын тулд улс төрөөс шаардагдах хүчин чармайлт байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор газар дээрх хяналт шалгалт хийх шийдвэрийг гаргасан талаар дурдсан.

2020
07.06

ФАТФ-ын 2020 оны 6 дугаар сард болсон чуулганаар шийдвэрлэсний дагуу ФАТФ-ын хамтарсан бүлгийн гишүүд болон жагсаалтад байгаа улс орнуудаас Ковид-19 цар тахлын нөхцөл байдал, газар дээрх хяналт шалгалтыг биечлэн зохион байгуулах боломжийн талаар тодруулсан асуулгыг авсан. Уг асуулгын хариуг Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулж хүргүүлсэн бөгөөд Монгол Улс дотооддоо Ковид-19 тархалтгүй байгаа тул газар дээрх хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэн боломжтой болохыг уламжилсан.

2020
07.29

Дэлхий нийтээр Ковид-19 цар тахлын хямрал улмаас Монгол Улсад хийх газар дээрх хяналт шалгалт хойшлогдож болзошгүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор Санхүүгийн мэдээллийн албанаас Сангийн яамтай хамтран Сангийн сайдаас улс орны эдийн засаг хүндрэлтэй байгааг харгалзан үзэж, Монгол Улсад суугаа Гадаадын Элчин сайдын яамд болон олон улсын байгууллагуудын ажилтнуудыг газар дээрх шалгалтад хамруулах эсвэл цахим байдлаар хяналт шалгалтыг зохион байгуулах хүсэлтийг ФАТФ-ын Ерөнхийлөгчид хүргүүлсэн.

2020
08.06

ФАТФ-ын Ерөнхийлөгчийн зүгээс Монгол Улсын хүсэлтийг хүлээн авах боломжгүйгээ илэрхийлсэн бөгөөд газар дээрх хяналт шалгалтыг ФАТФ-ын үнэлгээчид биечлэн тухайн улсад очиж хийх шаардлагатай болохыг албан хариунд дурдсан. Мөн Ковид-19 цар тахлын хүнд хэцүү нөхцөл байдлыг ажиглаж, газар дээрх хяналт шалгалтын багийг илүү уян хатан байдлаар бүрдүүлэх нь чухал болохыг онцолсон.

2020
08.07

ФАТФ-ын Ажлын албанаас Ковид-19 цар тахлын нөхцөлд үнэлгээчид Монгол Улсад биечлэн аялж ирэх боломжтой тохиолдолд Монгол Улсын газар дээрх хяналт шалгалтыг 2020 оны 9 дүгээр сарын сүүлээр зохион байгуулах боломжтой талаар мэдээлсэн.

2020
08.12

Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагын төлөөллийн хамт Монгол Улсад хийх газар дээрх хяналт шалгалтыг хойшлуулахгүйгээр зохион байгуулах хүрээнд Ази, номхон далайн хамтарсан бүлгийн дэд дарга болон Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгтэй цахим хурал хийсэн.

2020
08.13

Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагын төлөөллийн хамт ФАТФ-ын ажлын албатай цахим хурал хийж, Монгол Улсыг жагсаалтаас гаргах хүрээнд газар дээрх хяналт шалгалтыг хэрхэн зохион байгуулах талаар тодруулсан.

2020
08.14

Сангийн Сайдын 151 дүгээр тушаалаар Монгол Улсад хийх ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх төлөвлөгөө, хяналт шалгалтад бэлтгэх байгууллага, албан тушаалтнуудын бүрэлдэхүүн, зохион байгуулалтын арга хэмжээ авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тус тус баталсан.

2020
08.17

ФАТФ, Ази, номхон далайн хамтарсан бүлэг болон Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгтэй цахим хурал хийсний дүнд Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран Ковид-19 цар тахлын хүнд үед Монгол Улсад үнэлгээчдийг хэрхэн авчрах, байрлуулах, хяналт шалгалтыг зохион байгуулах талаар уян хатан нөхцөлийг санал болгосон. Уг хүсэлтэд Монгол Улсын ажлын хэсгийн төлөөлөл шаардлагатай тохиолдолд 21 хоног карантинд орох нөхцөл багтсан. Мөн энэ хугацаанд Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайдтай Засгийн газрын түвшинд уулзалт хийж, үнэлгээчнээ Монгол Улсад ирүүлж, газар дээрх хяналт шалгалтыг зохион байгуулахад дэмжлэг хүссэн.

2020
08.18

Санхүүгийн мэдээллийн албанаас Гадаад харилцааны ямаар дамжуулан Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яамдаар тухайн улсын Засгийн газарт хандан, Ковид-19 цар тахлын хүнд үед Монгол Улсыг жагсаалтаас гаргах ажилд дэмжлэг үзүүлж, үнэлгээчнээ ирүүлэх хүсэлтийг гаргасан. Мөн Монгол Улсын Засгийн газрын уян хатан нөхцөл бүхий саналыг хүргүүлсэн.

2020
08.20

ФАТФ-аас Монгол Улсын газар дээрх хяналт шалгалтыг зохион байгуулах уян хатан нөхцөлийг үнэлгээчдэд хүргүүлж, биечлэн оролцох боломжтой эсэх талаар санал асуулга явуулсан.

2020
08.26

ФАТФ-аас хүргүүлсэн санал асуулгын дүнд зөвхөн 1 үнэлгээчин бусад үнэлгээчид газар дээрх хяналт шалгалтад оролцох тохиолдолд Монгол Улс руу аялах боломжтой гэдгээ илэрхийлсэн. Иймд ФАТФ-аас Ковид-19 цар тахлын нөхцөл байдлыг харгалзан үзэж, газар дээрх хяналт шалгалтыг азнах талаар мэдээлсэн. Иймд Монгол Улсын саналыг Ази, Номхон далайн хамтарсан бүлгийн гишүүдээс гадна илүү өргөн хүрээнд бусад бүлэгт хүргүүлж, газар дээрх хяналт шалгалтад оролцох боломжтой эсэхийг тодруулахаар болсон.

2020
08.26

Монголбанкны Ерөнхийлөгчөөс Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Дэд дарга нар болон Ажлын албанд хандан 2020 оны 10 дугаар сард болох ФАТФ-ын Чуулганаас өмнө Монгол Улсад хийх хяналт шалгалтыг зохион байгуулахад дэмжлэг хүссэн. Ингэхдээ хэрэв үнэлгээчид Ковид-19 цар тахлын нөхцөлд биечлэн аялах боломжгүй тохиолдолд хяналт шалгалтыг цахимаар хийх хүсэлтийг хүргүүлсэн. Уг хүсэлт бүхий албан захидлыг Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулсан.

2020
08.27

Сангийн сайдын зүгээс Монгол Улсын ФАТФ-ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд хяналт тавих Ази, номхон далайн хамтарсан бүлгийн дэд даргад хандаж, ФАТФ-ын ээлжит бус хуралдаан зарлах замаар Монгол Улсад хийх хяналт шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах шийдвэр гаргах хүсэлтийг албан захидлаар хүргүүлсэн. Тус албан захидлыг Санхүүгийн мэдээллийн албанаас Сангийн яамтай хамтран боловсруулсан.

2020
08.28

ФАТФ-аас Ковид-19 цар тахлын хямралын үед харилцан үнэлгээг явуулах тухай баримт бичгийг гаргасан бөгөөд энэхүү баримт бичигт баримтлах процедурыг ФАТФ-ын жагсаалтаас гарах тохиолдолд мөн адил мөрдөх талаар тусгасан. Иймд Санхүүгийн мэдээллийн албанаас уг баримт бичигтэй танилцаж, Ковид-19 цар тахлын үед газар дээрх хяналт шалгалтыг цахимаар явуулах, биечлэн ирж хяналт шалгалт хийх үнэлгээчдийн тоог багасгах, үнэлгээчдийг илүү уян хатан нөхцөл санал болгож буй улс орнууд руу аялахыг дэмжих саналыг Ази, Номхон далайн хамтарсан бүлгээр дамжуулан ФАТФ-т хүргүүлэх хүсэлтийг илгээсэн.

2020
09.07

Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс Ази, Номхон далайн хамтарсан бүлгийн гишүүн үнэлгээчдэд хандан Ковид-19 цар тахлын хүндрэлтэй үед Монгол Улсыг ФАТФ-ын жагсаалтаас гаргахад дэмжлэг үзүүлж, газар дээрх хяналт шалгалтад биечлэн оролцох боломжгүй бол цахим байдлаар уян хатан нөхцөлөөр зохион байгуулах хүсэлтийг нааштай хүлээж авахыг хүссэн.

2020
09.07

Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-аас ирүүлсэн хүсэлтийн хариуд Монгол Улсын газар дээрх хяналт шалгалтыг 2020 оны 9 дүгээр сарын сүүлийн 7 хоногт зохион байгуулах боломжтой болохыг мэдэгдсэн.

2020
09.11

Монголын банкны холбоотой хамтран банкуудын удирдлагууд болон комплаенсын нэгжийн ажилтнуудад зориулан газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх талаар сургалт зохион байгуулж, зөвлөмжүүд өгөв.

2020
09.12

Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-аас ирүүлсэн хүсэлтийн хариуд Монгол Улсын газар дээрх хяналт шалгалтыг 2020 оны 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд БНХАУ, АНУ, Их Британи, ОХУ-аас 4 үнэлгээчин биечлэн ирж хийхээр болсон талаар мэдэгдсэн.

2020
09.17

ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарах хүрээнд Монгол Улсын газар дээрх хяналт шалгалтын тайлан буюу шинэчилсэн Ахицын тайланг Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран нэгтгэн боловсруулж, ФАТФ-т хүргүүлсэн.

2020
09.25

ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх зорилгоор 2020 оны 9 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд Азийн хөгжлийн банкны зөвлөхтэй нийт 4 удаагийн урьдчилсан цахим уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, вакумжиж ажиллав

2020
10.01

ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын уулзалтыг Улсын онцгой комиссын хяналтан дор Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх шаардлагын дагуу 2020 оны 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Уг уулзалтад төрийн 22 байгууллага, 19 аж ахуйн нэгж, 4 мэргэжлийн холбоод, хувиараа бизнес эрхлэгчдийн төлөөллөөс бүрдсэн нийт 140 гаруй хүн оролцсон. Харин Ази, номхон далайн хамтарсан бүлгийг төлөөлж АНУ, Их Британи, ОХУ, БНХАУ-ын нийт 4 үнэлгээний багийн гишүүн Монгол Улсад биечлэн ирж, бусад гишүүд цахим байдлаар газар дээрх хяналт шалгалтад оролцов.

2020
10.13

ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн цахим уулзалт зохион байгуулагдаж, Монгол Улсад хийсэн газар дээрх хяналт шалгалтын үр дүнг гишүүн орнууд хэлэлцэн дүгнэсэн.

2020
10.23

ФАТФ-ын Ерөнхийлөгч Монгол Улсыг ФАТФ-ын стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу "Саарал жагсаалт"-аас гарсныг албан ёсоор зарласан. ФАТФ-ын мэдэгдлийг ФАТФ-аас гаргасан мэдэгдлийн талаар Монголбанк болон Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд мэдээлсэн:

2020
11.06

Монгол Улс Ковид-19 цар тахлын хүнд хэцүү цаг үед газар дээрх хяналт шалгалтыг амжилттай зохион байгуулсан нь олон улсын сайн туршлага болсныг ФАТФ-ын чуулга уулзалт дээр онцлон тэмдэглэсэн. Түүнчлэн ФАТФ-ын Ерөнхийлөгч Доктор Маркус Плейер Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу саарал жагсаалтаас гаргахаар шийдвэрлэснийг дараах албан захидлаар мэдэгдэж, баяр хүргэсэн.

1.5 | **МОНГОЛ УЛС ЕВРОПЫН ХОЛБООНЫ МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ, ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ ГУРАВДАГЧ УЛС ОРНУУДЫН ЖАГСААЛТААС ГАРСАН ТУХАЙ**

ФАТФ-ын Саарал жагсаалтад орсонтой холбоотойгоор Монгол Улсыг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Европын Холбооны хар жагсаалт гэж нэрлэгддэг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад оруулсан.

Иймд Монгол Улсыг Европын Холбооны жагсаалтаас гаргах хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас Гадаад харилцааны ямаар дамжуулан Европын Холбоонд удаа дараа хүсэлт хүргүүлж, цахим хурал уулзалтуудыг зохион байгуулсан.

Зураг 9. Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албанаас Европын холбооны төлөөлөлтэй хийсэн уулзалт /2020.05.14/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Эдгээр арга хэмжээний үр дүнд ФАТФ-аас Монгол Улсыг Саарал жагсаалтаас гаргасантай холбогдуулан Европын Комиссоос 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр 2015/849 тоот тогтоолыг гаргаж, Монгол Улсыг Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас хассан.

Монгол Улсыг Европын Холбооны өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас гаргаснаар Европын Холбооны гишүүн орны банк, санхүүгийн байгууллагуудтай бизнесийн харилцаа тогтоох, гүйлгээг богино хугацаанд хийж гүйцэтгэх, Европын Холбооны санхүүжилтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж нэмэгдэх эерэг үр дагавартай юм.

МОНГОЛ УЛСЫГ ЕВРОПЫН ХОЛБООНЫ МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ, ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ ГУРАВДАГЧ УЛС ОРНУУДЫН ЖАГСААЛТААС ХАСАХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ОН ЦАГИЙН ДАРААЛАЛ

2019
10.18

Монгол Улсыг ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу "Саарал жагсаалт"-д оруулахаар шийдвэрлэсэн.

2020
05.07

Европын Комиссоос ФАТФ-ын жагсаалтад багтсан улс орнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх огтолцооны хувьд өндөр эрсдэлтэй гуравдагч улс орон хэмээн тодорхойлсон. Улмаар нийт 12 улсыг тэр дундаа Монгол Улсыг Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай гуравдагч улс орнуудын жагсаалтад нэмж оруулж байгаагаа зарласан.

2020
05.08

Санхүүгийн мэдээллийн албанаас Монголбанкны цахим хуудсанд Европын холбооноос боловсруулж байгаа бодлогын баримт бичиг нь төслийн түвшинд хэлэлцэгдэж байгаа бөгөөд Европын Парламент болон Зөвлөлөөр 1-2 сарын хугацаанд хэлэлцэж баталснаар албан ёсны шийдвэр болох талаар мэдэгдлийг бэлтгэж гаргав.

2020
05.13

Сангийн сайдаас Европын Комиссын Ерөнхийлөгч Урсула фон дер Лайенд хандан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдлыг арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Европын Холбооны шинэчилсэн аргачлалын 8 үндсэн шалгуурын дагуу тусган албан бичиг хүргүүлсэн. Улмаар Ковид-19 цар тахлын хүндрэлтэй цаг үед Монгол Улсыг өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад оруулах шийдвэрээ эргэн харж, энэ чиглэлээр албан ёсоор хамтран ажиллахыг хүссэн. Тус хүсэлтийг Сангийн яамнаас илгээхэд Санхүүгийн мэдээллийн албанаас албан бичгийн төсөлд санал өгч хамтран ажилласан.

2020
05.14

Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнгийн Европын холбооноос Монгол улсад суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд ноён Траян Христееатай хийсэн уулзалтад оролцож, Монгол Улсыг Европын Холбооны жагсаалтад оруулсантай холбоотой асуудлыг тодруулж, ФАТФ-ын стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарах хүрээнд хийгдэж буй ажлуудын ахиц дэвшлийг танилцуулав.

2020
05.21

Сангийн сайдаас Европын Парламентын Ерөнхийлөгч Дэвид Сассоли хандан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдлыг арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг танилцуулсан албан захидлыг илгээсэн. Уг захидалд Ковид-19 цар тахлын эдийн засгийн хүндрэлтэй цаг үед Монгол Улсыг өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад оруулахыг дэмжихгүй байхыг уриалж, албан ёсоор хамтран ажиллахыг хүссэн. Тус захидлыг илгээхэд Санхүүгийн мэдээллийн албанаас санал өгч хамтран ажилласан.

2020
06.11

Монгол Улсыг Европын Холбооны жагсаалтад оруулсантай холбоотойгоор Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудын төлөөллийн хамт Гадаад харилцааны ямаар дамжуулан Европын Комисстой цахим хурлыг зохион байгуулав. Уг хурлаар Европын Холбооны жагсаалт, холбогдох тогтоол, аргачлалын талаар тодруулсан бөгөөд нэмэлт тайлбар авах зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас нэмэлт асуултуудыг боловсруулан хүргүүлсэн.

2020
06.19

Санхүүгийн мэдээллийн албанаас Гадаад харилцааны яамтай хамтран Монгол Улсаас Европын Холбооны гишүүн улс орнуудад суугаа Элчин сайдын яамдаар дамжуулан тухайн улс орны Засгийн газраас Монгол Улсыг өндөр эрсдэлтэй гуравдагч улс орны жагсаалтад оруулахыг дэмжихгүй байх хүсэлтийг хүргүүлсэн. Гэвч Европын Комиссын Монгол Улсыг жагсаалтад оруулах тухай 2020/855 дугаартай журам Европын Холбооны албан ёсны сэтгүүлд хэвлэгдсэнээр Монгол Улс Европын Холбооны жагсаалтад багтсан.

2020
08.12

Европын холбооноос Монгол улсад суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдаас Гадаад харилцааны ямаар дамжуулан Сангийн яаманд Монгол Улсыг Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай гуравдагч улс орнуудын жагсаалтад оруулсныг мэдэгдсэн. Мөн Монгол Улсыг ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарсан тохиолдолд Европын Комиссын шинэчлэгдсэн аргачлалын хүрээнд аливаа нэмэлт шаардлага тавихгүйгээр Европын Холбооны жагсаалтаар гаргах тухай албан захидалд дурдсан.

2020
10.01

Ковид-19 цар тахлын хямралтай холбогдуулан Монгол Улсыг өндөр эрсдэлтэй гуравдагч улс орны жагсаалтад оруулах шийдвэр 4 сарын дараа буюу энэ өдрөөс албан ёсоор хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Ингэснээр Европын Холбооны санхүүгийн байгууллагууд Монгол Улсын хувьд өргөтгөсөн харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлж нэмэлт тавих, Европын Холбооны санхүүжилтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх нөхцөл байдал бий болсон.

2020
10.23

ФАТФ-аас Монгол Улсыг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо сайжруулах чиглэлээр томоохон ахиц, дэвшил гаргаж ажилласан тул Монгол Улсыг ФАТФ-ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу "Саарал жагсаалт"-аас гаргахаар шийдвэрлэсэн. Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-ын мэдэгдлийг орчуулж, Монгол Улс Саарал жагсаалтаас гарсан мэдээллийг бэлтгэн Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд нийтэлсэн.

2020
11.05

Монголбанкны Ерөнхийлөгчийн зүгээс Европын холбооноос Монгол улсад суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдад Монгол Улс ФАТФ-ын жагсаалтаас гарсантай холбогдуулан Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай гуравдагч улс орнуудын жагсаалтаас нэн яаралтай хасч өгөхийг хүссэн албан захидлыг хүргүүлсэн. Уг захидалд Монгол Улсыг жагсаалтаас хасах нь Ковид-19 цар тахлын хямралтай үед эдийн засаг, санхүүгийн салбарын сэргэлтэд чухал ач холбогдолтой болохыг дурдсан бөгөөд захидлын төслийг Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулсан.

2021
01.18

Европын Холбооны 2021/37 дугаартай журам нь албан ёсны сэтгүүлд нийтлэгдэж, Монгол Улсыг Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас албан ёсоор хассан.

2021
01.19

Санхүүгийн мэдээллийн албанаас Монгол Улсыг Европын Холбооны өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас хассан талаарх мэдээллийг Монголбанкны цахим хуудсанд нийтлэв.

ФАТФ-ЫН СААРАЛ ЖАГСААЛТААС МОНГОЛ УЛСЫГ ГАРГАХ АЖИЛД ХАМТАРЧ АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГУУД



Монголбанк



**ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Хууль Зүй,
Дотоод Хэргийн Яам



САНГИЙН ЯАМ

Сангийн Яам



Улсын Ерөнхий
Прокурорын Газар



Санхүүгийн Зохицуулах
Хороо



Авлигатай Тэмцэх
Газар



Тагнуулын Ерөнхий
Газар



Терроризмтой Тэмцэх
Зөвлөл



Цагдаагийн Ерөнхий
Газар



Гаалийн Ерөнхий Газар



Шүүхийн Ерөнхий
Зөвлөл



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ**

Гадаад Харилцааны яам



Шүүхийн Шийдвэр
Гүйцэтгэх Ерөнхий Газар



Улсын Дээд Шүүх



Засгийн Газрын Хэрэг
Эрхлэх Газар



Хил Хамгаалах Алба



Татварын Ерөнхий
Газар



Улсын Бүртгэлийн
Ерөнхий Газар



Мэргэжлийн Хяналтын
Ерөнхий Газар



Онцгой Байдлын
Ерөнхий Газар



Монголын Хуульчдын
Холбоо



Монголын
Нотариатчдын танхим



Монголын Банкны
Холбоо



**МОНГОЛЫН МЭРГЭШСЭН
НЯГТЛАН БОДОГЧДЫН
ИНСТИТУТ**

Монголын Мэргэшсэн
Нягтлан Бодогчдын
Институт



Монголын
Өмгөөлөгчдийн Холбоо



Халдварт Өвчин
Судлалын Үндэсний
Төв



Зоонозын Өвчин
Судлалын Үндэсний
Төв



Улсын Онцгой Комисс



Иргэний Нисэхийн
Ерөнхий Газар



Төрийн Тусгай
Хамгаалалтын Алба



БҮЛЭГ 2

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС
МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, ДҮН
ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

”



2.1 | МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдээс 20 сая төгрөг, түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний тайлан болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан, сэжигтэй гүйлгээний тайлан тус тус хүлээн

авдаг. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлсэн 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг мэдүүлсэн бэлэн мөнгөний мэдүүлгийг гаалийн байгууллагаас авч ажиллаж байна.

Хүснэгт 4. Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн гүйлгээний тоо


Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бэлэн мөнгөний гүйлгээний тоо	572,181	669,910	562,926	402,496
Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо	98,549	126,944	131,715	143,191
Сэжигтэй гүйлгээний тоо	203	1,596	2,385	3,014

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

2020 онд мэдээлэх үүрэгтэй этгээдээс нийт 3,014 сэжигтэй гүйлгээ хүлээн авсан нь 2019 онтой харьцуулахад 20 хувиар, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо 8 хувиар тус тус өссөн байна. Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо сүүлийн жилд өсч байгаа нь Санхүүгийн мэдээллийн алба мэдээлэх үүрэгтэй этгээдийн сэжигтэй гүйлгээг таних, илрүүлэх, сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор гарын авлага, заавар зөвлөмж боловсруулж хүргүүлсэн, мөн мэдээлэх үүрэгтэй этгээдтэй тогтмол уулзалт хийж сэжигтэй гүйлгээнд хийсэн дүн шинжилгээний талаарх ерөнхий мэдээлэл, сэжигтэй гүйлгээний нийтлэг хэв шинж, арга хэлбэрийн талаар мэдээлж байсантай холбоотой байна. Нөгөөтэйгүүр, мэдээлэх үүрэгтэй этгээдүүд сэжигтэй гүйлгээг таних, илрүүлэх, анхан шатны судалгаа шинжилгээ хийх, Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үйл ажиллагаандаа ач холбогдол өгч, өөрийн байгууллагыг болоод санхүүгийн системийг эрүүл, найдвартай байлгах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох олон эрсдэлээс урьдчилан сэргийлэх асуудалд анхаарал хандуулдаг болж байгаатай холбоотой

болов уу. Харин гаалийн мэдүүлгийн тоо өмнөх онтой харьцуулахад 2 дахин буурсан байгаа нь дэлхий нийтэд тархаад байгаа Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж улсын хилийг хааснаар зорчих хөдөлгөөн багассантай шууд холбоотой юм. Хэдий тийм ч, 2017, 2018 онуудаас гаалийн мэдүүлгийн тоо 2-3 дахин өссөн байгаа нь Санхүүгийн мэдээллийн алба болон гаалийн байгууллагын хамтын ажиллагааны үр дүн юм. 2020 онд Санхүүгийн мэдээллийн албаны оролцоотой хил, гаалийн ажилтнуудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон хилээр хууль бусаар бэлэн мөнгө тээвэрлэхтэй холбоотой сургалтыг зохион байгуулж, хил гаалийн ажилтнуудын энэ талын мэдлэг, чадавхыг дээшлүүлэн ажиллаа.

Зураг 10. Гаалийн мэдүүлгийн тоо




Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

2.2 | МЭДЭЭЛЭЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-т заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд

байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг. Энэ хүрээнд 2020 онд дараах байдлаар сэжигтэй гүйлгээнд дүн шинжилгээ хийсэн болно.

Зураг 11. Хүлээн авсан сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийсэн сэжигтэй гүйлгээний тоо



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Дүн шинжилгээ хийсэн сэжигтэй гүйлгээний тоо өмнөх онуудтай харьцуулахад огцом өссөн байгаа нь 2020 онд шинжээчдийн орон тоо нэмэгдсэн, албаны болон ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээ авсантай тус тус холбоотой. Мөн сэжигтэй гүйлгээний тайланд хийгдэж буй дүн шинжилгээний тоо өссөнөөс гадна чанар сайжирч байгаа нь Санхүүгийн мэдээллийн алба болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд гарч ирсэн статистик харуулж байна.

Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн алба нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд олон улсын стандарт болон хууль, журамд заасны дагуу стратегийн дүн шинжилгээний тайлан боловсрууллаа. Тайлант хугацаанд хууль сахиулах байгууллагууд, прокурор, шүүхийн байгууллагуудаас мэдээлэл цуглуулж Санхүүгийн мэдээллийн албаны 2019 оны Стратегийн дүн шинжилгээний тайланг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлж танилцуулсан. Мөн олон улсын байгууллагаас гаргасан мөнгө

угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох баримт бичиг, тайлан мэдээлэлд судалгаа хийж өөрийн улсад гарч болох сэжигтэй гүйлгээний жишээ типологийн тайланг гаргасан.

Санхүүгийн мэдээллийн албанд тайлант хугацаанд банкнаас бусад санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдээс 33 сэжигтэй гүйлгээг ирүүллээ. Өмнөх онд банк бус санхүүгийн болон үнэт цаасны салбарт үйл ажиллагаа явуулдаг мэдээлэх үүрэгтэй этгээдээс сэжигтэй гүйлгээний мэдээлэл ирүүлж байсан бол 2020 онд нотариатч, аудит болон хуульчдаас сэжигтэй гүйлгээний мэдээлэл ирүүлжээ. Үүнээс мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид нь ч мөн өөрсдийн салбар дахь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ач холбогдлыг ойлгож, энэ чиглэлээр арга хэмжээ авч эхэлж байгаатай холбоотой байна.

Хүснэгт 5. Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн сэжигтэй гүйлгээ

№	Үзүүлэлт	2018	2019	2020
1	Банк	1,593	2,370	2,979
2	Бусад МҮЭ	3	15	35
	Нийт	1,596	2,385	3,014

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба


Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тоо тогтмол өсч байгаа нь зохицуулах байгууллагын зүгээс мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн сэжигтэй гүйлгээг болон сэжиглэх үндэслэлүүдийг таниулах сургалт, семинарыг тогтмол зохион байгуулсантай холбоотой. Мөн банкнаас бусад бүх мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд Санхүүгийн мэдээллийн албанаас сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлж байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд зэрэг гарын авлагыг гаргасан.

Түүнчлэн хамтын ажиллагааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас банкуудтай хагас жил бүр тогтмол уулзалт хийн, эргэх холбоог сайжруулан ажилладаг. Уг уулзалтаар

тайлант оны хувьд тайлан хүлээн авахтай холбоотой асуудлуудын талаар, шинээр гарч байгаа мөнгө угаах типологи, сэжигтэй гүйлгээний тайлангийн шинж чанаруудын талаар ярилцаж, мэдээлэл хүргэдэг.

Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангийн эхний 10 сэжиглэх үндэслэлийг доор зургаар харуулав. 2020 онд ирүүлсэн нийт сэжигтэй гүйлгээний тайлангуудын дийлэнх хувийг “Өндөр дүнтэй гүйлгээ хийсэн, харилцагчийн эрхэлж буй үйл ажиллагаа тодорхойгүй эсхүл нийцэхгүй”, “Цахим мөрийтэй, бооцоот тоглоомын үйл ажиллагаа зохион байгуулсан байж болзошгүй”, “Эх үүсвэр тодорхойгүй, эдийн засгийн үндэслэлгүй” гэх үндэслэлээр мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс сэжигтэй гүйлгээний тайланг ирүүлсэн байна.

Зураг 12. Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн Сэжигтэй гүйлгээний тайлан, сэжиглэх үндэслэлээр



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба


2.3 | МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

2.3.1. Дотоодын байгууллагатай мэдээлэл солилцох

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий

байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцон, гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилладаг. Энэ хүрээнд дараах байдлаар мэдээлэл солилцон ажиллалаа.

Зураг 13. Санхүүгийн мэдээллийн албаны дотоодын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцсон байдал



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Мэдээлэл авах зорилгоор дотоодын хууль сахиулах байгууллагуудаас Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн хүсэлтийн тоо болон хүсэлтийн дагуу явуулсан хариуны статистик мэдээг гаргахдаа хүсэлтэд дурдаж байгаа этгээдийн тоогоор гаргадаг бөгөөд тухайн онд ирүүлсэн хүсэлтийн тоо болон явуулсан хариуны зөрүүг 2021 оны эхний улиралд гүйцэтгэв.

Сүүлийн жилд хууль сахиулах байгууллагуудаас Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн хүсэлтийн тоо, хүсэлтийн дагуу явуулсан хариуны тоо өссөн байгаа нь Санхүүгийн мэдээллийн алба болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүн юм.

2.3.2. Гадаадын байгууллагатай мэдээлэл солилцох

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Зөвлөмж 29-д заасны дагуу Эгмонт бүлгээс баталсан "Санхүүгийн мэдээллийн алба хоорондын мэдээлэл солилцох үндсэн зарчим"-ын хүрээнд Эгмонт бүлгийн

гишүүн орнуудын Санхүүгийн мэдээллийн албадтай болон хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан гадаад улсын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажилладаг. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь сүүлийн жилүүдэд дараах байдлаар мэдээлэл солилцон, хамтран ажиллав.

Хүснэгт 6. Санхүүгийн мэдээллийн албаны гадаадын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцсон байдал

Үзүүлэлт /этгээдийн тоогоор/	2017	2018	2019	2020
СМА-аас гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудад явуулсан хүсэлтийн тоо	393	231	238	353
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудад явуулсан хүсэлтийн дагуу ирүүлсэн хариуны тоо	316	193	202	268
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудаас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн тоо	167	126	133	123
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудаас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариуны тоо	151	126	144	112

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллага буюу гадаадын санхүүгийн мэдээллийн албадуудаас мэдээлэл авах чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн хүсэлтийн тоо болон явуулсан хариуны тоо зөрж байгаа нь 2.3.1 хэсэгт дурдсан шалтгаантай адил болно.

2020 онд Санхүүгийн мэдээллийн албанд 6 улсаас 123 этгээдэд холбогдох мэдээлэл хүссэн хүсэлт ирүүлсэн бөгөөд тайлант хугацаанд 4

улсын нийт 112 этгээдэд холбогдох хүсэлтэд хариулсан бол Санхүүгийн мэдээллийн албанаас гадаадын 31 улсын Санхүүгийн мэдээллийн албанд нийт 353 этгээдэд холбогдох мэдээлэл хүссэн хүсэлт явуулж, 30 улсаас 268 этгээдэд холбогдох мэдээлэл, хариуг хүлээн авчээ. 2020 оны хувьд Санхүүгийн мэдээллийн албанаас хамгийн их хүсэлт хүргүүлсэн гурван улс нь БНХАУ, ОХУ, Хонгконг байсан бол ОХУ, БНХАУ, АНУ хамгийн их хүсэлт ирүүлсэн байна.



БҮЛЭГ 3

ДОТООД БА ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

”

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албанаас олон улсын байгууллагууд болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу байгуулагдсан Үндэсний Зөвлөл болон Хамтын Ажиллагааны Зөвлөлийн гишүүн байгууллагууд, хувийн хэвшилтэй хамтран ажиллаж байна.



3.1 | ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

3.1.1. Үндэсний зөвлөл

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн эрх зүйн зохицуулалтыг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 221 дүгээр зүйлд тусгасан байдаг. Энэ хүрээнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, ФАТФ-ын 2016-2017 оны Явцын тайлангийн

техник хэрэгжилтийн үр дүнтэй байдлын үнэлгээг хангах үүднээс анх Үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн захирамжаар баталсан. 2018 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 144 дүгээр захирамжаар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж дараах бүтэцтэй болсон.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД



- Хууль зүй, дотоод хэргийн сайд (Зөвлөлийг даргална)
- Тагнуулын ерөнхий газрын дарга (Орлогч дарга)
- Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны дарга (Нарийн бичгийн дарга)
- Улсын ерөнхий прокурорын орлогч
- Авлигатай тэмцэх газрын дэд дарга
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга
- Сангийн дэд сайд
- Гадаад харилцааны дэд сайд
- Монголбанкны Дэд ерөнхийлөгч
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга
- Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга
- Гаалийн ерөнхий газрын дэд дарга
- Татварын ерөнхий газрын дэд дарга
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22^{1.1}-т заасны дагуу Үндэсний зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд Санхүүгийн мэдээллийн алба нь Үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

1. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, стратеги бүхий хөтөлбөрийн төслийг боловсруулах;
2. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, түүний биелэлтийг үнэлэх, дараагийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах;

3. Зөвлөлийн даргаар дамжуулан Үндэсний хөтөлбөрийн төслийг Засгийн газарт хүргүүлж, батлуулах арга хэмжээг авах;
4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн Үндэсний хөтөлбөрийг шинэчлэн баталах;
5. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлэх

шаардлагатай арга хэмжээний талаарх шийдвэрийг хурлаар хэлэлцэн гаргах;

6. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг зөвлөл жил бүр дүгнэж, Засгийн газарт хүргүүлэх;
7. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах.

Санхүүгийн мэдээллийн албанаас 2020 онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн 2 удаагийн хуралдааныг зохион байгуулсан бөгөөд Үндэсний зөвлөл нь Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

1. Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан зохион байгуулж буй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлын явц, тулгамдаж буй асуудлууд болон цаашид хийгдэх ажлуудын талаар танилцуулж, холбогдох байгууллагуудад тайланг эцэслэн боловсруулах ажлыг эрчимжүүлэх чиглэл өгөв;
2. 2017-2019 онд хэрэгжүүлсэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийн биелэлтийг Санхүүгийн мэдээллийн алба холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн зөвлөлийн гишүүдэд танилцуулсан;
3. ФАТФ-ын стандарт зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг илүү тодорхой болгох зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн ажиллах журам”-ыг боловсруулсан бөгөөд уг журмыг хурлаар хэлэлцүүлж, Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/85 тоот тушаалаар баталсан. Уг журмыг Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудас болох <https://fiu.mongolbank.mn> -д байршуулсан бөгөөд Хавсралт 1-ээс танилцана уу;
4. Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан ФАТФ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлын сайжруулах ажлын төлөвлөгөө"-г боловсруулж, Үндэсний зөвлөлийн даргаар батлуулсан. Энэхүү батлагдсан төлөвлөгөөг Хавсралт 2-оос харна уу. Мөн уг төлөвлөгөөний биелэлтийг Санхүүгийн мэдээллийн албанаас нэгтгэсэн байдлаар зөвлөлийн гишүүдэд танилцуулж, хэлэлцүүлсэн. Үндэсний зөвлөлийн даргаас төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг гишүүн байгууллагуудад үүрэг болгосон;
5. Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайлангийн хүрээнд ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомжийг яаралтай батлуулах шаардлагатай байгааг Санхүүгийн мэдээллийн албанаас онцлон танилцуулсан;
6. ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарах ажлын хүрээнд Ковид-19 цар тахлын нөхцөл байдалд Монгол Улсад хийх газар дээрх хяналт шалгалтын зохион байгуулалтын ажлыг Санхүүгийн мэдээллийн алба хариуцаж, уулзалтад оролцох төр, хувийн хэвшил болон мэргэжлийн холбоодын төлөөлөгчдийн бэлтгэлийг хангаж ажилласан.

САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА (ФАТФ)-ЫН МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ 40 ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИК ХЭРЭГЖИЛТИЙН ДУТАГДЛЫГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙ

ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайланг нэгтгэсэн байдлаар Санхүүгийн мэдээллийн албанаас Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн. Уг тайлангийн хүрээнд “Хэсэгчлэн биелсэн” үнэлгээтэй 1, 8, 14, 28, 35 гэсэн 5 Зөвлөмжийн үнэлгээг ахиулах, 15 дугаар Зөвлөмжийн үнэлгээг хэвээр хадгалах хүсэлтийг гаргасан. 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Харилцан үнэлгээний хорооны ээлжит бус цахим хурлаар 14, 28, 35 гэсэн 3 Зөвлөмжийн үнэлгээг ахиулсан бол 1, 8 дугаар Зөвлөмжийн үнэлгээг

хэвээр үлдээж, 15 дугаар Зөвлөмжийн үнэлгээг хэсэгчилсэн биелэлттэй болгож бууруулсан.

Иймд хэсэгчилсэн биелэлттэй гэсэн үнэлгээтэй 3 Зөвлөмж болон бусад Зөвлөмжийн шалгууруудын үнэлгээг ахиулах зорилгоор “Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулж, Үндэсний зөвлөлийн даргаар 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдөр батлуулсан. Уг төлөвлөгөө нь 2 хэсгээс бүрдсэн бөгөөд 2020 онд дараах байдлаар хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Үүнд:

I. Техник хэрэгжилтийн үнэлгээг сайжруулах хүрээнд хийгдэх ажлууд



ЗӨВЛӨМЖ 1

Монгол Улсын 2020 оны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг эцэслэх

Монгол Улсын санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч тус бүрийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлж, тайланг боловсруулсан бөгөөд салбар тус бүрийн хүрээнд төр, хувийн хэвшил болон холбогдох мэргэжлийн холбоодын төлөөлөгчдийг хамруулсан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Түүнчлэн, Дэлхийн банкны зөвлөхүүдээс эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэхэд санал зөвлөмж авч, хамтран ажилласан. Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэснээр мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аюул заналхийлэл болон эмзэг байдлыг илрүүлж, эрсдэлийг тодорхойлсны үндсэн дээр эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх ач холбогдолтой юм.

Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг батлуулах

Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах Үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байна. Уг төлөвлөгөөнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, зохицуулах, ФАТФ-ын техникийн хэрэгжилт болон үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх асуудлуудыг дэлгэрэнгүй тусгах бөгөөд Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагууд болон бусад холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлж ажиллах болно.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх урьдчилан сэргийлэх журмыг шинэчлэн батлуулах

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 тоот тушаалаар батлагдсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам"-д холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахаар тогтсон. Үүний дүнд эрсдэлийн үнэлгээгээр бага эрсдэлтэй гарсан харилцагчдад хялбаршуулсан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой болно.

“ ЗӨВЛӨМЖ 8

Ашгийн бус байгууллагын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх

Ашгийн бус салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгосноор ашгийн бус байгууллагуудыг терроризмыг санхүүжүүлэхэд ашиглахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Одоогийн байдлаар ашгийн бус байгууллагуудыг төрлөөр нь ангилж, Холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Сангийн эрх зүйн байдлын тухай хууль, Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулан, УИХ-д өргөн барьж батлуулахаар ажиллаж байна.

Ашгийн бус байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх

Ашгийн бус байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн. Ашгийн бус байгууллагуудын үйл ажиллагааны онцлогоос хамааран мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөхөд хялбар байдаг тул уг салбарын эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэл өндөртэй ашгийн бус байгууллагуудыг тодорхойлсон.

Соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах

Терроризмтой тэмцэх зөвлөлөөс НҮБ-ын Терроризмтой тэмцэх албанд 2020 оны 10 дугаар сард ашгийн бус байгууллагын салбарыг терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт мэдээлэл зохион байгуулах тухай хүсэлт тавьж улмаар 3 үе шаттай хөтөлбөр хэрэгжүүлэхээр тогтсон. Ашгийн бус байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх мэдлэг, чадамжийг нэмэгдүүлэх нь тус салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөх эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.

Хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, хяналт шалгалтын арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх

Ашгийн бус байгууллагын салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, хяналт шалгалтын арга хэмжээ болон төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр хэлэлцүүлэг зохиож, холбогдох арга хэмжээг авч байна.

Холбогдох төрийн байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Терроризмтой тэмцэх зөвлөлийн ажлын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар, Татварын ерөнхий газартай хамтран Монгол Улсын Ашгийн бус хуулийн этгээдийн салбарын терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээнд үндэслэн "Төрийн бус байгууллагын бүртгэл, тайлагналт, татвар төлөлт, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, тайлагналт, хариуцлагын эрх зүйн орчин, терроризмыг санхүүжүүлэх ойлголт, урьдчилан сэргийлэх, түүний эрх зүйн орчин"-ы талаарх цахим сургалтыг 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав.

Ашгийн бус байгууллагатай холбоотой мөрдөн шалгах ажиллагааны чадамжийг сайжруулах арга хэмжээ авах

Ашгийн бус байгууллагын салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн мөрдөн шалгах үйл ажиллагааг үр дүнтэй явуулах зорилгоор хууль сахиулах байгууллагуудын албан тушаалтнуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр холбогдох сургалт семинарт хамруулсан байна.

“ ЗӨВЛӨМЖ 15

Виртуал хөрөнгийн үйлчилгээнээс үүсэх мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлох

Виртуал хөрөнгийн үйлчилгээний онцлог шинж чанараас хамааран мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр юм. Иймд бөгөөд өнөөгийн байдлаар өдрөөс өдөрт байнга хөгжиж, өөрчлөгдөж байгаа тул тус салбарын МУТС эрсдэлийн үнэлгээг хийх шаардлагатай байна. Уг эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Ажлын хэсгийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээг дэмжих

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээдтэй холбоотой хуулийн төсөл болон холбогдох судалгааг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-23 тоот тушаалаар байгуулсан. Уг ажлын хэсэгт Санхүүгийн мэдээллийн албанаас орж, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулах, олон улсын туршлагыг судлах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллав.

Хууль эрх зүйн орчныг бий болгох

Санхүүгийн мэдээллийн албанаас Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам болон бусад байгууллагуудтай хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон олон улсын стандарт зөвлөмжид заасан шаардлагыг үндэслэн боловсруулсан.

Хяналт шалгалтын тогтолцоог бий болгох

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд болсноор мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай болно. Хуулийн төсөлд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавихаар зохицуулсан.

Шаардлагатай техник туслалцааг шийдвэрлэх

Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд Олон улсын зөвлөх авах хүсэлт гаргасан бөгөөд 2020 оны 5 дугаар сард холбогдох сонгон шалгаруулалтыг зарласан. Улмаар ФАТФ-ын харилцан үнэлгээний үнэлгээчин, хуульч мэргэжилтэй Англи улсын иргэн Жон МкКендрикийг 2020 оны 6 дугаар сард сонгон шалгаруулсан. Тус зөвлөхтэй хуулийн төслийг боловсруулах чиглэлээр хамтарч ажилласан бөгөөд хуулийн зөвлөх нийтдээ 3 удаа цахим сургалт явуулсан.

Виртуал хөрөнгийн зохицуулалтыг цогцоор нь хийх

Дэвшилтэт технологид суурилсан виртуал хөрөнгийн үйлчилгээ нь Монгол Улсад төдийгүй бусад улс орнуудын хувьд харьцангуй шинэлэг бөгөөд дэлхийн улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохицуулалт хийж эхэлсэн. Иймд Монгол Улсын хувьд энэ төрлийн шинэ үйлчилгээг тусгайлан зохицуулах нь зүйтэй гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан болно.

II. Техник хэрэгжилтийн үнэлгээтэй холбоотой хийгдэх шаардлагатай ажлууд

Зөвлөмжийн шалгуурууд	Хийгдэх ажил	Ач холбогдол
		ЗӨВЛӨМЖ 4
4.1-.4.4	Хөрөнгө хураах болон бусад холбогдох арга хэмжээ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх төрлийн гэмт хэрэгтэй холбогдуулан хураасан хөрөнгө, орлогыг тодорхой зориулалтаар ашиглаж болох эсэхийг судалж, шаардлагатай хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр санал дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Сангийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 65 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс хураасан хөрөнгийг зохицуулах хуулийн төслийг боловсруулсан.
		ЗӨВЛӨМЖ 14
14.2	Хууль бус, зөвшөөрөлгүй мөнгөн болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээг илрүүлж, бүртгэлжүүлэх, шийтгэх тогтолцоог бий болгох	"Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газраас 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөө"-ний дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооноос мөнгөн болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээг хууль бусаар явуулж буй этгээдийг бүртгэж, холбогдох хариуцлагыг авч хэрэгжүүлж байна.

ЗӨВЛӨМЖ 22		
22.3	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид харилцагчийг таньж мэдэх	Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид буюу үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагч, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, нотариатч, хуульч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид мэдээлэх үүрэгтэй этгээд болсноор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон ФАТФ-аас гаргасан стандартын дагуу харилцагчийг таньж мэдэх шаардлагатай.
ЗӨВЛӨМЖ 24		
24.2, 24.15	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон тод байдалтай холбоотой эрсдэлийн үнэлгээг хийх, гадаад хамтын ажиллагааг сайжруулах	Санхүүгийн мэдээллийн албанаас Эцсийн өмчлөгчийн тухай гарын авлагыг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, 5.14.1-д заасан эцсийн өмчлөгчийг шалгаж тогтоох талаар авч хэрэгжүүлэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бэлтгэсэн. Тус гарын авлага нь ФАТФ болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага зэрэг олон улсын байгууллагаас гаргасан эцсийн өмчлөгчийн ил тод байдал, эцсийн өмчлөгчийг нуун дарагдуулах тухай, эцсийн өмчлөгчтэй холбоотой олон улсын туршлага болон итгэлцлийн үйлчилгээний тухай сэдвүүдийг хамарсан.
ЗӨВЛӨМЖ 25		
25.1	Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгчтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох	Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгчтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох талаар хууль тогтоомж, дүрэм журамд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай юм. Энэ хүрээнд холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын саналыг судалж, хамтран ажиллаж байна.
ЗӨВЛӨМЖ 26		
26.3-26.6	Санхүүгийн байгууллагуудын зохицуулалт, хяналт шалгалтын шалгуурт нийцүүлэх, Виртуал хөрөнгөтэй холбоотой хяналт шалгалтын зохицуулалтыг бий болгох	Олон улсын стандарт, зөвлөмжийн дагуу хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Улмаар уг ажлын хэсэг нь виртуал хөрөнгөтэй холбоотой хяналт шалгалтын зохицуулалтыг бий болгох чиглэлээр хуулийн төсөл хяналт шалгалтын талаар тусгасан.
ЗӨВЛӨМЖ 27		
27	Хянан шалгагчдын эрх мэдэл хэсэг дэх Виртуал хөрөнгөтэй холбоотой зохицуулалтыг бий болгох	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөлд тус харилцаанд хяналт тавих эрх бүхий этгээдийг тодорхойлж, хянан шалгагчдын эрх мэдлийг талаарх зохицуулалтыг туссан. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид мэдээлэх үүрэгтэй этгээд болсноор эрсдэлд суурилсан, үр дүнтэй хянан шалгалтыг тус этгээдүүдэд хэрэгжүүлэх шаардлагатай.
ЗӨВЛӨМЖ 28		
28.2-.28.5	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй болсон тул мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай. Иймд энэ салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр тогтмол арга хэмжээ авч ажиллах нь чухал юм.
ЗӨВЛӨМЖ 33		
33.1	Статистик гаргах маягтын дагуу шалгуурт заасан мэдээллийг тогтмол гаргадаг болох	ФАТФ-ын шаардлагын дагуу статистик мэдээллийг нэг загварын дагуу, тогтмол гаргадаг болсноор хууль сахиулах байгууллагуудын мөрдөн шалгах үйл ажиллагаанд ихээхэн дэмжлэг тусалцаа үзүүлдэг. Энэ чиглэлээр хууль сахиулах байгууллагууд холбогдох мэдээллийг санг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.
ЗӨВЛӨМЖ 34		
34.1	Эргэх холбоо	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хүрээнд хамтарч ажиллаж буй бүх байгууллагууд үр дүнтэй эргэх холбоог бий болгосноор дотоод, гадаад хамтын ажиллагааг сайжруулах боломжтой.



“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн ажиллах журам”-ын тухай

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн ажиллах журамд Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, хуралдуулах талаар болон зөвлөлийн чиг үүргийг тодорхойлсон. Тухайлбал:

- Үндэсний зөвлөл нь Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг боловсруулж Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;
- Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар батална;
- Санхүүгийн мэдээллийн алба нь Үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд зөвлөлийн нарийн бичгийн даргаар Санхүүгийн мэдээллийн албаны дарга ажиллана;
- Үндэсний зөвлөлийн ээлжит хурлыг хагас жилд нэг удаа, ээлжит бус хурлыг ажлын албаны санаачилгаар зөвлөлийн даргын зөвшөөрснөөр зарлан хуралдуулна;
- Үндэсний зөвлөл нь ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг болон бусад эрх бүхий олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргийн дагуу хамтран ажиллах, мэдээ, тайланг гаргахтай холбогдох асуудлыг яаралтай шийдвэрлэнэ.

Энэхүү журмыг боловсруулж батлуулснаар ФАТФ-ын дотоод хамтын ажиллагаатай холбоотой Зөвлөмж 2 болон Шууд хэрэгжилт 1-ийг бүрэн биелүүлэх юм.

3.1.2. Хамтын ажиллагааны зөвлөл

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22.1-т заасны дагуу Хамтын ажиллагааны зөвлөл нь Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах

чиглэл үүрэгтэй ажилладаг. Тус зөвлөл нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А-229 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Хамтын ажиллагааны зөвлөлийн бүрэлдэхүүнд дараах байгууллагууд багтдаг.

Зураг 14. Хамтын ажиллагааны гишүүн байгууллагуудын албан тушаалтнуудад шагнал гардуулах ёслол



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зураг 15. Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛ

- Улсын дээд шүүх
- Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх
- Улсын ерөнхий прокурорын газар
- Монголбанк
- Санхүүгийн мэдээллийн алба
- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Санхүүгийн зохицуулах хороо
- Авлигатай тэмцэх газар
- Хууль зүй, дотоод хэргийн яам
- Сангийн яам
- Гадаад харилцааны яам
- Тагнуулын ерөнхий газар
- Терроризмтой тэмцэх зөвлөл
- Цагдаагийн ерөнхий газар
- Улсын бүртгэлийн ерөнхий газар
- Гаалийн ерөнхий газар
- Татварын ерөнхий газар

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР



МОНГОЛБАНК
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



САНГИЙН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛ НЬ ДАРААХ ЧИГ ҮҮРЭГТЭЙ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22.3-т заасны дагуу Санхүүгийн мэдээллийн алба нь Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албаны үүргийг хэрэгжүүлдэг. Хамтын ажиллагааны зөвлөл нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох зөвлөмж, санал гаргах;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг Монгол Улсын хэмжээнд судлах, эрсдэлийн үнэлгээ хийх, үр дүнг тооцох ажиллагааг тогтмол зохион байгуулах;
- Үндэсний эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, үр дүнтэй, оновчтой зохион байгуулах талаар зөвлөмж гаргах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдал, үр дүнгийн талаар мэдээлэл солилцох;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэхтэй танилцаж мөрдүүлэх талаар санал, зөвлөмж гаргах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан дүрэм, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний болон Хамтын ажиллагааны зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих, гүйцэтгэлийн явцтай танилцах, шаардлагатай бол хэрэгжилтийг хангаж ажиллахыг шаардах, гүйцэтгэлийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх, хугацаатай үүрэг даалгавар өгөх, үйл ажиллагааны уялдаа холбоог хангуулах зэрэг холбогдох арга хэмжээг авах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг олон улсын стандарт, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 Зөвлөмжид нийцүүлэх талаар санал гарган танилцуулах;
- Гишүүн байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон бүс нутаг, олон улсын байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажилтай уялдуулахад дэмжлэг үзүүлэх;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэгдэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, хувийн хэвшил болон олон нийтэд зориулсан сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх талаар өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх;
- Санхүүгийн мэдээллийн албаны бүтэц, зохион байгуулалт, төсөв, үйл ажиллагааны зардлын талаар санал гаргах, танилцуулах, шийдвэрлүүлэх;
- Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх Ажлын хэсгийн хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй танилцах, хэрэгжүүлэх санал зөвлөмж, хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах;
- Хамтын ажиллагааны зөвлөлийн гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНД ХЭЛЭЛЦЭЖ ШИЙДВЭРЛЭСЭН ГОЛ АЖЛУУД

Санхүүгийн мэдээллийн алба нь Хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдааныг 2020 онд нийт 6 удаа зохион байгуулж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд ач холбогдолтой дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

1

Монгол улсыг ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу Саарал жагсаалтаас гаргах ажлын хүрээнд:

Монгол Улс ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гарахын тулд ФАТФ-тай тохиролцсон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 6 ажлын явцыг агуулсан Ахицын тайланг Санхүүгийн мэдээллийн албанаас нэгтгэн Ази, Номхон далайн хамтарсан бүлэгт танилцуулж, ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн хурлаар хэлэлцүүлсэн. Уг ажлын хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөл нь дараах асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэв. Үүнд:

- Монгол Улсыг ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргах чиглэлээр 2020 оны 1 дүгээр сарын 16-21-ний өдрүүдэд БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн уулзалтаар Ахицын тайланг танилцуулан, 3 ажлыг хангалттай биелүүлсэн үнэлгээ авсан талаар хэлэлцэж, улмаар Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлд танилцуулахаар болсон;
- Монгол Улсыг ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргах хүрээнд Монгол улс Ази, Номхон далайн хамтарсан бүлэгтэй 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдөр цахим хурал зохион байгуулахаар болсон бөгөөд уг хүрээнд хийгдэх шаардлагатай бэлтгэл ажлуудыг Санхүүгийн мэдээллийн албанаас танилцуулж, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүдээс холбогдох саналуудыг авсан. Улмаар Ази, номхон далайн хамтарсан бүлэгтэй цахим хурлыг амжилттай зохион байгуулж, үлдсэн 3 төлөвлөгөөт ажлын явцыг тусгасан Ахицын тайланг амжилттай танилцуулж, хамгаалав;

Ковид-19 цар тахлын үед ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтыг биечлэн зохион байгуулах боломжгүйн улмаас хойшлогдох нөхцөл байдал үүссэн. Гэвч Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс удаа дараа хүсэлт тавьсны үндсэн дээр уг уулзалтыг 2020 оны 10 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд зохион байгуулахаар болсон. Үүнтэй холбоотойгоор Шадар сайдын ахалсан Ажлын хэсэг байгуулагдаж, газар дээрх хяналт шалгалтын бэлтгэл ажлыг амжилттай хангав. Уг газар дээрх хяналт шалгалттай холбоотой ажлын хүрээнд Хамтын ажиллагааны зөвлөлөөр дараах асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэв. Үүнд:

- Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүд Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулж, Сангийн сайдын 2020 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 151 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан "ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг хүлээв.

- ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх ажлын хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллага тус бүрт газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх асуулт хариулт, зөвлөмжийг багтаасан гарын авлагыг бэлтгэж Зөвлөлийн хурал дээр тараасан. Мөн Санхүүгийн мэдээллийн

албанаас газар дээрх хяналт шалгалтын зохион байгуулалтыг Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэхээр тогтсон ба олон улсын зөвлөхүүдтэй хамтран ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх цахим ярилцлагыг зохион байгуулсан.

2

ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-ын 40 Зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлуудыг багтаасан Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайланг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж 2020 оны 2 дугаар сарын 01-ний өдөр Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн. Тус тайланг хүргүүлэхдээ нийт хэсэгчлэн биелсэн үнэлгээтэй 5 Зөвлөмжийн үнэлгээг ахиулж, 1 Зөвлөмжийн үнэлгээг хэвээр хадгалах хүсэлтийг гаргасан. Энэ хүрээнд Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайлантай холбоотой дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэв. Үүнд:

- Хамтын ажиллагааны зөвлөлийн хурлаар Санхүүгийн мэдээллийн албанаас Явцын тайлангийн хүрээнд хийгдэх шаардлагатай ажлуудыг танилцуулж, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудаас холбогдох тайланг ирүүлэх болон нэгтгэх ажлыг хариуцаж хийв;
- Санхүүгийн мэдээллийн албанаас зөвлөлийн гишүүдэд Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайлангийн хүрээнд ФАТФ-ын 1, 8, 14, 15, 28 болон 35 дугаар Зөвлөмжүүдийн үнэлгээг ахиулах чиглэлээр байгууллага тус бүрийн хийх шаардлагатай ажлуудыг танилцуулав;
- Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулж, 2020 оны 5 дугаар сард Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргаар батлуулсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн ажиллах журам" болон "ФАТФ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн Техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө" болон уг төлөвлөгөөнөөс өөрсдийн байгууллагуудад хамаарах ажлуудтай Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүд танилцаж, төлөвлөгөөт ажлуудыг биелүүлэх үүрэг хүлээв.
- Санхүүгийн мэдээллийн албанаас Хамтын ажиллагааны зөвлөлийн хурлаар ФАТФ-ын Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2020 оны 8 дугаар сард нийтэлсэн Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайланг хэлэлцэж, үнэлгээг ахиулсан тухай болон ахиулах шаардлагатай үлдсэн зөвлөмжүүдийн талаар танилцуулав.
- Монгол Улсын 2021 оны Явцын тайланг хүргүүлэх хүрээнд Зөвлөмж 1, 8, 15-ын үнэлгээг ахиулахын тулд хийгдэх шаардлагатай ажлуудыг хэлэлцэв. Тухайлбал, Зөвлөмж 1-ийн хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлын явц болон тулгамдаж буй асуудлуудыг танилцуулав. Зөвлөмж 8-ын үнэлгээг ахиулах хүрээнд ашгийн бус байгууллагын салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг явуулах чиглэлээр хийх шаардлагатай ажлуудыг хэлэлцэв.

- ФАТФ-ын Зөвлөмж 15 буюу Шинэ технологийн талаарх стандарт шинэчлэгдсэнтэй холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-23 дугаартай тушаалаар “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх этгээдтэй холбоотой хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг судлах, олон улсын стандарт, зөвлөмжийн дагуу хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, холбогдох хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах” чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулсан. Тус ажлын хэсэгт Санхүүгийн мэдээллийн албанаас оролцон ажиллаж, холбогдох байгууллагуудтай хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулан Хамтын ажиллагааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, санал авсан.

3

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх хүрээнд:

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд ФАТФ-ын Зөвлөмж 1-т заасны дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж, уг үнэлгээний үр дүнд суурилан Үндэсний хөтөлбөрийг боловсруулахаар заасан. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу хийх, эрсдэлийн үнэлгээнд суурилсан эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг 2020 онд гүйцэтгэсэн бөгөөд Хамтын ажиллагааны зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

- Хамтын ажиллагааны зөвлөлд Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс 2020 онд хийгдэж эхэлсэн Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний талаар танилцуулж, уг ажлын хүрээнд Дэлхийн банкны зөвлөхүүдтэй хамтарч ажиллаж байгаа тухай мэдээлэв;
- Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг Сангийн сайдын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаартай тушаалаар байгуулсан. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө болон хуваарийг Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүдэд танилцуулж, зохион байгуулалтыг хариуцахаар болсон;
- Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх ажлын явцад Санхүүгийн мэдээллийн албанаас дата мэдээлэл цуглуулах тал дээр бүх гишүүн байгууллагаас тусалж дэмжин, хамтарч ажиллахыг хүсэв;
- Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлын явцын талаар Санхүүгийн мэдээллийн албанаас Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүдэд танилцуулж, холбогдох ажилтнуудад анхаарч ажиллах үүрэг чиглэл өгөхийг хүсэв;

4

Соён гэгээрүүлэх болон бусад үйл тогтолцоог сайжруулах хүрээнд:

- Санхүүгийн мэдээллийн албанаас зөвлөлийн гишүүн байгууллагуудын Харилцан үнэлгээ хийх мэргэжилтэн бэлтгэх сургалтад нэр дэвших албан тушаалтнуудын мэдээллийг нэгтгэж, Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн.


Монгол Улсаас Харилцан үнэлгээ хийх мэргэжилтэн бэлтгэснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх, мэдлэг чадвар бүхий боловсон хүчинг бэлтгэх ач холбогдолтой юм.

- Санхүүгийн мэдээллийн албанаас Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А-27 тоот тушаалаар батлагдсан Санхүүгийн мэдээллийн албаны бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн талаар танилцуулсан. Санхүүгийн мэдээллийн албаны шинэчилсэн бүтэц зохион байгуулалтаар Үйл ажиллагааны болон Бодлого хэрэгжилт, хамтын ажиллагааны гэсэн 2 хэлтэстэй болсон.
- 2020 онд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай нэгдсэн мэдээллийг байршуулах, соён гэгээрүүлэх чиг үүрэг бүхий нэгдсэн цахим хуудастай болох саналыг Хамтын ажиллагааны зөвлөлийн хурлаар дэвшүүлсний дагуу www.amlcft.mn цахим хуудсыг Санхүүгийн мэдээллийн алба хариуцан ажиллуулсан. Уг цахим хуудсанд Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд тус цахим хуудсанд нийтлэх мэдээ, мэдээллийг бэлтгэн Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлдэг болсон. Уг цахим хуудас нь иргэд, төрийн байгууллагуудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой соён

гэгээрүүлэх шинэлэг мэдээ мэдээллийг цаг тутам хүргэх ач тустай юм.

- Монголын банкны холбоон дээр зохион байгуулагдсан “Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа болон мэдээлэл солилцох нь” сэдэвт хэлэлцүүлгийн хүрээнд хөндөгдсөн асуудлуудыг гишүүд хэлэлцсэн;
- Банкуудын дансны хуулгыг нэг загвартай болгох асуудал дээр Санхүүгийн мэдээллийн албанаас Монголбанк болон хууль сахиулах байгууллагуудтай хамтарч ажиллахаар шийдсэн ба уг ажил нь хийгдсэнээр Санхүүгийн мэдээллийн албанд хууль сахиулах байгууллагуудаас ирэх мэдээлэл нь тогтсон жишигтэй болж, хянан шалгагчидад сэжигэй гүйлгээнүүдэд дүн шинжилгээ илүү үр дүнтэй хийх тогтолцоог бүрдүүлэх юм.
- Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд өргөн хэрэглэгддэг нэр томъёо, товчлолыг бүх байгууллагуудын хүрээнд нэгэн жигд ашигладаг байх зорилгоор нийт 27 нэр томъёо, товчлолыг Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүдэд танилцуулж, нэр томъёоны жагсаалтыг зөвлөлийн хурлаар батлав. Уг нэр томъёонуудыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд тайлан, мэдээлэл солилцоонд хэрэглэдэг болсон нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээнд хийгдэж буй байгууллагуудын хамтын ажиллагаанд ач тустай юм.

Зураг 16. . Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдсан байдал /2020 он/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

3.2 | ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

3.2.1. ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг болон Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг



ФАТФ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэх, дэлхийн санхүүгийн системийг хамгаалах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газар хоорондын хараат бус байгууллага юм.

■ 2020.01.20

ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг болон Ази, Номхон далайн хамтарсан бүлэгтэй хамтран БНХАУ-ын Бээжин хотод уулзалт зохион байгуулсан бөгөөд уг хурлаар үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг багтаасан Ахицын тайланг амжилттай танилцуулж, хамгаалав.

■ 2020.02.16-21

ФАТФ-ын 2020 оны 02 дугаар сарын 16-21-ний өдрүүдэд Франц Улсын Парис хотод зохион байгуулсан ээлжит чуулганд Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөгч биечлэн оролцсон бөгөөд Монгол Улсыг ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргахтай холбоотой ажлын үйл явцын талаар мэдээлж, Монгол Улсад хийх газар дээрх хяналт шалгалттай холботой Сангийн сайдын албан хүсэлтийг уламжлав.

■ 2020.05.11

ФАТФ-ын Саарал жагсаалтаас Монгол Улсыг гаргах ажлын хүрээнд өгөгдсөн 6 үүрэг даалгаврыг биелүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгасан Ахицын тайланг ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн цахим уулзалтаар амжилттай танилцуулж, хамгаалав.

■ 2020.06.24

Ковид-19 цар тахлын улмаас ФАТФ-аас ээлжит чуулга уулзалтуудаа цахимаар хийхээр шийдвэрлэсэн бөгөөд 2020 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралд Санхүүгийн мэдээллийн алба болон холбогдох байгууллагуудын төлөөлөгчид цахимаар оролцсон.

ФАТФ-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үүргийн дагуу Монгол Улс тогтмол идэвхтэй хамтран ажиллаж байна. Улмаар уг байгууллагтай 2020 онд дараах байдлаар хамтарч ажилласан. Үүнд:

■ 2020.07.27

ФАТФ-аас 2020 оны 6 дугаар сард гаргасан "Мөнгө угаах болон зэрлэг ан амьтдын хууль бус худалдаа" сэдэвт тайланг танилцуулж, зэрлэг ан амьтдыг хамарсан гэмт хэргийн типологи, бодит жишээнүүдийг оролцогчидтой хэлэлцсэн.

■ 2020.10.01-02

ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтыг Монгол Улсад зохион байгуулсан бөгөөд төрийн 22 байгууллага, 19 аж ахуйн нэгж, 4 мэргэжлийн холбоод, хувиараа бизнес эрхлэгчдийн төлөөллөөс бүрдсэн нийт 140 гаруй хүн оролцож, үйл ажиллагааны төлөвлөгөөний 6 ажлын амжилттай хамгаалсан.

■ 2020.10.13

ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн цахим уулзалтаар гишүүн улс орнуудын төлөөлөгчид Монгол Улсын гаргасан ахиц дэвшлийг хэлэлцэж, үнэлгээний багийн шийдвэрийг бүрэн дэмжэн.

■ 2020.10.23


ФАТФ-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан чуулганаар Монгол Улсыг ФАТФ-ын Саарал жагсаалт буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргахаар шийдвэрлэсэн талаар албан ёсоор мэдэгдэв.

ФАТФ-ЫН ГИШҮҮН ОРНУУД



ФАТФ-ын төрлийн, бүс нутгийн хэмжээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэг бүхий Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг нь 1997 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улс 2004 онд гишүүнээр нь элссэн. ФАТФ-аас гишүүн улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлж, харилцан үнэлгээний тайлан гаргадаг.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсаас ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2020 оны 02 дугаар сард хүргүүлсэн. Улмаар Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Харилцан үнэлгээний хорооны цахим хурлыг 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулж, Монгол Улсын зүгээс техник хэрэгжилтийн 5 зөвлөмжийн үнэлгээг ахиулж, 1 зөвлөмжийн үнэлгээг хэвээр үлдээх хүсэлт гаргасныг хэлэлцсэн бөгөөд 3 зөвлөмжийн үнэлгээг ахиулахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайланг эцэслэн баталж, 2020 оны 8 дугаар сард нийтэлсэн.



Үүнээс гадна Санхүүгийн мэдээллийн албанаас Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс зохион байгуулдаг сургалтад хамрагдах, бусад улс орнуудын тайлантай танилцаж, санал өгөх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой ирүүлсэн санал асуулга бөглөх, сайн туршлага, типологи, бодит жишээг хуваалцах, шаардлагатай бусад мэдээллийг хүргүүлэх байдлаар тогтмол хамтарч ажилласан. Тухайлбал, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2020 оны 7 дугаар сард ирүүлсэн Ковид-19 цар тахалтай холбоотой асуулгыг Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудын саналыг нэгтгэн хариу хүргүүлсэн болно.

Холбоос: <http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/fur/APG-3rd-Follow-Up%20Report-Mongolia-2020.pdf>

АЗИ, НОМХОН ДАЛАЙН МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ БҮЛГИЙН ГИШҮҮН ОРНУУД



Монгол Улс 2012 оны 5 дугаар сард Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн ажиглагчаар нэгдсэн. Тухайн үеэс хойших хугацаанд Монгол Улс уг байгууллагатай тогтмол хамтран ажиллаж, санхүүгийн дүн шинжилгээ, типологи, сайн туршлага зэрэг асуудлуудын хүрээнд мэдээллээр солилцсон. Тухайлбал, Санхүүгийн мэдээллийн албанаас Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр болсон 33 дахь чуулга уулзалтад оролцов. Түүнчлэн, Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн ажлын албанаас гаргасан санаачилгаар Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүн орнуудтай ойр байршдаг улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийх ажилд Монгол Улс идэвхтэй оролцсоныг өндрөөр үнэлсэн.

3.2.2. Эгмонт бүлэг



Дэлхийн 166 орны санхүүгийн мэдээллийн албадын олон улсын нийгэмлэг болох Эгмонт бүлэгт Монгол Улс

2009 онд гишүүнээр элссэн. Эгмонт бүлэг нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор өөрийн гишүүн улс орнуудын дунд туршлага судлах, санхүүгийн мэдлэг, мэдээлэл солилцох боломжийг олгодог. Иймд Санхүүгийн мэдээллийн алба нь тус нийгэмлэгийн гишүүний хувиар үндэсний болон олон улсын хэмжээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, олон улсын стандартын дагуу мэдээлэл


солилцон ажиллаж байна.

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Зөвлөмж 29-д заасны дагуу Эгмонт бүлгээс баталсан "Санхүүгийн мэдээллийн алба хоорондын мэдээлэл солилцох үндсэн зарчим"-ын хүрээнд Эгмонт бүлгийн гишүүн орнуудын Санхүүгийн мэдээллийн албадтай болон хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан гадаад улсын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажилладаг. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь сүүлийн жилүүдэд дараах байдлаар мэдээлэл солилцон, хамтран ажиллав.

Хүснэгт 7. Эгмонт бүлгийн гишүүн гадаадын Санхүүгийн мэдээллийн албадуудтай мэдээлэл солилцсон байдал

Үзүүлэлт /этгээдийн тоогоор/	2017	2018	2019	2020
СМА-аас гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудад явуулсан хүсэлтийн тоо	393	231	238	353
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудад явуулсан хүсэлтийн дагуу ирүүлсэн хариуны тоо	316	193	202	268
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудаас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн тоо	167	126	133	123
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудаас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариуны тоо	151	126	144	112

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба



3.2.3. Харилцан ойлголцлын санамж бичиг

Санхүүгийн мэдээллийн алба нь одоогийн байдлаар нийт 19 орны Санхүүгийн мэдээллийн албатай хоёр талын мэдээлэл солилцох харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан

хамтран ажиллаж байна. Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан улс орнуудын жагсаалтыг Хүснэгт 8-аас харна уу.

Хүснэгт 8. Бусад орны Санхүүгийн мэдээллийн албадуудтай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн жагсаалт

		
Турк Улсын Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах алба	БНХАУ-ын Мөнгө угаахтай тэмцэх хяналт, дүн шинжилгээний төв	Афганистан Улсын Санхүүгийн гүйлгээ болон тайлангийн дүн шинжилгээний төв
		
Малайз Улсын Санхүүгийн тагнуулын алба	Украин Улсын Төрийн санхүүгийн хяналт шалгалтын газар	Бангладеш Улсын Санхүүгийн тагнуулын алба
		
Мексик Улсын Санхүүгийн тагнуулын алба	Балба Улсын Санхүүгийн мэдээллийн алба	Словени Улсын Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх алба
		
Япон Улсын Санхүүгийн мэдээллийн төв	Беларусь Улсын Төрийн хяналтын хорооны Санхүүгийн хяналтын газар	Филиппин Улсын Мөнгө угаахтай тэмцэх зөвлөл
		
Шри-Ланка Улсын Санхүүгийн тагнуулын алба	Молдова Улсын Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх газар	Казахстан Улсын Сангийн яамны Санхүүгийн хяналтын хороо
		
Өмнөд Солонгос Улсын Санхүүгийн тагнуулын алба	Киргиз Улсын Төрийн санхүүгийн тагнуулын алба	
		
ОХУ-ын Санхүүгийн хяналтын алба	Тайванийн Мөнгө угаахтай тэмцэх хэлтэс	

3.2.4 | Олон улсын хамтын ажиллагаа

Санхүүгийн мэдээллийн алба нь олон улсын донор байгууллагуудтай техник туслалцааны хүрээнд идэвхтэй хамтран ажилладаг бөгөөд 2020 онд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон АНУ-ын Сангийн яамтай техник туслалцаа, төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд хамтран ажиллав.

Азийн Хөгжлийн Банк

Азийн хөгжлийн банкнаас макро эдийн засгийг дэмжих техник туслалцааг хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх, Монгол Улсыг ФАТФ-ын Саарал жагсаалтаас гаргах чиглэлээр Азийн хөгжлийн банкны

зөвлөхтэй хамтран ажиллаж, Монгол Улсад өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэх чиглэлээр хийгдэх ажлуудыг тодорхойлох, ФАТФ-т хүргүүлэх Ахицын тайлангуудад санал авах, тайланг амжилттай хамгаалахад бэлтгэх цахим ярилцлагуудыг хийж, зөвлөгөө авч ажилласан.

Дэлхийн Банк

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг 2020 оны туршид Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн нийт 52 байгууллагын 128 төлөөлөгчөөс бүрдсэн ажлын хэсэг хийж гүйцэтгэв. Дэлхийн банкны аргачлалын дагуу үндсэн ажлын хэсгээс гадна салбар бүрийн эрсдэлийг үнэлэх нийт 11 дэд ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Дэлхийн банкнаас нийт ажлын хэсгийн гишүүдэд болон

дэд ажлын хэсэг тус бүрт эрсдэлийн үнэлгээ хийх цахим сургалтуудыг зохион байгуулсан.

Тухайлбал, Дэлхийн банкны зөвлөхүүд 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хооронд Үндэсний эрсдэлийн үнэлгээний дэд ажлын хэсгийн гишүүдэд салбар тус бүрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний тухай цахим сургалт зохион байгуулсан.

Хүснэгт 9. Дэлхийн банкны зөвлөхүүдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний цахим сургалт хийсэн хуваарь

Огноо	Цахим уулзалт
2020.04.30	Даатгал, үнэт цаасны салбарын эмзэг байдлын үнэлгээ
2020.05.05	Банк бус санхүүгийн байгууллагууд болон хадгаламж зээлийн хоршооны салбарын эмзэг байдлын үнэлгээ
2020.05.06	Санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээ
2020.05.13	Банкны салбарын эмзэг байдлын үнэлгээ
2020.05.15	Мөнгө угаах аюул заналхийллийн үнэлгээ
2020.05.19	Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ Ашгийн бус байгууллагын эмзэг байдлын үнэлгээ
2020.05.20	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийн үнэлгээ
2020.05.21	Үндэсний эмзэг байдлын үнэлгээ

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Түүнчлэн Дэлхийн банкны дэргэдэх хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (Stolen Asset Recovery Initiative)-ын хүрээнд

хууль сахиулах байгууллагуудын санхүүгийн гэмт хэргийн мөрдөн шалгалтыг хийх чадамж, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтарч ажилласан.

Үүнээс гадна Дэлхийн банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслөөс 2017-2020 онд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, стратегийн дутагдлыг арилгах үйл ажиллагааны хүрээнд хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хүний

нөөцийн чадавхыг бэхжүүлэх, уулзалт албан ёсны арга хэмжээг санхүүжүүлэх чиглэлээр тогтмол дэмжиж, хамтран ажилласан. Тухайлбал ФАТФ-ын Саарал жагсаалтаас Монгол Улсыг гаргах ажил болон виртуал хөрөнгийн зохицуулалтыг бий болгоход ихээхэн дэмжлэг туслалцаа үзүүлсэн.

АНУ-ын Сангийн Яам

Санхүүгийн мэдээллийн алба нь 2018 онд АНУ-ын Сангийн яамны Техник туслалцааны газартай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэ хүрээнд АНУ-ын Сангийн яамны Техник туслалцааны газраас мөнгө угаахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх сайн туршлагыг нэвтрүүлэх, Санхүүгийн мэдээллийн алба болон хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр ажиллав. Техник туслалцааны газрын зөвлөх Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Санхүүгийн мэдээллийн албанд цахимаар сургалт, зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна.

Түүнчлэн дээр дурдсанчлан Монгол Улсад 2020 оны 10 дугаар сард ФАТФ-аас хийсэн газар дээрх хяналт шалгалтад АНУ-ын Сангийн яамны Бодлогын ахлах зөвлөх Сабина Кук биечлэн оролцож, идэвхтэй хамтарч ажилласан. Мөн АНУ-ын Сангийн яамнаас Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагаанд зориулж GoAML програм хангамжийг худалдан авахад санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлсэн. Санхүүгийн мэдээллийн алба уг программыг өдөр тутмын үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлснээр мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс мэдээлэл хүлээн авах, тус мэдээлэл дээр дүн

Зураг 18. Монголбанкны удирдлагууд АНУ-ын Элчин Сайд Майкл С.Клеческийг хүлээн авч уулзав. /2020.04.29/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

шинжилгээ хийх болон холбогдох мэдээллийн сан үүсгэхэд мэдээллийн аюулгүйн байдлыг хангах, мэдээлэл солилцооны хурдыг нэмэгдүүлэх болон нэгдсэн системтэй болох боломжтой юм. Үүнээс гадна энэхүү програмыг ашигласнаар хуульд заасан бүх мэдээлэх үүрэгтэй этгээд Санхүүгийн мэдээллийн албанд тайлан, мэдээллийг цахимаар мэдээлэх, Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, Гадаад төлбөр

тооцооны гүйлгээний тайлан болон Сэжигтэй гүйлгээний чанар сайжрах, хууль сахиулах байгууллагууд руу шилжүүлэх мэдээллийн чанар, тоо нэмэгдэх, улмаар МУТС гэмт хэрэгтэй холбоотой мөрдөн шалгах, яллах, шүүх үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой юм. 2020 оны эцсийн байдлаар GoAML-ийг нэвтрүүлэх ажил нь дунд шатандаа явж байна.



БҮЛЭГ 4

ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ, СОЁН
ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

”




ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэргэжлийн сургалт, семинарт байнга хамрагдахаас гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэх үүрэгтэй этгээд болон олон нийтэд

зориулсан соён гэгээрүүлэх ажлуудыг ч мөн зохион байгуулав. 2020 оны хувьд дэлхий дахинд гарсан цар тахалтай холбоотойгоор гадаад улсад зохион байгуулж байгаа сургалт, семинарт биечлэн хамрагдах боломж байхгүй байсан ч холбогдох сургалт, семинарт цахим хэлбэрээр цаг алдалгүй оролцлоо.

Зураг 19. Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2017-2020/




Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

4.1 САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНААС ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН СУРГАЛТ, СЕМИНАР

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд холбогдох байгууллагуудын хүчин чармайлтаас гадна олон нийт энэ талын мэдлэг, боловсролтой байх нь мөн адил чухал ач холбогдолтой байдаг. Санхүүгийн мэдээллийн албаны хувьд хамтран


ажилладаг байгууллагууд, мэдээлэх үүрэгтэй этгээдүүд болон олон нийтэд чиглэсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх ажлыг манлайлан зохион байгуулж оролцдог.

Зураг 20. Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2017-2020/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Зураг 21. Бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2017-2020/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх сургалт, семинарын тоо болон оролцогчдын тоо өмнөх оноос бага зэрэг буурсан байгаа нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дотооддоо хөл хориог тогтоон

танхимын сургалт хойшилж, цуцлагдаж байсантай холбоотой.

Дээр дурдсан Санхүүгийн мэдээллийн алба болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинараас онцлон дурдвал:

I улирал	- Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх Судалгаа, дүн шинжилгээний ажлын хэсгийн танилцуулга уулзалт дээр хийсэн банкуудын комплаенсийн нэгжийн 70 гаруй ажилтнуудад сэжигтэй гүйлгээний талаарх танилцуулга; - Санхүүгийн мэдээллийн албанаас банк бус санхүүгийн байгууллагын 120 гаруй ажилтнуудад "Сэжигтэй гүйлгээг хэрхэн тайлагнах вэ?" сэдэвт сургалт; - Санхүүгийн мэдээллийн алба болон Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт хамтран тус салбарын 15 хянан шалгагч нарт хяналт шалгалтын ахисан шатны сургалт; - Санхүүгийн мэдээллийн албанаас Хөгжлийн банкны 30 гаруй ажилтнуудад зориулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Хөгжлийн банкны оролцоо сэдвээр сургалт;
II улирал	- Санхүүгийн мэдээллийн алба болон Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт хамтран ПрайсоутерхаусКүперс ХХК-ийн 20 гаруй ажилтнуудад мэдээлэх үүргийг таниулах чиглэлээрх сургалт; - Санхүүгийн мэдээллийн алба болон Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт хамтран аудитын үйл ажиллагаа явуулдаг компаниудын 70 гаруй ажилтнуудад мэдээлэх үүргийг таниулах чиглэлээрх сургалт;
III улирал	- Санхүүгийн мэдээллийн алба болон Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэхэд анхаарах асуудлаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын ажилтнуудад сургалт; - Санхүүгийн мэдээллийн алба болон Терроризмтой тэмцэх зөвлөл, Сангийн яам, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт хамтран 125 гаруй татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд сэжигтэй гүйлгээг мэдээлэх тухай сургалт; - Санхүүгийн мэдээллийн алба болон Гаалийн ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Дорноговь аймгийн Замын-Үүд боомт, Ханги боомт, Өмнөговь аймгийн Гашуун сухайт боомтын 35 гаруй ажилтнуудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хил, гаалийн байгууллагын оролцооны талаарх сургалт; - Санхүүгийн мэдээллийн албанаас АНУ-ын зөвлөхтэй хамтран санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хяналт тавих чиг үүрэгтэй Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий өөрийгөө зохицуулах байгууллагууд буюу Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын Нотариатчдын Танхим болон Монголын Хуульчдын Холбооны хянан шалгагчдад зориулан "Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх" сэдэвт сургалт; - Санхүүгийн мэдээллийн алба болон Монголын банкны холбоо, Сангийн яам хамтран банкны комплаенсын 100 гаруй албан хаагч нарт ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын тухай сургалтыг тус тус зохион байгууллаа.
IV улирал	Санхүүгийн мэдээллийн алба болон Олон улсын комплаенсийн холбоо, Европын сэргээн босголт хөгжлийн банк хамтран "Харилцагчийг таньж мэдэх нь", "Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг" сэдвээр 4 өдрийн семинар.

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь мэдээлэх үүрэгтэй этгээдийн сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор сэжигтэй гүйлгээнд хийсэн дүн шинжилгээний талаарх ерөнхий мэдээлэл, сэжигтэй гүйлгээний нийтлэг хэв шинж, арга хэлбэрийн талаар тогтмол мэдээлэх чиг үүрэгтэй байдаг. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас хагас жил бүр банкуудын холбогдох ажилтнуудтай уулзалтыг төлөвлөн, зохион

байгуулдаг. Энэ оны хувьд 2, 3 дугаар улиралд багтаан Ариг банк, Капитрон банк, Кредит банк, Богд банк, Тээвэр Хөгжлийн банк, Үндэсний Хөрөнгө оруулалтын банк, Төрийн банк, Хас банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны холбогдох ажилтнуудтай уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар тайлант хугацаанд банкуудын ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо, чанарын үзүүлэлт, хууль сахиулах байгууллагуудад шилжүүлсэн мэдээлэл, гүйлгээний хэв шинж хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар болон бусад холбогдох мэдээллийг танилцуулж, санал хүсэлт, тулгарч байгаа асуудлуудыг авч хэлэлцэв.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ АЖИЛТНУУДЫН ХАМРАГДСАН СУРГАЛТ, СЕМИНАР

Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд 2020 онд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн мэргэжлийн сургалт, семинаруудад цахим хэлбэрээр идэвхтэй оролцлоо. Мөн АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны хөтөлбөрийн хүрээнд


шинжээчдийн чадавхыг бэхжүүлэх, сүүлийн үеийн чиг хандлагын талаар мэдлэг боловсролоо дээшлүүлэх зорилгоор үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна. Ажилтнуудын хамрагдсан сургалт семинарын мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10. Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын сургалт, семинарт хамрагдсан байдал хуваарь

	2017	2018	2019	2020
Ажилтнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хамрагдсан сургалт, семинарын тоо	9	23	23	33
Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр сургалт, семинарт хамрагдсан ажилтнуудын тоо (давхацсан байдлаар)	23	73	63	75

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Зураг 22. Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хамрагдсан гадаад, дотоод сургалт, семинарын мэдээлэл



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Энэ онд Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын хамрагдсан сургалт, семинараас онцлон дурдвал:

Гадаад сургалт	• Ковид-19 цар тахал гарахаас өмнө НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газраас Итали улсын Ром хотод зохион байгуулсан “Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх нь” сэдэвт сургалтад Санхүүгийн мэдээллийн албаны ахлах шинжээч оролцов; • АНУ-ын Элчин сайдын яам, АНУ-ын Сангийн яам, ХонгКонг дахь АНУ-ын консулын газар, Авлигатай тэмцэх газраас хамтран “Санхүүгийн мөрдөн шалгах техник” сэдвээр шинжээч, хянан шалгагч нарт семинар; • Дэлхийн банкны зөвлөхүүдийн “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ”-ний нийт 11 дэд ажлын хэсгийн салбарын үнэлгээ хийхтэй холбоотой сургалтууд; • АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн албаны нийт ажилтнуудад зориулсан аюулгүй байдал, нууцлал хамгааллын тухай сургалт; • Эгмонт бүлгийн Мэдээлэл солилцох ажлын хэсгээс 2020-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай семинар; • Эгмонт бүлгээс зохион байгуулсан “Виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эмзэг байдал, тус салбарын ФАТФ-ын стандартын нөлөөг шинэчлэн өөрчлөх” сэдвээр удирдлагуудад сургалт; • Эгмонт бүлгээс зохион байгуулсан “Гар утасны төлбөрийн үйлчилгээний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эмзэг байдал” сэдвээр удирдлагуудад зориулсан сургалт; • Эгмонт бүлгээс зохион байгуулсан Санхүүгийн мэдээллийн албаны бүх ажилтнуудад “Ковид-19 цар тахлын үеийн дэлхийн улс орнуудын Санхүүгийн мэдээллийн албадуудын шилдэг туршлага” болон “Зэрлэг ан амьтадтай холбоотой санхүүгийн гэмт хэргийн тухай” сэдэвт сургалт; • Эгмонт бүлгээс зохион байгуулсан Санхүүгийн мэдээллийн албаны бүх ажилтнуудад “Үндэсний эрсдэлийн үнэлгээнд Санхүүгийн мэдээллийн албаны гүйцэтгэх үүрэг” сэдвээр сургалт; • ФАТФ-аас “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд Ковид-19-ийн үзүүлж байгаа нөлөө”, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг илрүүлэхэд Ковид-19-ийн үзүүлсэн нөлөө” сэдвээр сургалт; • Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хянан тавих чиг үүрэгтэй Санхүүгийн зохицуулах хороо, мэргэжлийн холбоодын хянан шалгагч мэргэжилтнүүдэд зориулж АНУ-ын Сангийн яамны зөвлөх “Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн хяналт шалгалтын тухай”, “Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр” болон “Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хийх хяналт шалгалт” сэдвүүдээр 3 өдрийн сургалт; • НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас goAML програмын талаарх сургалт; • Дэлхийн банкны зөвлөхүүд “Крипто хөрөнгө ба олон улсын хууль эрх зүйн орчин”, “ФАТФ-ын Зөвлөмж 15, Монгол Улсын хууль эрх зүйн орчны сул талууд”, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөлд өгөх санал, зөвлөмж” сэдвээр сургалтууд; • Олон улсын комплаенсийн холбоо, Европын сэргээн босголт хөгжлийн банкаас “Харилцагчийг таньж мэдэх нь”, “Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг” сэдвээр 4 өдрийн семинар; • Бусад цахим сургалт, семинарт тус тус хамрагдсан байна.
Дотоод сургалт	• Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудад Татварын ерөнхий газраас “Татварын хяналт шалгалтын тухай” сэдэвт сургалт; • Санхүүгийн мэдээллийн албаны нийт ажилтнуудад Улсын ерөнхий прокурорын газраас “Зөрчлийн тухай хууль тогтоомжийн хэрэглээ” сэдвээр сургалтыг тус тус оров.

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Үүнээс гадна Ковид-19 цар тахал дотоодод тархсан нөхцөл байдлаас болж Монгол Улсад Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх албан ёсны шийдвэр гарснаар Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд зайнаас ажиллав. Энэ хугацаанд ажилтнууд цахим хэлбэрээр мэргэжлийн сургалт семинаруудад тогтмол хамрагдсан бөгөөд

голчлон дараах сургалтын платформуудын холбогдох сургалтуудад хамрагдав. Үүнд:

- Эгмонт бүлгийн сургалтын платформ болох - www.learn.ecofel.org
- Базелийн хорооны сургалтын платформ болох- <https://baselgovernance.org/elearning-courses>
- www.coursera.org
- www.edx.org гэх мэт.


4.3 СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн мэдээллийн албанаас 2020 онд төр, хувийн хэвшил болон олон нийтийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимтэй зохион байгуулж ажиллав. Ковид-19 цар тахлын улмаас танхимын сургалт, уулзалт хийхээс илүүтэйгээр ФАТФ-ын олон улсын зөвлөмж, стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр гарын авлага, заавар, зөвлөмж боловсруулан холбогдох төр болон хувийн хэвшлийн байгууллагуудад хүргүүлж, олон нийтэд зориулсан Санхүүгийн мэдээллийн албаны <https://fiu.mongolbank.mn> цахим хуудаст байршуулсан.

Санхүүгийн мэдээллийн албанаас өөрийн цахим хуудсыг хөгжүүлж 2020 оны 5 дугаар

сарын 28-ны өдөр ашиглалтад оруулсан бөгөөд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр хийгдэж буй ажлуудын талаарх мэдээлэл, холбогдох дотоодын хууль, эрх зүйн, бодлогын бичиг баримтууд болон ФАТФ, олон улсын байгууллагуудаас гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт, зөвлөмжүүдийг цахим хуудсандаа нийтэлж байна. Үүнээс гадна Санхүүгийн мэдээллийн албанаас мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулан гаргасан соён гэгээрүүлэх гарын авлага, заавар, зөвлөмжүүдийг цахим хуудсанд байршуулж, тогтмол шинэчлэхэд анхаарч ажиллаж байгаа тул мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг авах боломжтой.

Зураг 23. Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудас <https://fiu.mongolbank.mn>




Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Үүнээс гадна Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай нэгдсэн мэдээллийг агуулсан www.amlcft.mn хэмээх цахим хуудсыг 2020 оноос ажиллуулж эхлэв. Энэхүү цахим хуудас дээр Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

тогтолцоог бэхжүүлэх чиглээр явуулж буй арга хэмжээний талаарх мэдээ, мэдээлэл болон бичиг баримтуудыг байршуулж байна. Түүнчлэн мэдээлэх үүрэгтэй этгээдүүд уг цахим хуудсанд байршуулсан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтыг харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаандаа тогтмол ашиглах боломжтой юм.

Зураг 24. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай мэдээллийн нэгдсэн систем www.amlcft.mn



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

2020

Санхүүгийн мэдээллийн албанаас соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд дараах бичиг баримтуудыг боловсруулан гаргалаа. Үүнд:



Санхүүгийн мэдээллийн албаны 2019 оны жилийн тайлан

Санхүүгийн мэдээллийн албаны жилийн тайланг анх удаа боловсруулж гаргасан бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр 2017-2019 онуудад хийгдсэн ажлуудын талаарх мэдээллийг багтаасан. Энэхүү тайлан нь, 1) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн зохицуулалт, 2) Мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлэл хүлээн авах, дүн шинжилгээ хийх, 3) Дотоод ба гадаад хамтын ажиллагаа, 4) Чадавхыг бэхжүүлэх, нөөц бололцоог сайжруулах, 5) Типологийн дүн шинжилгээ, 6) Санхүүгийн мэдээллийн албаны мэдээллийн системийн бүтэц, 7) Үндэсний эрсдэлийн үнэлгээ, 8) ФАТФ-ын стандартын техник хэрэгжилт ба үр дүнтэй байдлын үнэлгээ, 9) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалт нийт 9 бүлэгтэй. Жилийн тайланг fiu.mongolbank.mn цахим хуудсанд байршуулснаас гадна хэвлэмэл хувийг холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлсэн.

Холбоос: <https://fiu.mongolbank.mn/documents/annualreport2019.pdf>



Банкуудад зориулсан сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээд болох банкуудад зориулан сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь мэдээлэл, чиглэл өгөх зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулан Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудаст нийтэлж, банкуудад хүргүүлсэн. Энэхүү гарын авлагаар дамжуулан банкны ажилтнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт болон сэжигтэй гүйлгээ, оролдлогыг таних түгээмэл шинж тэмдгүүдийн талаарх ерөнхий мэдлэгийг дээшлүүлснээр сэжигтэй гүйлгээ, сэжигтэй гүйлгээ хийх оролдлогыг таних, илрүүлэх, мэдээлэх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Холбооц: <https://www.mongolbank.mn/documents/cma/guide202007.pdf>



Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад зориулсан тайлан бөглөх заавар, зөвлөмж

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээд болох банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад зориулан хууль тогтоомжийн дагуу гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх заавар, зөвлөмжийг 2020 оны 7 дугаар сард боловсруулж гаргасан. Энэхүү заавар, зөвлөмжид банк бус санхүүгийн байгууллага, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршоо зэрэг мэдээлэх үүрэгтэй этгээдүүд Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан болон Сэжигтэй гүйлгээний тайланг хэрхэн үнэн зөв, чанартай бөглөх талаар тайлбарласан.

Холбооц: https://www.mongolbank.mn/documents/cma/guide20200825_other.pdf



Стратегийн дүн шинжилгээний тайлан-2019 он

Санхүүгийн мэдээллийн албанаас Стратегийн дүн шинжилгээний тайланг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй байгууллага, мэдээлэх үүрэгтэй этгээдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох аюул заналхийлэл, сул талыг илрүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, нөөц бололцоогоо зөв, зохистой хуваарилах, эрсдэл өндөртэй хэсэгт анхаарал хандуулан үйл ажиллагаагаа үр дүнтэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор албан хэрэгцээнд зориулан гаргасан. Энэхүү тайланг 2020 оны 5 дугаар сард гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн танилцуулав.



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь

Олон нийтэд зориулж мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай гарын авлагыг “Санхүүгийн боловсрол” хөтөлбөрийн хүрээнд хүрээнд 2020 оны 5 дугаар сард боловсруулан гаргаж, Монголбанк болон Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудаст байршуулсан. Уг гарын авлагад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тухай ойлголт, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо болон холбогдох хууль эрх зүйн орчинг тайлбарласан.

Холбоос: <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/24.pdf>



Хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага

Энэхүү гарын авлагыг хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг удирдах, мэдээлэх үүргээ биелүүлэх болон бусад олон улсын стандарт, зөвлөмжид заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор боловсруулав. Гарын авлагыг Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд байгуулж, Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын нотариатчдын танхим, Монголын хуульчдын холбоогоор дамжуулан холбогдох мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд хүргүүлсэн.

Холбоос: <https://fiu.mongolbank.mn/other.aspx?id=02>



Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан тайлан бөглөх заавар, зөвлөмж

Санхүүгийн мэдээллийн албанаас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээд болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч тус бүрт зориулан Санхүүгийн мэдээллийн албанд хууль тогтоомжийн дагуу гүйлгээний талаарх мэдээллийг үнэн зөв, чанартай бөглөж ирүүлэх талаарх заавар зөвлөмжийг 2020 оны 6 сард боловсруулж гаргасан. Уг заавар зөвлөмжийг ашигласнаар мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан болон Сэжигтэй гүйлгээний тайлангийн талаарх ойлголт сайжирч, тайлан мэдээний тоо, чанар нь нэмэгдэх ач холбогдолтой.

Холбоос: <https://www.mongolbank.mn/documents/cma/guide20210126.pdf>



Нотариатын салбар дахь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн дохио гарын авлага

Олон улсын нотариатчдын холбооноос гаргасан баримт бичигт үндэслэн "Нотариатын салбар дахь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн дохио" гарын авлагыг боловсруулж гаргасан. Энэхүү гарын авлага нь нотариатчдад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр харилцагчийг таньж мэдэх ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Түүнчлэн, Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаарх мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд дараах соён гэгээрүүлэх бичиг баримтуудыг боловсруулж гаргав. Үүнд:



Улс төрд нөлөө бүхий этгээдийг тогтоох талаар мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан гарын авлага

ФАТФ-ын Зөвлөмж 12-ын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдүүд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөж болзошгүй улс төрд нөлөө бүхий этгээдийг тодорхойлж, илрүүлэх шаардлагатай байдаг. Иймд энэ төрлийн харилцагчийг тогтооход дэмжлэг үзүүлэх зорилгоор гарын авлагыг боловсруулж, цахим хуудсанд байршуулав.



Эцсийн өмчлөгчийг тодорхойлох тухай гарын авлага

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд эцсийн өмчлөгчийг тодорхойлох нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бүрэн ойлгоход өндөр ач холбогдолтой байдаг. Иймд ФАТФ-ын Зөвлөмж 24, 25 болон ФАТФ-аас гаргасан "Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын тухай гарын авлага", "Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн шилдэг туршлагын талаарх гарын авлага"-д үндэслэн Санхүүгийн мэдээллийн албанаас "Эцсийн өмчлөгчийг тодорхойлох тухай гарын авлага"-ыг гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт санал авахаар хүргүүлсэн.

Дээр дурдсан гарын авлага, заавар, зөвлөмж болон бусад холбогдох бичиг баримтуудыг Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудаснаас татаж авах боломжтой.

Холбоос: <https://www.mongolbank.mn/documents/cma/guide20210126.pdf>

Холбоос: https://www.mongolbank.mn/documents/cma/guide_20190628.pdf



БҮЛЭГ 5

МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН БҮТЭЦ

”




5.1 | САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ДОТООД МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээд нь сэжигтэй гүйлгээний тайлангаамэдээллийнсандирүүлснийдараагаар ахлах шинжээчид эрсдэлийн матрицийн аргаар үнэлэн өндөр оноо авсан гүйлгээг шинжээчдэд хуваарилан өгнө. Үүний дараагаар шинжээчид сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийх явцдаа холбогдох байгууллагуудаас нэмэлт мэдээлэл авч шинжилгээ хийдэг.

Одоогийн байдлаар банкууд хуульд заасан тайлан, мэдээллийг онлайнаар, банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээд нь эксэл файлаар дамжуулан цахим хэлбэрээр Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлж байна. Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагаанд ашиглаж буй программ хангамжийг сайжруулах шаардлага тулгарсан.

Зураг 25. Санхүүгийн мэдээллийн албаны дотоод мэдээллийн системийн бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

5.2 | GOAML ПРОГРАММ ХАНГАМЖ


Санхүүгийн мэдээллийн албанаас шинээр нэвтрүүлж буй goAML програм нь мэдээлэх үүрэгтэй этгээдийн тайлагнах үйл ажиллагааны чанарыг сайжруулж, Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор мэдээлэх үүрэгтэй этгээдийн бүртгэл болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд тайлан, хавсралт мэдээг тайлагнах, хүлээн авах, боловсруулах болон дүн шинжилгээ хийж, хууль, сахиулах байгууллагад шилжүүлэх процессуудыг бүрэн хангах чадалтай цогц систем юм.

Энэхүү системийг мэдээлэл цуглуулах болон солилцох техник, технологийн дэвшилтэт орчинг бий болгож улмаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг

түргэн шуурхай, хялбар болгох, оновчтой бодлого шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор НҮБ-ын Хар Тамхи, Мансууруулах Бодистой тэмцэх албанаас гишүүн орнуудын Санхүүгийн мэдээллийн албаны хэрэгцээнд нийцүүлэн гаргасан.

Санхүүгийн мэдээллийн алба нь 2019 оны 12 дугаар сараас goAML программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, программын мэдээлэл хүлээн авах схем болон утгуудыг Монголын хууль эрх зүйн орчин, мэдээллийн төрөлд нийцүүлэн тохируулах, интерфэйсийг Монгол хэлнээ орчуулах, схемийн танилцуулга, заавар болон дагалдах бусад баримт бичгийг боловсруулан банкуудад танилцуулаад байна.

Зураг 26. goAML вэб портал




Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

goAML систем нь мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд тайлан, мэдээг тайлагнах "гадаад" вэб портал болон Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын дүн шинжилгээ хийх, статистик дүгнэлт гаргах "дотоод" буюу "клиент" үндсэн програм гэх хоёр програмаас бүрдэж байна.

goAML вэб буюу гадаад портал нь Санхүүгийн мэдээллийн алба ба Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хооронд аюулгүй вэб платформыг бүрдүүлж, XML файл илгээх эсвэл онлайн тайлангийн хуудсыг гараар бөглөх замаар тайлан, мэдээл хүлээн авах бэлтгэл ажил

хангагдсан. Тайлан илгээхэд мэдээлэх үүрэгтэй этгээдэд XML өгөгдлийн формат шаардлагатай байдаг бөгөөд сэжигтэй гүйлгээний тайлан гэх мэт өгөгдлийн цогц багц датаг бүтээх боломжийг олгодог мэдээллийн технологийн хэл юм. Тайланг гар аргаар вэб хэлбэрт хөрвүүлэх үед өгөгдлийг аюулгүй HTTPS интернет холболтоор DMZ бүсрүү дамжуулж тухайн бүс нь firewall, шифрлэгдсэн холбоос мөн вирусын эсрэг програм хангамжийн нөхцөлийг бүрдүүлж өгсний дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс оруулсан өгөгдлүүд Санхүүгийн мэдээллийн албаны сервер дээр аюулгүй байдлыг бүрэн хангаж хадгалагдана.

Зураг 27. goAML системийн бүдүүвч зураг



Эх сурвалж: НҮБ-ийн Хар Тамхи, Мансууруулах Бодистой тэмцэх алба


2020 оны 4 дүгээр сард goAML програмыг нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, сервер болон програмын лицензийг бүрэн худалдан авсан бөгөөд 2020 оны 7, 8 дугаар сард Монголбанкны Мэдээллийн технологийн газар болон Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд хамтран худалдан авсан серверүүд дээр системийн суурилуулалтыг хийж гүйцэтгэсэн.

Эдгээр ажлуудыг хийж гүйцэтгэсний дараа НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын ажилтнуудтай 2020 оны 8 дугаар сард цахимаар холбогдож, суурилуулсан систем болон мэдээллийн технологийн бүтцийг шалгуулан туршилт хийсэн бөгөөд алдаа тус бүрийг засаж залруулан goAML программын туршилтыг

хийхэд бэлэн болсныг баталгаажуулсан. 2020 оны 9 дүгээр сар, 10 дугаар саруудад goAML вэб болон клиент програм дээр мэдээлэл солилцох болон бусад дотоод үйл ажиллагааны туршилт хийж, гарсан асуудал, алдаануудыг НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын тусламжтайгаар засаж, залруулж ажиллав.

2020 оны 11 дүгээр сард goAML вэб аппликейшн дээр бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан болон сэжигтэй гүйлгээний тайлан оруулах туршилтын ажлуудыг хийсэн бөгөөд goAML программын мэдээлэл хүлээн авах схемийг эцэслэн тодорхойлж банкуудад 2020 оны 12 дугаар сард хүргүүлсэн.

Зураг 28. goAML тайлан хүлээн авах хуудас



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд програм хангамжийг нэвтрүүлэх тал дээр дотоод бэлтгэлийг бүрэн

хангуулж ажиллах зааварчилгааг өгсөн бөгөөд 2021 онд програмыг бүрэн нэвтрүүлэхээр ажиллаж байна.



БҮЛЭГ 6

ҮНДЭСНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

”



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд ФАТФ-ын Зөвлөмж 1-т заасны дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийж, уг үнэлгээний үр дүнд суурилан Үндэсний хөтөлбөрийг боловсруулахаар заасан. Энэ хүрээнд 2016 онд анхны Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг боловсруулж гаргасан. Тийм учраас Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу

хийх, эрсдэлийн үнэлгээнд суурилсан эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг 2020 оны 01 дүгээр сараас хийж гүйцэтгэсэн. Энэ хүрээнд Сангийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар тушаалаар Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх үндсэн ажлын хэсгийг байгуулснаас гадна Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дүгээр тушаалаар зохицуулалттай салбар тус бүрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх 10 модулийн 11 дэд ажлын хэсгийг байгуулж ажиллав. Үүнд:

- Модуль 1.** Мөнгө угаах аюул заналхийллийг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 2.** Үндэсний эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 3.** Банкны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 4.** Үнэт цаасны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 5.** Даатгалын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 6.** Банк бус санхүүгийн байгууллагын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 7.** Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 8.** Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 9.** Санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 10.** Ашгийн бус байгууллагын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 11.** Виртуал хөрөнгийн салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг


Дээрх дэд ажлын хэсгүүдэд төрийн байгууллагууд болон холбогдох бүхий л салбарын хувийн хэвшлийн нийт 52 байгууллагын 128 төлөөлөгчид орж ажилласан бөгөөд Дэлхийн

банкнаас нийт ажлын хэсгийн гишүүдэд болон дэд ажлын хэсэг тус бүрт эрсдэлийн үнэлгээ хийх цахим сургалтуудыг зохион байгуулсан.

Ажлын хэсгийн зүгээс Дэлхийн банкны аргачлалд үндэслэн дараах бүдүүвч зурагт

үзүүлсний дагуу Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэж байна.

Зураг 29. Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх бүдүүвч зураглал



Эх сурвалж: Дэлхийн банкны гарын авлага

Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх нөөц бололцоог зөв хуваарилах, болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх

боломж нөхцөл бүрдэх юм. Мөн түүнчлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны бодит үр дүнг дээшлүүлэх, шууд хэрэгжилтийн үр дүнг сайжруулах, тогтолцоог чанаржуулах ач холбогдолтой.

Зураг 30. Үндэсний эрсдэлийн үнэлгээний ач холбогдол




Эх сурвалж: Дэлхийн банкны танилцуулга

Иймд ажлын хэсгийн зүгээс Дэлхийн банкны аргачлал болон ФАТФ-ын гарын авлагад зөвлөснөөр дараах бүдүүвч зурагт үзүүлсэн үе шатуудын дагуу холбогдох мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийж, эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг

тодорхойлж ажиллав. Энэ хүрээнд юуны түрүүнд, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг аюул заналхийлэл болон эмзэг байдалд тулгуурлан тодорхойлж, дараагийн үе шатанд дүн шинжилгээг хийсэн.

Зураг 31. Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх үе шатууд



Эх сурвалж: ФАТФ-ын Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх гарын авлага

Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс долоо хоног бүр ажлын явцыг хэлэлцэх, цаашид хийгдэх ажлуудыг тодорхойлох уулзалтуудыг зохион байгуулсан. Эдгээр уулзалтуудын үр дүнд 2020 онд салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээг хийх хэлэлцүүлгүүдийг зохион байгуулав. Улмаар салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээний үр дүн, дүгнэлтүүдийг урьдчилсан байдлаар боловсруулсан бөгөөд ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх зорилгоор нэгдсэн хэлэлцүүлгийг Санхүүгийн мэдээллийн албанаас бүх ажлын хэсгийн гишүүн байгууллагуудтай хамтран 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулав.

Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг эцэслэн боловсруулах ажлын хүрээнд 2020 оны 10 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд нийт 5 өдөр 10 дэд ажлын хэсэг тус бүрийн хийсэн үнэлгээний талаарх хэлэлцүүлгийг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Авлигатай тэмцэх газар дээр амжилттай зохион байгуулав. Тус хэлэлцүүлэгт холбогдох яам, төрийн байгууллага, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага, судлаач эрдэмтэд, мэргэжлийн холбоод болон хувийн хэвшлийн нийт 250 гаруй төлөөлөл оролцон нийт 10 модулийн тайланг хэлэлцэж, санал дэвшүүлж, сайжруулах талаар үзэл бодлоо илэрхийллээ.

Зураг 32. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний хэлэлцүүлэг /2020.10.26-30/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Дэд ажлын хэсгүүд дээрх хэлэлцүүлгийн үеэр дэвшүүлсэн оновчтой санал, зөвлөмжүүдийг өөрсдийн модулийн тайландаа тусган боловсруулж Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлж байгаа бөгөөд Эрсдэлийн үнэлгээний тайлангийн төслийг эцэслэн боловсруулж, Дэлхийн банканд хүргүүлж санал авахаар ажиллаж байна.

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний 2 дахь тайлангийн үр дүнг үнэлж, дүгнэсний үндэслэн “Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны Үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж, мөнгө

угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулахаар төлөвлөж байна. Энэхүү Үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, ФАТФ-ын техникийн хэрэгжилт болон үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх асуудлуудыг дэлгэрэнгүй тусгах бөгөөд Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, хууль сахиулах байгууллагууд болон бусад холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлж ажиллах болно.

Зураг 33. Үндэсний Хөтөлбөр, Стратегийг батлуулж хэрэгжүүлэх тухай



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Үндэсний хөтөлбөрөөр дамжуулан Улсын Их Хурлын 2020 оны 52 тоот тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Улсын Их Хурлын 2020 оны 23 тоот тогтоолоор батлагдсан Монгол

Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын Их Хурлын 2020 оны 24 тоот тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой юм.

2020.01.31 1 Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу хийх, эрсдэлийн үнэлгээнд суурилсан эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг 2020 оны 01 дүгээр сараас хийж гүйцэтгэсэн. Энэ хүрээнд Сангийн сайдын 20 дугаар тушаалаар Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх үндсэн ажлын хэсгийг байгуулсан.

2020.10.30 12 Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг эцэслэн боловсруулах ажлын хүрээнд нийт 5 өдөр 10 дэд ажлын хэсэг тус бүрийн хийсэн үнэлгээний талаарх хэлэлцүүлгийг Санхүүгийн мэдээллийн албанаас Хууль зүй, дотоод хэргийн яам болон Авлигатай тэмцэх газар дээр амжилттай зохион байгуулав.

2020.04.24 2 Дэлхийн банкнаас зохион байгуулсан Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх тухай цахим сургалтыг зохион байгуулсан.

2020.04.30 3 Даатгал болон Үнэт цаасны салбарын эмзэг байдлын үнэлгээг хийх цахим сургалтыг Дэлхийн банкнаас зохион байгуулдсан.

2020.05.21 11 Үндэсний эмзэг байдлын үнэлгээг хийж гүйцэтгэх тухай цахим сургалтыг зохион байгуулсан.

2020.04.27 4 Сангийн сайдын 90 дүгээр тушаалаар зохицуулалттай салбар тус бүрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх 10 модулийн дэд ажлын хэсгийг байгуулж ажиллав.



2020.05.20 10 Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийн үнэлгээг хийх тухай цахим сургалтыг зохион байгуулсан.

2020.05.05 5 Банк бус санхүүгийн байгууллага болон Хадгаламж зээлийн хоршооны салбарын эмзэг байдлын үнэлгээг хэрхэн хийх тухай цахим сургалт болсон.

2020.05.13 7 Банкны салбарын эмзэг байдлын үнэлгээг хэрхэн хийх тухай цахим сургалт зохион байгуулсан.

2020.05.19 9 Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ болон Ашгийн бус байгууллагын эмзэг байдлын үнэлгээг хэрхэн хийх тухай цахим сургалтыг зохион байгуулсан.

2020.05.06 6 Санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээг хийх тухай Дэлхийн банкны цахим сургалтыг Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан.

2020.05.15 8 Мөнгө угаах аюул заналхийллийн үнэлгээг хэрхэн хийх тухай цахим сургалтыг зохион байгуулсан.



БҮЛЭГ 7

ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИК
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

”



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дэлхийн улс орнууд ФАТФ-аас гаргасан техник хэрэгжилтийн 40 зөвлөмж болон Шууд хэрэгжилтийн 11 шалгуурыг дагаж мөрдөх үүрэгтэй байдаг.

Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-ын 40 Зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлуудыг багтаасан Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайланг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн. Тус тайланг хүргүүлэхдээ нийт хэсэгчлэн биелсэн үнэлгээтэй 5 Зөвлөмжийн үнэлгээг ахиулж, 1 Зөвлөмжийн үнэлгээг хэвээр хадгалах хүсэлтийг гаргасан. Энэ хүрээнд үнэлгээний багаас Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайлантай холбоотой тодруулга авах хүсэлтийг 2020 оны 3-5 дугаар саруудад удаа дараа ирүүлсний хариуд Санхүүгийн мэдээллийн

албанаас хариуцсан байгууллагуудтай хамтран холбогдох тайлбаруудыг тухай бүр өгч ажиллав. Мөн Монгол Улсын Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүн орнуудад хүргүүлэн санал авсан бөгөөд улмаар ирүүлсэн саналуудад хариу тайлбарыг бэлтгэн хүргүүлсэн.

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан Харилцан үнэлгээний хорооны ээлжит бус цахим хуралд бэлтгэх зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас олон улсын мэргэжилтнүүдтэй хийх цахим уулзалтуудыг зохион байгуулсан. Энэхүү хуралд оролцсон гишүүн орны төлөөллүүд бүгд Монгол Улсын Явцын тайланд тусгасан 3 зөвлөмжийн үнэлгээг ахиулах саналыг дэмжсэн. Үүний үр дүнд Зөвлөмж 14-ийн үнэлгээг хоёр шатаар ахиулан “Биелүүлсэн”, Зөвлөмж 28 болон 35-ын үнэлгээг тус бүр нэг шатаар ахиулан “Дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээ авсан.

Зураг 34. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн цахим чуулга уулзалт /2020.07.22/



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Тухайлбал, Зөвлөмж 14-ийн хүрээнд бүртгэгдээгүй мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчдийг илрүүлэх, тэдний гаргасан зөрчилтэй дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээг авах үр дүнтэй хууль эрх зүйн систем, практикийг бий болгоход Санхүүгийн мэдээллийн албанаас Санхүүгийн зохицуулах хороонд дэмжлэг үзүүлж хамтарч ажилласан. Үүнээс гадна, Зөвлөмж 28-ын үнэлгээг ахиулах чиглэлээр бүх зохицуулалттай салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлалыг нэвтрүүлж, ялангуяа хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдийг зохицуулах

байгууллагуудын хяналт шалгалтын чадавхыг сайжруулах, тэдний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас гарын авлага, заавар, зөвлөмжүүдийг боловсруулж, сургалтууд зохион байгуулсан. Түүнчлэн, Зөвлөмж 35-ын үнэлгээг ахиулах хүрээнд мэдээлэх үүрэгтэй этгээдийн гаргасан зөрчилд ногдуулах торгуулийн хэмжээг нэмэгдүүлснээс гадна Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн дагуу торгууль, шийтгэл ногдуулах зохицуулалтыг тусгасан.

Хүснэгт 11. ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээний өөрчлөлт

№	Зөвлөмжийн нэр	Өмнөх үнэлгээ	Шинэчилсэн үнэлгээ	Тайлбар
Үнэлгээг ахиулсан 3 Зөвлөмж				
14	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Биелүүлсэн (C)	Үнэлгээг хоёр шатаар ахиулсан.
28	СББМҮҮ-ийн зохицуулалт, хяналт шалгалт	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Дийлэнхийг биелүүлсэн (LC)	Үнэлгээг нэг шатаар ахиулсан.
35	Шийтгэлийн арга хэмжээ	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Дийлэнхийг биелүүлсэн (LC)	Үнэлгээг нэг шатаар ахиулсан.
Үнэлгээг хэвээр үлдээсэн 2 Зөвлөмж				
1	Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Үнэлгээг хэвээр үлдээсэн.
8	Ашгийн бус байгууллагууд	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Үнэлгээг хэвээр үлдээсэн.
Үнэлгээг бууруулсан 1 Зөвлөмж				
15	Шинэ технологи	Дийлэнхийг биелүүлсэн (LC)	Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	Үнэлгээг нэг шатаар бууруулсан.

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Иймд ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээний хувьд Монгол Улс нийт 37 Зөвлөмжийг дийлэнхийг болон бүрэн биелүүлсэн гэсэн үнэлгээтэй байгаа бөгөөд

үлдсэн 3 Зөвлөмжийг хэсэгчлэн биелүүлсэн байгааг дараах хүснэгтэд харуулав (Хүснэгт 11). Үүнд:

Хүснэгт 12. Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээ

ЗӨВЛӨМЖ 1 Эрсдэлээ үнэлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх	ЗӨВЛӨМЖ 2 Үндэсний хамтын ажиллагаа болон уялдаа холбоо	ЗӨВЛӨМЖ 3 Мөнгө угаах гэмт хэрэг	ЗӨВЛӨМЖ 4 Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ	ЗӨВЛӨМЖ 5 Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг
PC	LC	LC	LC	LC
ЗӨВЛӨМЖ 6 Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ	ЗӨВЛӨМЖ 7 Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ	ЗӨВЛӨМЖ 8 Ашгийн бус байгууллага	ЗӨВЛӨМЖ 9 Санхүүгийн байгууллагын нууцлалын хууль тогтоомж	ЗӨВЛӨМЖ 10 Харилцагчийг таньж мэдэх
LC	LC	PC	LC	LC
ЗӨВЛӨМЖ 11 Баримт материал хадгалах	ЗӨВЛӨМЖ 12 Улс төрд нөлөө бүхий этгээд	ЗӨВЛӨМЖ 13 Корреспондент банкны үйл ажиллагаа	ЗӨВЛӨМЖ 14 Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ	ЗӨВЛӨМЖ 15 Шинэ технологи
C	LC	LC	C	PC
ЗӨВЛӨМЖ 16 Цахим шилжүүлэг	ЗӨВЛӨМЖ 17 Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх	ЗӨВЛӨМЖ 18 Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани	ЗӨВЛӨМЖ 19 Өндөр эрсдэлтэй улс орнууд	ЗӨВЛӨМЖ 20 Сэжигтэй гүйлгээг мэдээлэх
LC	LC	LC	LC	LC
ЗӨВЛӨМЖ 21 Мэдээллийг задруулах болон нууцлал	ЗӨВЛӨМЖ 22 СББМҮҮ: Харилцагчийг таньж мэдэх	ЗӨВЛӨМЖ 23 СББМҮҮ: Бусад арга хэмжээ	ЗӨВЛӨМЖ 24 Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал	ЗӨВЛӨМЖ 25 Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч
C	LC	LC	LC	LC
ЗӨВЛӨМЖ 26 Санхүүгийн байгууллагын зохицуулалт, хяналт шалгалт	ЗӨВЛӨМЖ 27 Хянан шалгагчийн эрх мэдэл	ЗӨВЛӨМЖ 28 СББМҮҮ-ийн зохицуулалт, хянан шалгалт	ЗӨВЛӨМЖ 29 Санхүүгийн мэдээллийн алба	ЗӨВЛӨМЖ 30 Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын үүрэг
LC	LC	LC	C	C
ЗӨВЛӨМЖ 31 Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын эрх мэдэл	ЗӨВЛӨМЖ 32 Бэлэн мөнгө зөөвөрлөгчид	ЗӨВЛӨМЖ 33 Статистик мэдээлэл	ЗӨВЛӨМЖ 34 Зааварчилгаа, эргэх холбоо	ЗӨВЛӨМЖ 35 Шийтгэлийн арга хэмжээ
C	LC	LC	LC	LC
ЗӨВЛӨМЖ 36 Олон улсын арга хэрэгслүүд	ЗӨВЛӨМЖ 37 Эрх зүйн харилцан туслалцаа	ЗӨВЛӨМЖ 38 Эрх зүйн харилцан туслалцаа: хөрөнгө царцаах, хураах	ЗӨВЛӨМЖ 39 Гэмт хэрэгтэн шилжүүлэх	ЗӨВЛӨМЖ 40 Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр
C	C	LC	LC	LC

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Тайлбар: Бүрэн биелүүлсэн: C-compliant, Дийлэнхийг биелүүлсэн: LC-largely compliant, Хэсэгчлэн биелүүлсэн: PC-partially compliant, Биелүүлээгүй: NC-noncompliant

Монгол Улсын ФАТФ-ын Техник хэрэгжилт болон Үр дүнтэй байдлын үнэлгээний цаг хугацааны матриц (2007-2020)-ыг Хавсралт 3-аас харна уу.

Цаашид хэсэгчлэн биелүүлсэн үнэлгээтэй 3 Зөвлөмжийн үнэлгээг ахиулах, бусад Зөвлөмжүүдийн үнэлгээг хэвээр хадгалах зорилгоор 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд "ФАТФ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө"-г баталж, холбогдох байгууллагуудыг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон.

Иймд уг төлөвлөгөөний хүрээнд Зөвлөмж 1-д заасны дагуу Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэж байна. Мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр А-26 тоот тушаалаар батлагдсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам"-д холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахаар болсон.


Зөвлөмж 8-ын хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас ашгийн бус байгууллагын салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бүрдүүлэх, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, соён гэгээрүүлэх

үйл ажиллагааг явуулах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам болон Терроризмтой тэмцэх зөвлөлтэй хамтран ажиллаж байна.

Үүнээс гадна, Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-23 дугаартай тушаалаар байгуулагдсан "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх этгээдтэй холбоотой хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг судлах, олон улсын стандарт, зөвлөмжийн дагуу хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах" чиг үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажилласан. Энэ хүрээнд виртуал хөрөнгийн салбарын талаарх олон улсын туршлага, хууль, эрх зүйн орчинтой холбоотой судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд холбогдох байгууллагуудтай хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулав.

Монгол Улсын зүгээс хэсэгчлэн биелүүлсэн гэсэн үнэлгээтэй 3 зөвлөмж болох 1, 8, 15 дугаар зөвлөмжийн үнэлгээг ахиулах хүсэлтийг энэ чиглэлээр хийгдсэн ажлуудыг багтаасан тайлангийн хамт 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлэх болно.

ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИК ХЭРЭГЖЭЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ОН ЦАГИЙН ДАРААЛАЛ





БҮЛЭГ 8

ХЯНАЛТ ШАЛГАЛТ

”



Монгол Улсад 2017 онд хийгдсэн Харилцан үнэлгээний тайланд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийгдэж буй хяналт шалгалттай холбоотой дутагдлыг тодорхойлж, түүнийг засах, сайжруулах арга хэмжээг эрчимтэй авсан билээ. 2020 онд хяналт шалгалттай холбоотой техник хэрэгжилт буюу хууль эрх зүйн дутагдалтай байдлыг бүрэн залруулж, Зөвлөмж 26, 28-ын үнэлгээг ахиулж дүгнүүлэв. Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдтэй холбоотой хяналт шалгалтын зохицуулалтыг сайжруулсны үр дүнд 2020 оны 10 дугаар сард болсон газар дээрх хяналт шалгалтын Шууд хэрэгжилт 3-т гаргасан ахицыг амжилттай хамгаалав.

Хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр 2020 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19.1, Зөрчил шалгах шийдвэрлэх тухай хуулийн 6.31 дүгээр заалтад өөрчлөлт

оруулснаар Санхүүгийн мэдээллийн албаны хянан шалгагч, улсын байцаагч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Терроризм болон үй олноор зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тухай хуулийн зөрчилд арга хэмжээ авах эрх зүйн орчин бүрдэв. Хуульд өөрчлөлт оруулсантай холбогдуулан хянан шалгагчдын мэдлэг, чадавхыг дээшлүүлэх сургалтад хамруулах, хяналт шалгалтад ашиглах аргачлал, заавар, асуулга, зайны эрсдэлийн үнэлгээний хэрэгсэл зэрэг баримт бичгүүдийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18.1.7 дугаар зүйлд зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь тус хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар нэгдсэн статистик гаргах, хяналт шалгалт хийх, эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх чиг үүрэгтэй.

8.1 | САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОО, ЦАР ХҮРЭЭ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд Санхүүгийн зохицуулах хороо болон мэргэжлийн холбоод болох Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын Хуульчдын холбоо, Монголын Нотариатчдын танхимаас хяналт тавихаар болсон. Үүнтэй холбогдуулан, Санхүүгийн мэдээллийн албанаас нотариатч, хуульч болон нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд хяналт тавих хүрээнд 2020 онд мэргэжлийн холбоодтой хамтран мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Энэ хүрээнд мэргэжлийн холбоодыг Олон улсын валютын сангийн техник туслалцааны хүрээнд боловсруулсан зайны хяналтын асуулга болон эрсдэлийн үнэлгээний аргачлалыг ашиглан санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд үнэлгээ хийж, өндөр эрсдэлтэй гарсан этгээдэд газар дээрх хяналт шалгалт хийх, улмаар хяналт шалгалтын үр дүнд үндэслэн зайны хяналтын асуулга болон эрсдэлийн үнэлгээний аргачлалыг шинэчлэхэд Санхүүгийн мэдээллийн албанаас туслалцаа үзүүлж хамтран ажиллав. Мөн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага болон тайлан бөглөх заавар

зөвлөмжийг боловсруулж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан үүргийг биелүүлж ажиллах талаар сургалт, уулзалтуудыг зохион байгуулсан. Дараах хүснэгтэд мөнгө угаах, терроризмыг

санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр нийт мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт болон авсан арга хэмжээний талаар харуулав (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа


Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Банканд хийсэн хяналт шалгалт	2	14	24	19
Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт	139	1025	269	146
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавигдсан актын тоо	29	4	-	1
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд өгсөн хугацаат үүрэг даалгаврын тоо	367	272	245	444

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19.1-т хяналт шалгалтын үйл ажиллагааг тухайн салбарын мэргэжлийн холбоод буюу Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Нотариатчдын танхим хийхээр тусгасан. Энэ зохицуулалтын хүрээнд мэргэжлийн холбоод хяналт шалгалтын

арга хэмжээ авч, зөрчил гарсан тохиолдолд Санхүүгийн мэдээллийн албаны улсын байцаагч арга хэмжээ авахаар заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллав. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалт хийх байгууллагуудыг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах зургийн дагуу хэрэгжүүлэв.

Зураг 35. Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа



Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хяналт шалгалт хийхдээ мэргэжлийн холбоодоор дамжуулан нийт энэ төрлийн үйлчилгээ үзүүлэгчдээс зайны хяналт шалгалтаар асуулгын маягтын дагуу мэдээлэл цуглуулж, үнэлгээ хийсэн бөгөөд гарсан эрсдэлийн үнэлгээг үндэслэн газар дээрх хяналт шалгалтыг зохион байгуулав. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөртэй үнэлэгдсэн хуульч, нотариатч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид газар дээрх хяналт шалгалтыг мэргэжлийн холбоодоос зохион байгуулж, хугацаатай үүрэг даалгаврыг өгдөг. Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг Санхүүгийн мэдээллийн алба нь

гүйцэтгэлийн газар дээрх хяналт шалгалтын явцад шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан хариуцлагын арга хэмжээ, Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлд заасан арга хэмжээг авах үүрэгтэй санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хийж буй хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэхэд Санхүүгийн мэдээллийн албанаас бүх чиглэлээр хамран ажиллаж, техник туслалцаа үзүүлэв.

2020 онд Санхүүгийн мэдээллийн албанаас санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хийсэн хяналт шалгалтын статистик мэдээллийг хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 14. Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хийсэн хяналт шалгалтын статистик мэдээлэл /2020 он/

Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид	Зайны хяналт шалгалтын тоо	Газар дээрх хяналт шалгалтын тоо	Гүйцэтгэлийн хяналт шалгалтын тоо	Зөрчлийг арилгах арга хэмжээ
Нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч	136	3	6	Хугацаат үүрэг даалгаврын тоо- 3, Улсын байцаагчийн мэдэгдэл - 18
Хуульч, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч	217	10	5	Хугацаат үүрэг даалгаврын тоо- 10, Улсын байцаагчийн мэдэгдэл - 48
Нотариатч	250	20	2	Хугацаат үүрэг даалгаврын тоо- 20, Улсын байцаагчийн мэдэгдэл - 2

Эх сурвалж: Мэргэжлийн холбоод

8.2 | ХЯНАЛТ ШАЛГАЛТТАЙ ХОЛБООТОЙ БОЛОВСРУУЛСАН БАРИМТ БИЧИГ

Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хийж буй хяналт шалгалт зайны болон газар дээрх хяналт шалгалт гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Зайны хяналт шалгалтын хүрээнд мэдээлэл цуглуулах асуулга, цуглуулсан мэдээллийг нэгтгэн үнэлэх үнэлгээний матриц буюу аргачлалыг салбар тус бүрээр боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлэв.

Зайны хяналт шалгалтын хүрээнд цугларч буй мэдээллийн чанар хангалтгүй эсхүл мэдээллийн олдоц зарим тохиолдолд муу байсантай

холбогдуулан Санхүүгийн мэдээллийн албанаас мэдээлэл цуглуулах маягт болон эрсдэлийн үнэлгээний хэрэгсэлд холбогдох өөрчлөлтүүдийг хийсэн. Энэ нь цаашид зайны хяналт шалгалтын хэрэгжилтэд бодитой үр дүн авчрах ач холбогдолтой юм.

Газар дээрх хяналт шалгалтын хүрээнд хянан шалгагч нарын дагаж мөрдөх нарийвчилсан заавар, аргачлалыг боловсруулах чиглэлээр Олон Улсын Валютын Сан болон АНУ-ын Сангийн яамтай хамтран ажиллав.

8.3 | ТЕХНИК ТУСЛАЛЦАА БА ХҮРЧ АЖИЛЛАХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулсан хяналт шалгалтын дүрэм журмыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих, бодит үр дүн гаргах зорилгоор салбарын мэргэжлийн холбоодтай нягт хамтран ажиллав. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хийгдсэн хяналт шалгалт бүрт хамтран оролцож, техник туслалцаа үзүүлэхээс гадна хяналт шалгалтын бусад чиглэлээр дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал:

- Монголбанк, Сангийн яам, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Терроризмтой тэмцэх зөвлөл, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг зэрэг байгууллагуудтай хамтран хянан шалгагчид, нягтлан бодох бүртгэлийн компанийн гүйцэтгэх удирдлагууд, ажилтнууд, санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нарт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр сургалтуудыг зохион байгуулсан.
- Хууль зүй, дотоод хэргийн яам болон Монголын хуульчдын холбоотой хамтран 43 хуулийн компанид зориулан 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгээр тэдний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай үүргийг ойлгуулах танилцуулга сургалтыг зохион байгуулсан.
- АНУ-ын Сангийн яамны зөвлөхүүдтэй хамтран Санхүүгийн мэдээллийн алба, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын хуульчдын холбоо, Монголын нотариатчдын танхимын хянан шалгагчдад болон Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яамны мэргэжилтнүүдэд зориулан 3 өдрийн цахим сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтаар санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбар дахь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг; комплаенсийн хөтөлбөр, санхүүгийн бус

бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах үйл ажиллагаа гэсэн 3 үндсэн сэдвийг хамарсан.

- Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын хуульчдын холбоо, Монголын нотариатчдын танхимын зохицуулалтад хамаарах нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч,

хуульч, нотариатчдад зориулан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага” болон Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан тайлан мэдээ бөглөх заавар, зөвлөмжийг боловсруулж гаргасан.

8.4 | **САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДЭД ХИЙГДЭХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ**

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажилласны дүнд олон улсын шалгуурыг тодорхой түвшинд хангаж байгаа боловч бодит хэрэгжилтэнд анхаарч ажиллах шаардлагатай байна. Иймд Санхүүгийн мэдээллийн албанаас нэн тэргүүнд дараах арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

- Хяналт шалгалтын баримт бичгүүдэд тулгуурлан журам гаргах;
- Хяналт шалгалт хийх эрх бүхий мэргэжлийн холбоодуудтай хамтран ажиллах шат дарааллыг нарийвчлан гаргах;
- Санхүүгийн мэдээллийн албанаас хэрэгжүүлж буй хяналт шалгалтын үйл ажиллагааг Зөрчлийн тухай хуульд заасан процессын дагуу хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 05 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар А/25

Улаанбаатар
хот

"Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний зөвлөлийн ажиллах журам" батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22¹ дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 144 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.


Ц.НЯМДОРЖ



Мөнгө угаах, терроризмыг
санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний
зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй,
дотоод хэргийн сайдын 2020 оны 9/25
дугаар тушаалын хавсралт

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" гэх/ - ийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/- ийн үйл ажиллагаанд энэ журмыг баримтална.

1.2.Зөвлөл нь чиг үүргээ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журамд заасан хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд орон тооны бус хэлбэрээр ажиллана.

Хоёр.Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1.Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хурал байна.

2.2.Зөвлөл нь Засгийн газартай зөвлөлийн даргаар дамжуулан харилцана.

2.3.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу Зөвлөлийг тэргүүлэх албан тушаалтан, бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар батлах бөгөөд шаардлагатай тохиолдолд бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах саналын төслийг хурлаар хэлэлцэн Зөвлөлийн даргын гарын үсэг бүхий албан бичгээр Ерөнхий сайдад хүргүүлнэ.

2.4.Зөвлөлийн ажлын алба /цаашид "Ажлын алба" гэх/- ны чиг үүргийг Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба хэрэгжүүлэх бөгөөд Зөвлөлийн нарийн бичгийн даргаар Санхүүгийн мэдээллийн албаны дарга ажиллана.

2.5.Зөвлөлийн гишүүний эзгүйд түүнийг орлох албан тушаалтны нэрийг тухайн байгууллагаас зөвлөлийн хурал эхлэхээс ажлын нэгээс доошгүй өдрийн өмнө Ажлын албанд бичгээр мэдэгдэнэ.

Гурав.Зөвлөлийн хурал

3.1.Хурлыг зохион байгуулах үйл ажиллагааг Ажлын алба хариуцна.

3.2.Хурлыг Зөвлөлийн дарга эсхүл түүний эзгүйд орлогч дарга удирдана.

3.3.Зөвлөл нь ээлжит болон ээлжит бусаар хуралдана. Ээлжит хурлыг хагас жилд нэг удаа, ээлжит бус хурлыг ажлын албаны санаачилгаар Зөвлөлийн даргын зөвшөөрснөөр зарлан хуралдуулна.

3.4.Хурлын дэгийг зөвлөлийн дарга тогтоох бөгөөд зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр тооцогдоно.

3.5.Хурлын тов (байршил, цаг), хэлэлцэх асуудлын жагсаалтыг нарийн бичгийн дарга хурал эхлэхээс ажлын нэгээс доошгүй өдрийн өмнө албан бичгээр, цахим шуудангаар, яаралтай тохиолдолд утсаар нийт гишүүдэд мэдэгдсэн байна.

3.6.Зөвлөлийн шийдвэрийг гишүүн байгууллагуудад Ажлын алба хүргүүлнэ.

3.7.Хурлаар хэлэлцэх асуудлыг хуралд оролцож байгаа нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд Зөвлөлийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

3.8.Хурлын тэмдэглэлийг Ажлын алба хөтлөх бөгөөд хурлаас гарсан шийдвэрийг тэмдэглэлд "ШИЙДВЭРЛЭСЭН нь:" гэсэн хэлбэрээр тусгаж баталгаажуулна.

3.9.Зөвлөлийн хурлын тэмдэглэлд зөвлөлийн дарга, хурал даргалагч болон нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна.

3.10.Ажлын албанаас хурлын тэмдэглэлийг хэлэлцсэн асуудал бүрээр хураангуй хэлбэрээр гаргаж, зөвлөлийн гишүүдийн хүсэлтийн дагуу холбогдох байгууллагад хүргүүлж болно.

3.11.Зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилт, үр дүнг Ажлын алба ээлжит хурлаар танилцуулна.

3.12.Хурлын тэмдэглэл, хурлаар хэлэлцсэн асуудалтай холбогдох баримт бичгийг Ажлын алба хадгалах бөгөөд гишүүдийн хүсэлтийн дагуу танилцуулж болно.

3.13.Хурлын тэмдэглэлд тухайн хурлаар хэлэлцсэн асуудлын жагсаалт, холбогдох баримт бичгийг хавсаргана.

3.14.Зөвлөлийн гишүүд хурлаар асуудал хэлэлцүүлэх бол ажлын албанд саналаа ажлын дөрвөөс доошгүй хоногийн өмнө ирүүлнэ.

Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагаа

4.1.Зөвлөл нь Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, стратеги бүхий Хөтөлбөрийн төслийг боловсруулна.

4.2.Энэ журмын 4.1-д заасан төсөлд Зөвлөлийн бүрэлдэхүүнд хамаарах байгууллагаас ирүүлсэн саналыг тусгах ажлыг Ажлын алба зохион байгуулна.

4.3.Зөвлөлийн даргаар дамжуулан хөтөлбөрийн төслийг Засгийн газарт хүргүүлж, батлуулах арга хэмжээг авна.

4.4.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

4.5.Зөвлөл нь Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, түүний биелэлтийг үнэлэх, дараагийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.

4.6.Хөтөлбөрийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн хөтөлбөрийг шинэчлэн батална.

4.7.Хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг зөвлөл жил бүр дүгнэж, Засгийн газарт хүргүүлнэ.

4.8.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаарх шийдвэрийг хурлаар хэлэлцэн гаргана.

4.9.Зөвлөл нь Хөтөлбөрийг боловсруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч болно:

4.9.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг Улсын Их Хурал болон Засгийн газарт хүргүүлэх;

4.9.2.Хөтөлбөрийг боловсруулахтай холбогдуулан баримт бичиг, мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах.

4.10.Зөвлөл нь Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч болно:

4.10.1.Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэх харилцан үнэлгээний техникийн хэрэгжилт, хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.10.2.Монгол Улсад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

4.10.3.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлан, тайлбарыг Хамтын ажиллагааны зөвлөл, холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулах, тэдгээрт санал, зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд баримт, бичгийг англи хэл дээр гаргуулан авах.

4.11.Зөвлөл нь Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ:

4.11.1.Зөвлөлийн хурлыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулах, хурлаас гарсан шийдвэрийн гүйцэтгэлд хяналт тавих;

4.11.2.Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ), Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг болон бусад эрх бүхий олон улсын

байгууллагын өмнө хүлээсэн үүргийн дагуу хамтран ажиллах, мэдээ, тайланг гаргахтай холбогдох асуудлыг яаралтай шийдвэрлэх.

4.12.Зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох баримт бичигтэй танилцах эрх бүхий этгээд нууцлалыг чандлан хадгална.

Тав.Бусад

5.1.Энэ журамд өөрчлөлт оруулах саналыг зөвлөлийн бүрэлдэхүүнээс ажлын албанд хүргүүлэн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

---oOo---

ХАВСРАЛТ 2. САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА (ФАТФ)-ЫН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ 40 ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИК ХЭРЭГЖИЛТИЙН ДУТАГДЛЫГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАТЛАВ.

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БӨГӨӨД
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД



Ц.НЯМДОРЖ

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр

**САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА (ФАТФ)-ЫН МӨНГӨ УГААХ
БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ 40 ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИК
ХЭРЭГЖИЛТИЙН ДУТАГДЛЫГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

I. Техникийн хэрэгжилтийн үнэлгээг сайжруулах хүрээнд хийгдэх ажлууд					
№	Холбогдох зөвлөмж	Хийгдэх ажил	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа
1	Зөвлөмж 1	1. Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг эцэслэж, хэвлэх	Сангийн яам, Санхүүгийн мэдээллийн алба	Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
		2. Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүн болон бусад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулахтай холбоотой ажлыг тусгасан үндэсний стратеги төлөвлөгөөг батлуулах	Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн мэдээллийн алба	Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
		3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх урьдчилан сэргийлэх журмыг шинэчлэн батлуулах	Монголбанк	Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Тагнуулын ерөнхий газар	2020 он
2	Зөвлөмж 8	1. Ашгийн бус байгууллагын тухай хуулийн төслийг батлуулах	Хууль зүй, дотоод хэргийн яам	Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар,	2020 он

				Улсын бүртгэлийн ерөнхий газар	2020 он УХА0577 9131517 1115126371
		2. Ашгийн бус байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх	Хууль зүй, дотоод хэргийн яам	Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар	
		3. Соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах	Терроризмтэй тэмцэх зөвлөлийн Ажлын алба	Хууль зүй, дотоод хэргийн яам, Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар	2020 он
		4. Хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, хяналт шалгалтын арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх	Терроризмтэй тэмцэх зөвлөлийн Ажлын алба	Хууль зүй, дотоод хэргийн яам, Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар	2020 он
		5. Холбогдох төрийн байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах	Терроризмтэй тэмцэх зөвлөлийн Ажлын алба, Хууль зүй, дотоод хэргийн яам	Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар	2020 он
		6. Ашгийн бус байгууллагатай холбоотой мөрдөн шалгах ажиллагааны чадамжийг сайжруулах арга хэмжээг авах	Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар	Хууль зүй, дотоод хэргийн яам, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар	2020 он
3	Зөвлөмж 15	1. Виртуал хөрөнгийн үйлчилгээнээс үүсэх эрсдэлийг тодорхойлох	Монголбанк	Санхүүгийн зохицуулах хороо, Хамтын	2020 он

				ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	
		2. Ажлын хэсгийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээг дэмжих	Монголбанк	Санхүүгийн зохицуулах хороо, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он УХА0577 9131317 1116126371
		3. Хууль эрх зүйн орчныг бий болгох	Монголбанк	Санхүүгийн зохицуулах хороо, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
		4. Хяналт шалгалтын тогтолцоог бий болгох	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
		5. Шаардлагатай техник туслалцааг шийдвэрлэх	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
		6. Виртуал хөрөнгийн зохицуулалтыг цогцоор нь хийх	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
		7. Бусад шалгууртай холбоотой зохицуулалтыг бий болгох	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 – 2021 он

Техник хэрэгжилтийн үнэлгээтэй холбоотой хийгдэх шаардлагатай ажлууд						
№	Холбогдох зөвлөмж	Хийгдэх ажил	Зөвлөмжийн шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа
1	Зөвлөмж 1	Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэхэд эрсдэл бага байхтай	Шалгуур 1.6, 1.8, 1.12	Сангийн яам, Санхүүгийн мэдээллийн алба	Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он

		холбоотой үед авах арга хэмжээг тодорхой болгох				
2	Зөвлөмж 4	Хөрөнгө хураах болон холбогдох бусад арга хэмжээ	Шалгуур 4.1-4.4	Сангийн яам	Хууль зүй, дотоод хэргийн яам, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
3	Зөвлөмж 14	Хууль бус, зөвшөөрөлгүй мөнгөн болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээг илрүүлж, бүртгэлжүүлэх, шийтгэх тогтолцоог бий болгох	Шалгуур 14.2	Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголбанк	Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар	2020 он
5	Зөвлөмж 22	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч харилцагчийг таньж мэдэх (Улс төрд нөлөө бүхий этгээдийн тодорхойлолтыг стандартад нийцүүлэх)	Шалгуур 22.3	Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо	Хуульчдийн холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Нотариатчдын танхим, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
6	Зөвлөмж 24	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон тод байдалтай холбоотой эрсдэлийн үнэлгээг хийх, гадаад хамтын ажиллагааг сайжруулах	Шалгуур 24.2, 24.15	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
7	Зөвлөмж 25	Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгчтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох	Шалгуур 25.1	Хууль зүй, дотоод хэргийн яам	Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
8	Зөвлөмж 26	Санхүүгийн байгууллагуудын зохицуулалт, хяналт шалгалтын шалгуурт	Шалгуур 26.3, 26.4, 26.5, 26.6, Шалгуур	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн	2020 он

		нийцүүлэх, Виртуал хөрөнгөтэй хяналт холбоотой шалгалтын зохицуулалтыг бий болгох	26-д Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчи йг хамруула х		байгууллагууд	
9	Зөвлөмж 27	Хянан шалгагчдын эрх мэдэл хэсэг дэх Виртуал хөрөнгөтэй холбоотой зохицуулалтыг бий болгох	Шалгуур 27-д Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчи йг хамруула х	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
10	Зөвлөмж 28	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийн зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах	Шалгуур 28.2-5	Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо	Хуульчдийн холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Нотариатчдын танхим, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд	2020 он
11	Зөвлөмж 33	Статистик гаргах маягтын дагуу шалгуурт заасан мэдээллийг тогтмол гаргадаг болох	Шалгуур 33.1	Улсын ерөнхий прокурорын газар	Тэгнүүлэн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөл	2020 он
12	Зөвлөмж 34	Зааварчилгаа эргэх холбоо	Шалгуур 34.1	Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд		2020 он



ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН ФАТФ-ЫН ТЕХНИК ХЭРЭГЖИЛТИЙН БОЛОН ҮР ДҮНТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЦАГ ХУГАЦААНЫ МАТРИЦ (2007-2020)

C	Бүрэн биелүүлсэн
LC	Дийлэнхийг биелүүлсэн
PC	Хэсэгчлэн биелүүлсэн
NC	Биелүүлээгүй
NA	Үнэлээгүй

Хуучин	Шинэ	ЗӨВЛӨМЖ	40+9									40+11					
			2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	
		Тайлангийн төрөл	Харицан үнэлгээний тайлан							Ахицын тайлан				Харицан үнэлгээний тайлан		2 дахь явцын тайлан	3 дахь явцын тайлан
-	1	Эрсдэлээ үнэлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	PC	PC	PC	PC
31	2	Үндэсний хамтын ажиллагаа болон уялдаа холбоо	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC
1&2	3	Мөнгө угаах гэмт хэрэг	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC	LC	LC
3	4	Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC	LC	LC
II	5	Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC	LC	LC
III	6	Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	PC	LC	LC

-	7	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NC	NC	NC	LC	LC
VIII	8	Ашгийн бус байгууллага	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC
4	9	Санхүүгийн байгууллагын нууцлалын хууль тогтоомж	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC
5	10	Харилцагчийг таньж мэдэх	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC	LC	LC
10	11	Баримт материал хадгалах	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	C	C	C	C	C
6	12	Улс төрд нөлөө бүхий этгээд	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC	LC	LC
7	13	Корреспондент банкны үйл ажиллагаа	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC	LC	LC
VI	14	Мөнгө, үнэ цэнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC	PC	PC	PC	PC
8	15	Шинэ технологи	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC	LC	PC
VII	16	Цахим шилжүүлэг	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC	LC	LC
9	17	Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	NC	NC	NC	LC	LC
15&22	18	Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC	LC	LC	LC
21	19	Өндөр эрсдэлтэй улс орнууд	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC
13&IV	20	Сэжигтэй гүйлгээг мэдээлэх	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC	LC	LC	LC

14	21	Мэдээллийг задруулах болон нууцлал	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	C	C
12	22	СББМҮҮ: Харилцагчийг таньж мэдэх	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC
16	23	СББМҮҮ: Бусад арга хэмжээ	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	LC	LC
33	24	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC
34	25	Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC
23	26	Санхүүгийн байгууллагын зохицуулалт, хяналт шалгалт	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC
29	27	Хянан шалгагчийн эрх мэдэл	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC
24	28	СББМҮҮ-ийн зохицуулалт, хянан шалгалт	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC	LC
26	29	Санхүүгийн мэдээллийн алба	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC	C	C
27	30	Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын үүрэг	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	C	C	C
28	31	Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын эрх мэдэл	C	C	C	C	C	C	C	C	C	C	C	C	C	C	C	C	C	C	C
IX	32	Бэлэн мөнгө зөөвөрлөгчид	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC	LC
32	33	Статистик мэдээлэл	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC	LC	LC

25	34	Зааварчилгаа, эргэх холбоо	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	NC	PC	PC	LC	LC
17	35	Шийтгэлийн арга хэмжээ	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC
35&I	36	Олон улсын арга хэрэгслүүд	PC+NC	PC+NC	PC+NC	PC+NC	PC+NC	NC	NC	LC	LC	C	C	C	C
36&V	37	Эрх зүйн харилцан туслалцаа	LC+PC	LC+PC	LC+PC	LC+PC	LC+PC	PC	PC	LC	LC	C	C	C	C
38	38	Эрх зүйн харилцан туслалцаа: хөрөнгө царцаах, хураах	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC
39	39	Гэмт хэрэгтэн шилжүүлэх	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC	LC
40	40	Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	PC	LC

ХАВСРАЛТ 4. АНГЛИ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Товчлол	Нэр томьёо	Товчлол	Нэр томьёо
/Англи/	/Англи/	/Монгол/	/Монгол/
AML/CFT	Anti-money laundering/ countering financing of terrorism	МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
APJG	Asia Pacific Joint Group	АНДХБ	Ази, Номхон далайн хамтарсан бүлэг
APG	Asian Pacific group on Money Laundering	АНДМУТБ	Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг
BNI	Bearer negotiable instrument	ШТХ	Шилжих төлбөрийн хэрэгсэл
CC	Cooperation council	ХАЗ	Хамтын ажиллагааны зөвлөл
CFT	Countering financing of terrorism	ТСТ	Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
DNFBP	Designated non-financial business providers	СББМҮҮ	Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч
EAG	Euro-Asia group	ЕАМУТБ	Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг
FSRB	FATF-style regional bodies	ФТБНБ	ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллага
FATF	Financial action task force	ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
FIU	Financial information unit	СМА	Санхүүгийн мэдээллийн алба
FUR	Follow-up report		Явцын тайлан
IO	Immediate outcomes	ШХ	Шууд хэрэгжилт
ICRG	International cooperation review group	ОУХАХБ	Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг
MER	Mutual evaluation report	ХҮТ	Харилцан үнэлгээний тайлан
NC	National council	ҮЗ	Үндэсний зөвлөл
PEP	Politically exposed person	УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
POPR	Post observation period report		Ажиглалтын дараах тайлан
	Progress report		Ахицын тайлан
RBA	Risk based approach	ЭСА	Эрсдэлд суурилсан аргачлал
VASP	Virtual asset service provider	ВХҮҮ	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч



Бага тойруу-3, 15160
Улаанбаатар-46, Монгол Улс
976-11-326161, 976-11-326803
fiuforpublic@mongolbank.mn
www.fiu.mongolbank.mn